



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



Empowered lives.
Resilient nations.

**МОНГОЛ УЛСЫН ДУНД ХУГАЦААНЫ
(2020-2025) ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ
(Тайлан III)**

Улаанбаатар хот
2018 он



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



Empowered lives.
Resilient nations.

МОНГОЛ УЛСЫН ДУНД ХУГАЦААНЫ (2020-2025) ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ (Тайлан III)

Улаанбаатар хот
2018 он

АЖЛЫН БАГ

Судалгааг удирдан зохион байгуулагчид

Б.Баярсайхан, Үндэсний хөгжлийн газрын дарга, Докторант
Ж.Должинсүрэн, Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн газрын дарга, Докторант
С.Сюзанна, Х.Онон, Э.Тодмэргэн, Л.Амарбаясгалан, Д.Эрхэмбаяр, Үндэсний
хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтнүүд

Судлаачид

ШУ-ны доктор А.Даваасүрэн (Багийн ахлагч)
Доктор Б.Батмөнх
Доктор О.Бат-Эрдэнэ
Магистр Д.Лхагвадорж

Хянан тохиолдуулагч Доктор Б.Батхишиг

Энэхүү судалгааны ажлыг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн техникийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэв.

Үндэсний хөгжлийн газрын судалгааны ажлууд нь хөгжлийн бодлогын чиглэлээр тулгамдаж буй чухал асуудлуудыг хөндлөнгийн судалгаан дээр тулгуурлан хөнддөг тул судалгааны санал, дүгнэлт нь тус газрын албан ёсны байр суурийг зайлшгүй илэрхийлэх албагүй болно.

Илтгэлийг ашгийн бус зорилгоор хуулбарлах, олшруулж тараахыг зөвшөөрнө.

ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо, түүний өнөөгийн байдал болон алдаа дутагдал, цаашдын сургамжийн талаар, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдааг үнэлэх, бодлогын тэргүүлэх чиглэл, үзүүлэлтийн хүрэх түвшинг тодорхойлох, төлөвлөлтийн арга зүй, мөн түүнчлэн 2020-2025 оны дунд хугацааны хөгжлийн хүрээ зэргийг тодорхойлсон таван боть тайланг та бүхэнд толилуулж байгаадаа таатай байна.

Өнгөрсөн хугацаанд, Монгол Улс зах зээлийн шилжилтийг туулж, ардчилсан тогтолцоог нутагшуулсан 28 жилийн хугацаанд эдийн засаг өсч, хөгжлийн тодорхой хэд хэдэн үзүүлэлтүүдээрээ дэлхийн дундаж

түвшний хөгжилтэй орнуудын тоонд багтаж, уул уурхай, газар тариалан, барилга, худалдаа үйлчилгээний салбарт тодорхой ахиц дэвшилд хүрсэн боловч эдийн засгийн төрөлжилт, үйлдвэржилт, засаглал, дэд бүтэц, байгаль орчин, боловсрол, эрүүл мэнд зэрэг олон салбарын хөгжилд бэрхшээлүүд тулгарсан хэвээр байгаа билээ.

1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоог халснаас хойш урт хугацааны хөгжлийн хэд хэдэн стратегийг боловсруулж байсан бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэх бодлого хөтөлбөрүүд нь бодит байдалтай нийцгүй, залгамж чанаргүй, төсөвтэй уялдаагүй байсаар иржээ. Үүний зэрэгцээ дөрвөн жил тутам зохион байгуулагддаг сонгуулийн циклийг даган Засгийн газрын үйл ажиллагааны бодлого, чиглэл ойр ойрхон өөрчлөгддөг, мөн бодлогын баримт бичгүүд хэт олширсон тэдгээрийн хоорондын уялдаа хангагддаггүй зэргээс үүдэн хөгжлийн бодлогын баримт бичгүүд үр дүнтэй хэрэгжээгүй байна.

Үүний улмаас, Монгол Улсын хөгжил тогтворгүй, эмзэг, баялгийн тэгш бус хуваарилалт нэмэгдсэн, иргэдийн төрд итгэх итгэл суларсан, нийтээрээ хөгжлийн талаарх нэгдсэн ойлголтгүй болсон гэх мэт олон сөрөг үр дагаврууд бий болжээ. Энэ бүх хугацаанд хөгжлийн талаарх олон баримт бичиг, бодлогууд боловсруулж батлуулсан боловч нийгэмд нийтээрээ хүлээн зөвшөөрөгдөхүйц бодит өөрчлөлт, үр дүнд хүрэхгүй байгаа нь улсын тогтвортой хөгжлийн нэгдсэн ойлголт, бодлого, зохицуулалт, түүнийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, хариуцлага тооцох механизм, хууль эрх зүйн орчин дутагдалтай байсны илрэл юм.

Үүний мөрөөр, Үндэсний хөгжлийн газар (ҮХГ)-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)-ийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын өнөөгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог шинэчлэх, шинжлэх ухаан, тооцоо судалгаанд үндэслэн харилцан уялдаа бүхий бодлого, стратеги боловсруулдаг байх, түүнд чиглэсэн чадавхыг сайжруулах

зорилгоор энэхүү таван боть тайланг боловсрууллаа. Энэхүү тайланд судалсан арга зүйг Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго (ДТХЗ)-уудыг хэрэгжүүлэхэд хэрэглэж буй олон улсын сайн туршлагад үндэслэн манай орны салбар бүрийн төрийн болон төрийн бус байгууллагын, мэргэжлийн судлаачдын олон талын төлөөллийн үнэтэй санал, зөвлөмжийг тусган боловсруулсан. Энэхүү тайланд тусгагдсан арга зүй, санал зөвлөмжүүдийн дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чадавхыг бэхжүүлэх ажлууд үргэлжлэн хийгдэх бөгөөд цаашид Монгол Улсад цэгцтэй, уялдаатай, залгамж чанар бүхий бодлого, хөтөлбөр, механизмуудтай, харилцан уялдаа бүхий зохицуулалттай төрийн институцтэй, зах зээлийн эдийн засагт нийцсэн төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх бидний хүчин чармайлт биелэлээ олно гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү таван боть тайланг боловсруулах ажлыг гүйцэтгэхэд мэргэжлийн удирдлагаар ханган бүх талаар дэмжин ажилласан ҮХГ-ын дарга Б.Баярсайхан танд гүн талархлаа илэрхийлье. Мөн түүнчлэн, тайланг боловсруулахад нөр их хөдөлмөр, хичээл зүтгэл гаргаж ажилласан судлаачдын баг болон тайланг боловсруулахад бүхий л талаар оролцон хөдөлмөр зүтгэлээ гаргасан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтнүүд болох С.Сюзанна, Х.Онон, Э.Тодмэргэн, Л.Амарбаясгалан, Д.Эрхэмбаяр, Р.Сийлэн нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье. Түүнчлэн, манай улсын хөгжлийн төлөвлөлтийг сайжруулахад үнэ цэнэтэй дэмжлэг туслалцаа өгч, хамтран ажилласан Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Монгол дахь суурин зохицуулагч, НҮБХХ-ийн суурин төлөөлөгч хадагтай Беате Транкманн, НҮБХХ-ийн орлогч суурин төлөөлөгч хадагтай Даниела Гаспарикова болон НҮБХХ-ийн хамт олонд гүн талархлаа илэрхийлье.

Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Жамбалын Должинсүрэн

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УДИРТГАЛ

БҮЛЭГ 1. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, МУТХҮБ-2030-ЫН ХҮРЭХ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛСОН АРГА ЗҮЙ

1.1. Хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон арга зүй 1

1.2. МУТХҮБ-2030 -ын хүрэх түвшинг тодорхойлсон арга зүй 2

БҮЛЭГ 2. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, МУТХҮБ-2030-ЫН ХҮРЭХ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛСОН АРГА ЗҮЙГ ТУРШСАН БАЙДАЛ БА ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮН 5

БҮЛЭГ 3. САЛБАРУУДЫН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН ЗОРИЛТУУДЫН НЭГДСЭН ХҮРЭЭ БА НИЙТЛЭГ АСУУДЛУУД 15

БҮЛЭГ 4. ДУНД ХУГАЦААНЫ (2020-2025) ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

4.1. Макро эдийн засгийн бодлогын тэргүүлэх чиглэлүүд 19

4.2. Эдийн засгийн салбаруудын тогтвортой хөгжлийн дунд хугацааны бодлогын тэргүүлэх чиглэлүүд 20

4.2.1. Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд 20

4.2.2. Газар тариалангийн салбарын тогтвортой хөгжлийн бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд 22

4.2.3. Уул уурхай, олборлох, хүнд үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд 24

4.2.4. Хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд 27

4.2.4.1. Арьс ширний салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд 28

4.2.4.2. Ноос, ноосон эдлэл, ноосон үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд 29

4.2.4.3. Ноолуур, ноолууран эдлэл, ноолууран нэхмэлийн үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд 30

4.2.4.4. Оёдол, хувцас үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	31
4.2.4.5. Ой мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	31
4.2.4.6. Хүнсний үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	33
4.2.4.7. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	34
4.2.4.8. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	35
4.2.4.9. Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	35
4.2.4.10. Ус, ундаа, жүүс, исэлтийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	36
4.2.4.11. Хоол, нийтийн хоолны салбар, хоол үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	37
4.2.4.12. Бусад хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл (Хүнсний ногоо, хүнсний ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбар, зөгийн бал, жимс жимсгэний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, амттан чихэр, шоколад, чипс гэх мэт), бүх төрлийн будаа, элсэн чихэр болон импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	38
4.2.5. Эрчим хүчний салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	38
4.2.6. Барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	40
4.2.7. Барилгын салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	41
4.2.8. Худалдаа үйлчилгээ, дэд бүтцийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	41
4.2.9. Аялал жуулчлалын салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	42
4.2.10. Хот байгуулалтын салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	43
4.2.11. Агаарын тээврийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	43
4.2.12. Төмөр замын тээврийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	44
4.2.13. Авто тээврийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	45

4.2.14. Авто замын байгууламжийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	45
4.2.15. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	46
4.3. Нийгмийн тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	46
4.3.1. Хүн ам, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	46
4.3.2. Хөдөлмөр эрхлэлтийн талаарх дунд хугацааны бодлогын тэргүүлэх чиглэлүүд	47
4.3.3. Боловсрол, соёл, урлаг, биеийн тамир, спортын салбарын бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	48
4.3.4. Шинжлэх ухаан, инновацийн тогтвортой хөгжлийн дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлүүд	52
4.3.5. Эрүүл мэндийн салбарын бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	53
4.3.6. Нийгмийн даатгал, халамжийн бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	55
4.3.7. Хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын талаарх дунд хугацааны бодлогын тэргүүлэх чиглэлүүд	55
4.4. Байгаль орчны тогтвортой хөгжлийн дунд хугацааны бодлогын тэргүүлэх чиглэлүүд	55
4.4.1. Усны нөөцийн хамгаалалт, нөхөн сэргээлт ба зохистой ашиглалтын бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	55
4.4.2. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, эрсдэлийг бууруулах бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	57
4.4.3. Биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	60
4.5. Засаглалын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд	62
БҮЛЭГ 5. МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ	
БАРИМТЛАЛ-2030-ЫН ХҮРЭХ ТҮВШИН	65
НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖҮҮД	68
ХАВСРАЛТ	72
НОМ ЗҮЙ	110

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Бодлогын зорилтуудын уялдааг хянах матриц	1
Хүснэгт 2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хууль эрх зүйн актууд	6
Хүснэгт 3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх тэргүүлэх зорилго, зорилтууд	8
Хүснэгт 4. Харилцан нөлөөллийн онооны утга	9
Хүснэгт 5. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын бодлогын зорилтуудын өөр хоорондын болон МУТХҮБ-2030-тай уялдсан байдал, нөлөөллийн үнэлгээ ба эрэмбэ	10
Хүснэгт 6. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх зорилтуудыг хангах арга хэмжээнүүд	12
Хүснэгт 7. Салбаруудаас гарсан зорилтуудын давхардсан байдал	15
Хүснэгт 8. МУТХҮБ-2030-ын үндсэн 20 үзүүлэлтийн хүрэх түвшний төсөөлөл	65

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн уялдаа холбоо	2
Зураг 2. Салбарын хэлэлцүүлэг зохион байгуулсан үе шат	6

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. МУТХҮБ-2030-ын үндсэн үзүүлэлтээс гадна текстэд орсон 52 үзүүлэлтийн хүрэх түвшний төсөөлөл	72
Хавсралт 2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	74
Хавсралт 3. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	76
Хавсралт 4. Худалдааны салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	77
Хавсралт 5. Банкны салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	78
Хавсралт 6. Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	79
Хавсралт 7. Төрийн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	80
Хавсралт 8. Барилга угсралт, нийтийн орон сууцны дэд салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	81
Хавсралт 9. Барилга, хот байгуулалт, зураг төсөл төлөвлөлтийн дэд салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	83

Хавсралт 10. Барилгын материалын үйлдвэрлэлийн дэд салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	84
Хавсралт 11. Арьс ширний салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	85
Хавсралт 12. Ноос, ноосон эдлэл, ноосон үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	85
Хавсралт 13. Ноолуур, ноолууран эдлэл, ноолууран нэхмэлийн үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	87
Хавсралт 14. Оёдлын үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	88
Хавсралт 15. Ой мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	89
Хавсралт 16. Зам, тээвэр ложистикийн салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	90
Хавсралт 17. Зам, гүүр, замын байгууламжийн салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	91
Хавсралт 18. Төмөр зам, далайн тээврийн салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	93
Хавсралт 19. Авто салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийн эрэмбэ	94
Хавсралт 20. Эрчим хүчний салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	94
Хавсралт 21. Сургуулийн өмнөх боловсролын салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	95
Хавсралт 22. Ерөнхий боловсролын салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	96
Хавсралт 23. Дээд боловсрол болон мэргэжлийн боловсролын салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	98
Хавсралт 24. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	99
Хавсралт 25. Биеийн тамир, спортын салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	100
Хавсралт 26. Соёл, урлагийн салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	101
Хавсралт 27. Нийгмийн эрүүл мэндийн салбарын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	103
Хавсралт 28. Эмнэлэгийн тусламж, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	104
Хавсралт 29. Эрүүл мэндийн техник, технологийн салбарын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	106
Хавсралт 30. Эм зүйн тусламж, үйлчилгээний салбарын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ	107
Хавсралт 31. Хэлэлцүүлгүүд	108

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ДТХЗ - “Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго”
МУТХҮБ-2030 - “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”
НҮБ - Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ - Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
УИХ - Улсын Их Хурал
АИХ - Ардын Их Хурал
ДХБ - Дэлхийн худалдааны байгууллага
ТББ - Төрийн бус байгууллага
УУХҮЯ - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
БСШУСЯ - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
АМГ - Ашигт малтмалын газар
ХНХЯ - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ТӨК - Төрийн өмчит компани
ТМХХТББ - “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого” (2017-2025)
ҮХТ - Үндэсний хөгжлийн төлөвлөгөө
ТЭЗҮ - Техник эдийн засгийн үндэслэл
ДЦС - Дулааны цахилгаан станц
НӨАТ - Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОСНААҮ - Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ
МАХН - Монгол Ардын Хувьсгалт нам
ҮХАБ - Үндэсний хөгжлийн алсын хараат бодлого
ЭЗШЗ - Эдийн засгийн шинэ загвар
ДНБ - Дотоодын нийт бүтээгдэхүүн
ҮХГ - Үндэсний хөгжлийн газар
ТЭБСББ - “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого” (2014-2025)
ТОТББ - “Төрөөс ойн талаар баримтлах бодлого” (2015-2030)
ТБТББ - “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” (2014-2024)
ТШУТББ - “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого” (2017-2025)
ТХХААтББ - “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” (2015-2025)
ТЭХтББ - “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого” (2015-2030)
ТТЗТтББ - “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого” (2010)
ТХАХтББ - “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого” (2016-2025)
БТСХтББ - “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого” (2009)
ТИтББ - “Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого” (2018-2025)
ТЭМтББ - “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” (2017-2026)
УАӨҮХ - Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (2011-2021)
БОЯБҮХ - Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015-2025)
АТҮХ - Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2016-2023)

УДИРТГАЛ

2015 оны 9 дүгээр сард 193 орон оролцсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн дээд чуулган 2015-2030 оны ДТХЗ-уудыг 17 зорилго, 169 зорилт 244 шалгуур үзүүлэлттэйгээр баталсан.

2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хурал (УИХ) “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль” - ийг баталснаар Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгов.

Үүний дараа 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн УИХ-ын 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” (МУТХҮБ-2030)-ыг эдийн засаг, нийгэм, байгаль орчин, засаглал гэсэн 4 үндсэн чиглэлтэйгээр баталсан.

ДТХЗ-уудыг Монгол Улс өөрийн орны нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүргийг УИХ болон Засгийн газрын түвшний байгууллагууд хүлээсэн. Тухайлбал, УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дэргэд Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо байгуулагдан ажиллаж байгаа бол Засгийн газрын түвшинд Ерөнхий сайдын ахалсан Тогтвортой хөгжлийн үндэсний хороо ажиллаж байна.

Засгийн газрын түвшинд ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын урт, дунд хугацааны тусгал үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргийг Үндэсний хөгжлийн газар гүйцэтгэж байна. Өнөөгийн байдлаар энэхүү алсын харааг хэрэгжүүлэхэд Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн замын нэгдсэн зураглал байхгүй, урт болон дунд хугацааны бодлогын уялдаа хангагдаагүй, түүнийг хэрэгжүүлэх эдийн засаг, эрх зүйн болон захиргааны механизмууд бүрэн үйлчлэхгүй, улс орны хэмжээнд хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн бодлогыг зангидаж удирдан чиглүүлж, хянадаг институцийн эрх, үүрэг тодорхойгүй, улс орны хөгжлийн бодлогын залгамж, шинж чанар алдагдсан, хэт улс төржсөн, тэр нь эрх барьж байгаа намын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байгаа зэрэг дутагдлыг засах шаардлагатай байна.

Иймд, ҮХГ нь НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр ДТХЗ-уудыг МУТХҮБ, хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах, тэдгээрийн хоорондын нөлөөллийн үнэлгээ хийх, салбарын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох ажлыг зохион байгуулж байна.

Энэхүү үнэлгээг хийхдээ Швед Улсын Стокгольмын байгаль орчны хүрээлэнгийн судлаачдын боловсруулсан аргачлалыг ашигласан болно. Уг аргачлалын дагуу МУТХҮБ-2030-д заасан зорилтуудтай нийцүүлэн Монгол Улсын хөгжлийн 2020-2025 он хүртэлх дунд хугацаанд хэрэгжүүлэх макро түвшний болон салбарын бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрэх түвшинг тодорхойлох, дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөний үндсэн загвар боловсруулах ажлыг гүйцэтгэж байгаа юм.

2020-2025 он хүртэлх дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлохдоо салбарын яам, агентлагууд, мэргэжлийн холбоод, бизнесийн байгууллага, шинжлэх ухааны болон олон нийтийн байгууллагуудын төлөөллийг оролцуулсан болно. Тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход дээрх төлөөллийн оролцоог хангах зорилгоор салбарын цуврал хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан бөгөөд эдгээр хэлэлцүүлгүүдийг хийхдээ дараах эх сурвалжийг ашигласан. Үүнд:

1. Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгууд;
2. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030;
3. Төрөөс салбарын талаар баримтлах бодлогууд гэх мэт.

Ингэхдээ, бид салбарын өмнө тулгамдсан гол хүндрэл бэрхшээлтэй асуудлуудыг тодорхойлж, улмаар бодлогын шинэ зорилтуудыг томъёолсны дараагаар тэдгээрээс хамгийн чухал гэж эрэмбэлсэн 5-6 гол зорилтыг тэргүүлэх чиглэлд сонгон авсан.

Салбаруудын өмнө хамгийн их нийтлэг тулгамдсан асуудалд “хууль, эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус, хоорондоо зөрчилтэй”, “төрийн бодлогын тогтвортой залгамж чанар алдагдаж, засаглалын хомсдолд орсон”, “төр засгийн институцийн оновчтой бүтэц алдагдсан” гэх зэрэг асуудал орж байгаа нь үндэсний хөгжлийн шинэ загварыг боловсруулж, хэрэгжүүлэх, төрийн хөгжлийн бодлогын залгамж чанарыг сайжруулах, төрийн удирдлагын мэргэжсэн, оновчтой бүтцийг бүрдүүлэх явдал нэн чухал болохыг харуулж байна.

Нөгөө талаас одоо хүчин төгөлдөр хэрэгжүүлж байгаа бодлогын баримт бичгүүдэд заасан зорилтууд нь өөр хоорондоо уялдаагүй, хэрэгжүүлэх цаг хугацааны хувьд өөр өөр, улсын хэмжээнд нэгдсэн уялдаа, зохицуулалт байхгүй зэрэг дутагдал ажиглагдав.

БҮЛЭГ 1. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, МУТХҮБ- 2030-ЫН ХҮРЭХ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛСОН АРГА ЗҮЙ

1.1. Хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон арга зүй

Хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлохдоо дунд хугацааны бодлогын тэргүүлэх чиглэлийг цоо шинээр томъёолох бус, харин түүнийг нэгэнт УИХ-аас баталсан хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг болох МУТХҮБ-2030 болон салбаруудын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогуудад тулгуурлан тодорхойлох нь зайлшгүй гэсэн зарчмыг баримтлав. Үүний зэрэгцээ гол салбарын яам, агентлагуудын мэргэжилтнүүдийг оролцуулан салбарын хөгжлийн тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг явуулж, тэдгээрийг шийдвэрлэх бодлогын зорилтуудыг шинээр тодорхойлж, ач холбогдлоор нь эрэмбэлэн тогтоосон. Эдгээр зорилтоос эхний 5-6 эрэмбийн зорилтуудыг дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлд сонгон авав.

МУТХҮБ-2030-д тусгагдсан 2030 он хүртэл хөгжлийн бодлогын гол зорилтуудаас 2020-2025 онд хэрэгжүүлэх хэсгийг тэргүүлэх чиглэлд сонгон авсан болно. Харин салбаруудын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогууд нь цаг хугацааны хувьд ихэвчлэн МУТХҮБ-2030 батлагдсан 2016 оноос өмнө гарсан тул МУТХҮБ-2030-тай төдийлөн уялдаагүй байв. Иймд, салбаруудын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогуудаас МУТХҮБ-2030-тай шууд болон агуулгын хувьд уялдсан бодлогын зорилтуудыг матрицын аргаар сонгон тодорхойлсон.

Бодлогын уялдааг шинжлэхэд ашиглах үндсэн шалгуур нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд дэвшүүлсэн бодлогын зорилго, зорилтууд юм. МУТХҮБ-2030-ын бодлогын зорилтууд болон салбаруудын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогын зорилтууд хоорондоо хэрхэн уялдсан байдлыг тогтоохдоо доорх загвар матрицыг ашигласан.

Хүснэгт 1. Бодлогын зорилтуудын уялдааг хянах матриц


МУТХҮБ-2030-ын бодлогын зорилтууд	Салбаруудын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогын зорилтууд	1-шууд тусгагдсан 2-агуулгын хувьд уялдсан 3-огт тусгагдаагүй
-----------------------------------	---	---

Сүүлийн баганад салбаруудын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогын зорилтууд МУТХҮБ-2030-ын бодлогын зорилтуудтай хэрхэн уялдаж байгааг 1-шууд тусгагдсан, 2-агуулгын хувьд уялдсан, 3-огт тусгагдаагүй гэсэн 3 ангиллаар үнэлж дүгнэсэн. Шууд тусгагдсан гэдэг үнэлгээг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан бодлогын зорилтын агуулга яг давхцаж байгаа тохиолдолд өгнө. Агуулгын хувьд уялдсан гэдэгт зорилтын агуулгын зарим хэсгүүд тусгагдсан, эсвэл арай өөр хэлбэрээр илэрхийлсэн боловч агуулгын хувьд нийцсэн зорилтуудыг хамруулна.

Энд салбаруудын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогын зорилтуудаас 1 болон 2 гэсэн үнэлгээ авсан, өөрөөр хэлбэл, шууд тусгагдсан болон агуулгын хувьд уялдсан бодлогын зорилтуудыг дунд хугацааны салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэл болгон сонгон авсан. Учир нь 2020-2025 оны дунд хугацааны хөгжлийн бодлого нь МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх шаардлагатай билээ.

Дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн логик уялдааг доор харуулсан схемээр илэрхийлж болно.

Зураг 1. Дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн уялдаа холбоо



Эх сурвалж: ҮХГ-ын Судалгааны баг.

Алсын харааг хэрэгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөгжлийн бодлого нь хоёр түвшинд тодорхойлогдоно. Үүнд:

- Макро түвшний бодлогууд
- Салбарын хөгжлийн бодлогууд

Энэхүү хоёр түвшний бодлого нь хоорондоо нягт уялдаатай байхын зэрэгцээ салбарын бодлогууд нь макро түвшний бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстой. Макро болон салбарын бодлогуудыг олон улсын нийтлэг зарчмаар зорилго, зорилгыг дотор нь зорилтууд болгон задалсан доорх хэлбэрээр тодорхойлно.

1.2. МУТХҮБ-2030-ын хүрэх түвшинг тодорхойлсон арга зүй

Энэхүү төслийн 2 дахь шатны тайланд бид ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын үндсэн үзүүлэлтүүдийн завсрын онуудын хүрэх түвшинг тооцох арга зүйг авч үзсэн билээ. Энэхүү аргачлалаар ДТХЗ-ын хэрэгжилтийг үнэлэх боломжтой үзүүлэлтүүдийг манай орны хувьд 2020, 2025 болон 2030 он гэхэд ямар түвшинд хүргэхээр зорьж байгаатай холбон тодорхойлохыг тусгасан. Хэдийгээр, МУТХҮБ-2030-д тусгагдсан 70 гаруй үзүүлэлтийн хувьд 2030 он гэхэд хүрэх түвшинг тодорхойлсон боловч энэ нь ДТХЗ-ын бүх 169 зорилтыг үнэлэх бүх үзүүлэлтүүдийн 1/4 гаруй нь юм. Үүний зэрэгцээ МУТХҮБ-2030-д тусгагдсан 70 гаруй үзүүлэлтийн нэлээд нь ДТХЗ-ын хэрэгжилтийг үнэлэх үзүүлэлттэй нийцэхгүй тал байгаа. Хүрэх түвшинг тодорхойлох энэхүү арга зүй нь тодорхой үзүүлэлтийн хэтийн тооцооллын төрөлд хамаарах бөгөөд доорх үндсэн

зарчмаар хийгдэнэ.

1. Эхний ээлжинд өмнөх онуудын хувьд тоон мэдээлэлтэй үзүүлэлтийн хувьд олон жилийн (наад зах нь өмнөх 10 жилийн) өгөгдөлд шинжилгээ хийж, жилийн дундаж өсөлтийн хувийг тооцно.
2. Өмнөх онуудын жилийн дундаж өсөлтийн хувийг 3 хувилбараар (олон жилийн дунджаас доогуур, олон жилийн дундаж орчим, олон жилийн дунджаас дээгүүр) авч, суурь оноос эхлэн тооцоолно.
3. Өмнөх онуудын тоон мэдээлэл хангалттай байхгүй үзүүлэлтүүдийн хувьд байгаа хугацааны өөрчлөлтийн чиг хандлагыг харгалзан хүрэх түвшинг төсөөлнө.

МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөнд тусгах түвшинг тогтоох нь үндсэндээ дээрээс доош болон доороос дээш төлөвлөх буюу эцсийн хүрэх түвшингээсээ ухрааж, завсрын онуудын хүрэх түвшинг тодорхойлж, нөгөө талаасаа бодит нөхцөл байдлаас үндэслэн доороос нь тооцох аргуудын хослол юм. Үзүүлэлтүүдийн хүрэх түвшинг тооцох арга зүй нь үзүүлэлт бүрийн хувьд өөрийн онцлогтой, иймд өөр өөрөөр тооцох боломжтой. Гэхдээ нийтлэг тооцох арга зүй нь доорх 3 үндсэн үе шаттай хийгдэнэ. Үүнд:

I үе шат: Жилийн дундаж өсөлтийн хувийг ашиглан жил бүр жигд өсөлттэй нөхцөлд хүрэх түвшинг төсөөлөх

II үе шат: Шаардлагатай нэмэлт судалгаа, тооцоог хийх

III үе шат: Жигд өсөлтийн тооцоог бодит нөхцөлд аль болох тохируулан засварлах бөгөөд эцсийн шатанд төсөөллийг хийнэ.

БҮЛЭГ 2. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, МУТХҮБ-2030- ЫН ХҮРЭХ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛСОН АРГА ЗҮЙГ ТУРШСАН БАЙДАЛ БА ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮН

Монгол Улсын эдийн засгийн салбаруудын дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох аргыг ашиглахдаа хоёр зарчмыг удирдлага болгосон. Үүнд:

1. Дээрээс доош нь төлөвлөх (Top-down approach)
2. Доороос дээш нь төлөвлөх (Bottom-up approach)


Дээрээс доош төлөвлөх арга гэж дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохдоо урт хугацааны бодлогод тусгагдсан алсын хараа буюу хүрэх түвшинг харгалзан үзэж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох явдал юм.

Доороос дээш төлөвлөх зарчмаар дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлохдоо макро эдийн засгийн түвшинд болон салбаруудын дунд хугацааны бодлогын зорилтуудыг харгалзан үзэх ёстой. Ингэхдээ, салбаруудын мэргэжлийн хүмүүсийн оролцооны аргаар салбарын өмнө тулгамдсан шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлж, зорилтууд болгон хувиргасны дараа тэдгээрийн өөр хоорондын харилцан нөлөөлөл болон уг зорилтууд нь МУТХҮБ-2030-ын хэрэгжилтэд хэрхэн нөлөөлөхийг матрицын арга ашиглан оноогоор үнэлж, тэргүүлэх зорилтуудыг эрэмбэлэн дараах байдлаар тодорхойлсон.

Шведын Стокгольмын байгаль орчны хүрээлэнгийн эрдэмтдийн боловсруулсан ДТХЗ хоорондын харилцан нөлөөллийг матрицаар үнэлэх аргыг ашиглан Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын ажилтнууд “Гэрэгэ партнерс” компанийн зөвлөх багтай хамтран 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 2018 оны 7 дугаар сарын 6-ны өдрийг хүртэл Монгол Улсын эдийн засгийн 40 дэд салбарын өмнө тулгамдаж буй асуудлууд, зорилго, зорилтуудын өөр хоорондын харилцан нөлөөлөл болон уг зорилтуудын МУТХҮБ-2030-ын хэрэгжилтэд үзүүлэх нөлөөллийг эрэмбэлэн тодорхойлов. Ийнхүү салбаруудын хөгжлийн дунд хугацааны бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлохын тулд 13 салбарын 17 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Эдгээр хэлэлцүүлэгт төрийн яам, агентлаг, мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг өргөнөөр оролцуулав. Хэлэлцүүлгийг зохион байгуулахдаа тухайн салбарын тэргүүлэх зорилтуудын эрэмбийг дараах үе шатуудаар дамжуулан тодорхойлсныг доорх Зураг 1-ээс харна уу.

Зураг 2. Салбарын хэлэлцүүлэг зохион байгуулсан үе шат

Салбарын дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилтуудыг тодорхойлох дэс дараалал



Монгол Улсын эдийн засгийн гол салбарын мэргэжилтнүүдтэй хийсэн хэлэлцүүлгээс гарсан үр дүнгээс жишээ болгон уул уурхай, олборлох салбарт хийсэн хэлэлцүүлгийг сонгон авч энэхүү тайланд оруулж байна.

Уул уурхай, олборлох салбарт хэлэлцүүлэг хийхийн өмнө тухайн салбарын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль, эрх зүйн актууд, салбарын хөгжлийн бодлого, стратеги, УИХ-ын болон Засгийн газрын тогтоол, сайдын тушаал зэрэг бодлогын баримт бичгүүдийг судалсны үндсэн дээр салбарын зангилаа асуудлуудын хүрээг тодорхойлсон.

Хүснэгт 2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хууль эрх зүйн актууд

№	Эрх зүйн актууд	Батлагдсан он, сар, өдөр
1	Ашигт малтмалын тухай хууль	2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр
2	Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай хууль	2003 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн УИХ-ын 54 дүгээр тогтоол
3	Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого	2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн УИХ-ын 18 дугаар тогтоол
4	Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого	2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн УИХ-ын 62 дугаар тогтоол
5	Газрын хэвлийн тухай хууль	1988 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр

6	Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого	2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн УИХ-ын 34 дүгээр тогтоол
---	---	--

Хүснэгт 2-т заасан хууль эрх зүйн актуудын зарчим, үзэл санааг үндэс болгон уул уурхай, олборлох салбарын хэлэлцэх асуудлуудын хүрээг дараах 10 чиглэлээр багцлан томъёолсон. Үүнд:

1. Уул уурхай, олборлох салбарт хэрэгжүүлж байгаа төрийн бодлого, хууль, эрх зүй, дүрэм, журмын хэрэгжилт;
2. Уул уурхай, олборлох салбар дахь засаглалын тогтолцоо, институцийн удирдлага, бүтэц зохион байгуулалт, төр ба төрийн бус байгууллагуудын уялдаа;
3. Уул уурхай, олборлох салбар дахь санхүү, хөрөнгө оруулалтын асуудал;
4. Уул уурхай, олборлох салбарт ашиглаж буй техник, технологийн хүртээмж, хүчин чадлын ашиглалт;
5. Уул уурхай, олборлох салбарын бүтээгдэхүүний нэр төрөл, чанар, иж бүрдэл, стандарт, өрсөлдөх чадвар;
6. Уул уурхай, олборлох салбарын хүний нөөц, ажиллах хүчний хүрэлцээ, боловсон хүчний хөгжил, мэргэжлийн сургалт, ур чадварын хөгжүүлэлт;
7. Уул уурхай, олборлох салбарын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, инноваци, зохиогчийн эрхийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хамгаалах тогтолцоо;
8. Уул уурхай, олборлох салбарын байгаль орчны нөлөөлөл, бохирдлын асуудал (нөхөн сэргээлт, усны нөөц, экосистем гэх мэт);
9. Уул уурхай, олборлох салбар ба бусад салбарын хамтын ажиллагаа (эрчим хүч, зам тээвэр, худалдаа, аж үйлдвэр, худалдаа, боловсрол, эрүүл мэнд гэх мэт);
10. Уул уурхай, олборлох салбар дахь компанийн менежмент, засаглал гэх мэтээр багцалж өгсөн.

Хэлэлцүүлэгт оролцогсдод ДТХЗ-уудад заасан 17 зорилго, 169 зорилтын талаарх тодорхой ойлголтыг өгөхийн тулд ҮХГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ж.Должинсүрэн “Дэлхийн тогтвортой хөгжил-2030 хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах нь” сэдвээр илтгэл тавьж, оролцогсдод мэдээлэл өгсөн.

Үүний дараа хэлэлцүүлэгт оролцогсдыг 4 хэсэгт хувааж, хэсэг бүрийг ажил мэргэжлийн төлөөлөл бүрээс оролцуулан хольж бүрдүүлсэн бөгөөд тэд мэтгэлцээний аргаар санал бодлоо чөлөөтэй солилцож ярилцсаны үр дүнд нэгдмэл нэг байр суурьтай болж, асуудлаа томъёолох боломжтой болсон.

Ийнхүү уул уурхай, олборлох салбарын дараах 12 зорилго, зорилтуудыг оролцооны аргаар тодорхойлсон.

Хүснэгт 3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх тэргүүлэх зорилго, зорилтууд

Зорилго	Зорилтууд
1. Салбарын хөгжлийн бодлогыг нарийвчлан тодорхойлох, хууль, дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгох	<p>1.1. Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтыг нарийвчлан тодорхойлох, хууль, дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг чанд хангуулах</p> <p>1.2. Салбарын бодлогыг хэрэгжүүлэгч институцийн удирдлага, зохион байгуулалт, чиг үүргийг нарийвчлах, оновчтой механизмыг бүрдүүлж, сайн засаглалыг бий болгох (тайлан, шударга, ил тод, хариуцлагатай байх)</p> <p>1.3. Салбарын мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод үе шаттай бэлтгэх, давтан сургах, цалин хөлсний урамшууллын тогтолцоог бий болгох</p> <p>1.4. Ашигт малтмалын нөөцийн бүртгэл, хяналтын тогтолцоог сайжруулах, түүнийг ангилах болон ашигласны төлбөрийг тооцох арга, аргачлалыг боловсронгуй болгох, үндэсний гео мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх</p>
2. Уул уурхайн салбарын менежмент, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог олон улсын түвшинд хүргэх	<p>2.1. Хүн, амьтан, байгальд сөрөг нөлөөлөл багатай, орчин үеийн дэвшилтэт техник, технологи, инновацийг нэвтрүүлэх, ордын геологийн тогтоц болон нөөцийн онцлогт тохирсон оновчтой техник, технологийг ашиглах</p> <p>2.2. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын хариуцлагыг нэмэгдүүлэх, компанийн засаглалыг сайжруулах</p> <p>2.3. Уул уурхайн салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд бусад салбарын (боловсруулах салбар, эрчим хүч, зам тээвэр, барилга, хот байгуулалт) бодлоготой уялдуулж, судалгаа, төлөвлөлт, удирдлага зохицуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоог бий болгох</p> <p>2.4. Байгаль орчны бохирдолтыг зогсоох, уул уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн менежментийг сайжруулах, Байгаль орчны хуулийн хэрэгжилтийг хангуулах, хяналтыг сайжруулах</p>
3. Уул уурхайн салбарын дэд бүтцийн болон нийгмийн хариуцлагын тогтолцоог сайжруулах, хүртээмжийг дээшлүүлэх	<p>3.1. Хөрөнгө оруулагч, орон нутгийн иргэдийн хоорондын харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх, орлогыг зохистой хуваарилах</p> <p>3.2. Санхүү хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг сайжруулж, геологи, хайгуулын ажилд зарцуулах улсын төсвийн санхүүжилтийг жил бүр тогтвортой өсгөж, хайгуул, олборлолтын ажил гүйцэтгэхэд өмчийн хэлбэрээс үл хамааран хөрөнгө оруулагчдад ижил тэнцүү нөхцөл олгох</p>
4. Уул уурхайн ордуудын ашиглалтыг олон улсын түвшинд хүргэх, борлуулалтын зах зээлийг олшруулах	<p>4.1. Уул уурхайн салбарын бүтээгдэхүүн, түүхий эдийн борлуулалтын үнэ ханшийг олон улсын зах зээлийн түвшинд ойртуулах, ганц зах зээлийн хамаарлыг багасгах, түүний тоог олшруулах</p> <p>4.2. Стратегийн ордуудыг тээвэр, ложистикийн сүлжээтэй холбох, хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлэх</p>

Үүний дараа “Гэрэгэ партнерс” компанийн зөвлөх доктор Б.Батмөнх “Хөгжлийн бодлогын зорилтуудын уялдаа, нөлөөллийг оноогоор үнэлэх арга зүй” сэдвээр илтгэл тавьж, Шведийн Стокгольмын байгаль орчны хүрээлэнгийн эрдэмтдийн боловсруулсан ДТХЗ-уудын хоорондын харилцан нөлөөллийг энгийн матрицын аргаар шинжилж, оноогоор үнэлэн, тэргүүлэх зорилтуудыг тодорхойлдог аргачлалын талаар тайлбарлаж, түүнийг ашиглан Монгол Улсын макро эдийн засгийн болон салбаруудын зорилго, зорилтууд, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох тухай оролцогсдод зөвлөгөө өгөв.

Хэлэлцүүлэгт оролцогсдын томъёолсон 12 зорилтыг өөр хоорондоо болон МУТХҮБ-2030-ын зорилтуудад ямар нөлөө үзүүлэхийг харилцан нөлөөллийн матрицын аргаар дараах 7 оноогоор үнэлж, өндөр оноотой гарсан уул уурхай, олборлох салбарын хөгжлийн дунд хугацаанд тэргүүлэх зорилтуудыг тодорхойлсон.

Хүснэгт 4. Харилцан нөлөөллийн онооны утга

Оноо	Онооны утга агуулга
+3	Харьцуулж буй зорилтын хэрэгжилтэд шууд хүчтэй нөлөөтэй, шууд хүчтэй уялдаатай.
+2	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэхэд тус болно.
+1	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх нөхцөлийг яваандаа бүрдүүлнэ.
0	Эерэг болон сөрөг ямар нэг нөлөө үзүүлэхгүй.
-1	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх сонголтуудыг хязгаарлана.
-2	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлнө.
-3	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх боломжгүй болгоно, хүчтэй сөрөг нөлөөтэй.

Эх сурвалж: Nina Weitz, Hencik Carlsen, Mans Nisson Kristain Skanberg , *Toward systematic and contextual priority setting for implementation the 2030 Agenda, 2017.*

Ингэхдээ, матрицын мөрүүдэд байгаа зорилтууд нь баганад байгаа зорилтуудад нөлөөлөх нөлөөллийн хүчнээс хамаарч дээрх 7 онооноос аль тохирохыг нь тавьж салбарын бодлогын зорилтууд өөр хоорондоо болон МУТХҮБ-2030-тай уялдсан байдалд үнэлгээг өгч 2 матрицыг бөглөсөн. Өөрөөр хэлбэл, мөрүүдэд байгаа зорилтуудын хэрэгжилт нь баганад байгаа зорилтуудын хэрэгжилтэд ямар нөлөө үзүүлэхийг үнэлж, тэдгээрийн хоорондын уялдааг тодорхойлон бодлогын зорилтуудыг томъёолсон. Үүний дараа мөрүүдийн дүнг баруун гар талд нэгтгэн дүгнэнэ. Хамгийн өндөр оноотой мөрөнд тавигдсан бодлогын зорилт бусдадаа хүчтэй нөлөөтэй гэж үзэж, түүнийг тэргүүлэх зорилтод сонгоно. Дараа нь 2 матрицаас гарсан үр дүнг хооронд нь харьцуулж, салбарын бодлогын зорилтуудын өөр хоорондын нөлөөллийн үнэлгээг 60 хувь гэж, салбарын бодлогын зорилтуудын МУТХҮБ-2030-ын хэрэгжилтэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг 40 хувиар жигнэж, тэдгээрийн хувийн жинг жишиж үзээд уул уурхай, олборлох салбарын бодлогын зорилтуудыг эрэмбэлсэн.

Хүснэгт 5. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын бодлогын зорилтуудын өөр хоорондын болон МУТХҮБ-2030-тай уялдсан байдал, нөлөөллийн үнэлгээ ба эрэмбэ

№	Бодлогын зорилтууд	Салбарын хооронд		МУТХҮБ-2030		Нэгдсэн үр дүн	
		Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ
1	Салбарын хууль, дүрэм, журам, стандартыг шинээр бий болгох, хуулийн хэрэгжилтийг чанд хангуулах	20	II	41.5	I	32.9	I
2	Салбарын бодлогыг хэрэгжүүлэгч төрийн институцүүдийн удирдлага, зохион байгуулалт, чиг үүргийг нарийвчлах, оновчтой механизмыг бүрдүүлж, сайн засаглалыг бий болгох	21	I	40	III	32.4	II
3	Аж үйлдвэрийн салбарын зорилтуудыг үндэсний хөгжлийн стратеги, төлөвлөлтөд тусгах, зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд санхүү, татвар, зээл, төрийн болон орон нутгийн худалдан авалтаар дэмжих, оюуны өмч, патентыг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох	17.3	IV	38	V	29.7	III
4	Хүнд аж үйлдвэрийн инженер, техник ажилтныг гадаад, дотоодод үе шаттай бэлтгэх, давтан сургах, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг техник, технологийн хувьд шинэчлэх	12	IX	32	VII	24	VII
5	Ашигт малтмалын стратегийн ордуудыг монголчууд өөрсдөө ашиглаж, тэдгээрт тулгуурлан аж үйлдвэр, инновацийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн инкубатор, паркийг байгуулах ажлыг зохион байгуулах	17.5	III	36.5	VI	28.9	V
6	Өндөр бүтээмжтэй, байгаль орчинд ээлтэй техник, технологи нэвтрүүлэх, хяналт тавих, дүгнэлт зөвлөмж гаргах үүрэг бүхий аж үйлдвэрийн бодлогын зөвлөлийг мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцуулан байгуулах	13.8	V	29.5	IX	23.2	

**БҮЛЭГ 2. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, МУТХҮБ-2030-ЫН ХҮРЭХ ТҮВШИНГ
ТОДОРХОЙЛСОН АРГА ЗҮЙГ ТУРШСАН БАЙДАЛ БА ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮН**

7	Хүнд аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагааг шинжлэх ухааны байгууллагууд, их дээд сургууль, мэргэжил сургалтын төв, зохион бүтээх үүсгэл санаачлагын бүтцүүдтэй нягт уялдуулах замаар үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлж, төсвийн хөрөнгөөр дэмжих	13	VI	26.3	X	21	
8	Хүнд аж үйлдвэрийн дагалдах жижиг, дунд боловсруулах үйлдвэрүүдийг татвар, мөнгө, зээл, гадаад худалдааны болон Засгийн газрын болон төрийн өмчит том компаниудын худалдан авалтаар дэмжих	8.25	XI	21.5	XI	16.2	
9	Хүнд аж үйлдвэрийн салбарыг байгаль орчин, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, зам, тээвэр, холбоо, мэдээлэл, ус, цахилгаан, дулаан хангамж зэрэг дэд бүтцийн салбаруудтай уялдуулах	10.8	X	40.5	II	28.6	VI
10	Хүнд аж үйлдвэрийн мега төслүүдийн ТЭЗҮ-ийг боловсруулах, тооцоолох, зураглах, үнэлэх, магадлал хийдэг үндэсний чадавхыг олон улсын стандартын түвшинд бэхжүүлж, төслийг хэрэгжүүлэхдээ бүс, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, олон улсын зах зээлийн интеграцад нэгтгэх	12.8	VII	40	III	29.1	IV
11	Олон улсын худалдааг хөнгөвчлөх, тарифын болон тарифын бус саад тотгорыг багасгах арга хэмжээний хүрээнд хүнд аж үйлдвэрийн салбарын бараа, бүтээгдэхүүний гадаад зах зээлд нэвтрэх боломжийг бий болгох, зах зээлийн тоог олшруулах, бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	12.3	VIII	31.8	VIII	24	VIII

Хүснэгт 5-аас харахад уул уурхай, хүнд аж үйлдвэрийн салбарын зорилго, зорилтууд болон МУТХҮБ-2030-ын 12 зорилтоос эхний 8 зорилтыг эрэмбэлэн авч, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх зорилтуудыг тодорхойлсон.

Энэ ажлын дараа салбарын хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг оролцогсдоор томъёолуулав. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай эдийн засгийн зохицуулалтын механизмуудыг хэрхэн ашиглах талаар “Гэрэгэ партнерс” компанийн зөвлөх шинжлэх ухааны доктор А.Даваасүрэн “Төрийн эдийн засгийн бодлого, зохицуулалтын аргачлал” сэдэвт илтгэл тавьж, хэлэлцүүлэгт оролцогсдод чиглэл өгсөн.

Хүснэгт 6. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх зорилтуудыг хангах арга хэмжээнүүд

№	Зорилтууд	Авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд		
1	Салбарын хөгжлийн бодлого зохицуулалтыг нарийвчлан тодорхойлох, хууль, дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг чанд хангуулах	1.1. Ашигт малтмалын тухай болон Газрын хэвлийн тухай хуулийг шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах	1.2. Салбарын үйл ажиллагаанд хэрэглэгддэг бүхий л эрх зүйн баримт бичиг, стандартын давхардал, зөрчил, орхигдсон зохицуулалтыг судалж гаргах /gap analysis/	1.3. Газрын хэвлийн, ашигт малтмалын тухай, урт нэртэй хууль, түгээмэл тархацтай ашигт малтмалын зэрэг хуулиудын уялдаа холбоо, нийцэл давхардлыг судлах
2	Салбарын бодлогыг хэрэгжүүлэгч институцийн удирдлага, зохион байгуулалт, чиг үүргийг нарийвчлах, оновчтой механизмыг бүрдүүлж, сайн засаглалыг бий болгох (тайлан, шударга, ил тод, хариуцлагатай байх)	2.1. Бодлого хэрэгжүүлэгч агентлагийн мэргэжилтэн, судлаачдын үйл ажиллагааг дэмжих, залгамж халааг чухалчлах	2.2. Үндэсний геологийн алба байгуулах	2.3. УУХҮЯ, агентлаг, төрийн бусад байгууллагын удирдлагаас хараат бус байх
3	Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын хариуцлагыг нэмэгдүүлэх, компанийн засаглалыг сайжруулах	3.1. Хариуцлагатай уул уурхайн стандартыг нэвтрүүлэн хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн өөрсдийн санаачлагыг дэмжих	3.2. Төрийн өмчит компаний хариуцлагатай, уул уурхай, тогтвортой хөгжлийн тайланг заавал гаргах шаардлагыг хуульд оруулах	3.3. Уул уурхайн компаниудад эрсдэлийн менежментийн тухай ойлголтын талаар сургалт явуулах, түүнийг их сургууль, зөвлөх инженерүүдийн сургалтын модульд оруулах, УУЯ, АМГ-т сургалт явуулах
4	Хүн, амьтан, байгальд сөрөг нөлөөлөл багатай, орчин үеийн дэвшилтэт техник, технологи, инновацийг нэвтрүүлэх, ордын геологийн тогтоц болон нөөцийн онцлогт тохирсон оновчтой техник, технологийг ашиглах	4.1. Уул уурхайн түүхий эдийг боловсруулах үйлдвэр байгуулах, ТЭЗҮ-г баталж үйлдвэрлэл явуулах	4.2. Салбарын судалгааны институцийг шинээр байгуулж, техник, технологийн болон инновацийн судалгаануудыг санхүүжүүлж хэрэгжүүлэх, судалгааны төв байгуулах	4.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй уул уурхай, дэд бүтцийн худалдан авах ажиллагаанд заавал дэвшилтэт технологи хэрэглэх шаардлага тавих

5	Уул уурхайн салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд бусад салбарын (байгаль орчин, усны нөөц, боловсруулах салбар, эрчим хүч, зам тээвэр, барилга, хот байгуулалт) бодлоготой уялдуулж, судалгаа, төлөвлөлт, удирдлага зохицуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоог бий болгох	5.1. Ил урсацтай томоохон голуудын урсгалд тохирсон байгууламжуудыг байгуулж ашигласнаар газрын доорх усны нөөцийг хэмнэнэ	5.2. Томоохон уул уурхайн үйлдвэрлэлүүдийг түшиглэсэн эрчим хүчний шугам, ДЦС байгуулах	5.3. Тусгай зөвшөөрлийн тогтолцоог шинэчлэх / багасгах, бууруулах/
6	Салбарын мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод үе шаттай бэлтгэх, давтан сургах, цалин хөлсний урамшууллын тогтолцоог бий болгох	6.1. УУХҮЯ, БСШУСЯ болон ХНХЯ хооронд бодлогын бүтэц зохион байгуулалт бий болгох, боловсон хүчний сургалтын хэрэгцээ, шаардлага зэргийг тодорхойлдог болох	6.2. ШУТИС болон уул уурхайн сургуулийн багшийг гадаадад бэлтгэх, нарийн мэргэшүүлэх, давтан сургах асуудлыг БСШУСЯ, УУХҮЯ бодлогоор дэмжих	6.3. Мэргэжилтэн бэлтгэж буй сургуулиудыг орчин үеийн дэвшилтэт лабораториор хангах

Уул уурхайн, хүнд үйлдвэрийн салбарын дунд хугацааны тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай олон арга хэмжээний талаар хэлэлцүүлэгт оролцогсод бичсэн. Эдгээр арга хэмжээг багцалж, ач холбогдлоор нь эрэмбэлэн 3 арга хэмжээг түүвэрлэж авсан.

Дүгнэж хэлэхэд, эдийн засгийн салбаруудын дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох арга нь тухайн салбарт тулгамдаж байгаа олон асуудлыг хооронд нь харьцуулж хамгийн чухлыг нь тодорхойлж, МУТХҮБ-2030-тай уялдсан эсэхийг нь шинжлэхэд хэрэгтэй. Энэ арга нь ойлгоход хялбар, практик дээр ашиглахад энгийн, цаг хугацаа, хүн хүч хэмнэх бөгөөд тодорхой нэг асуудлыг шийдэхэд бусад асуудал аяндаа шийдэгдэх нөхцөлийг тодорхойлох, нэн тэргүүнд шийдэх асуудлыг эрэмбэлэн томъёолох зэрэгт төр, захиргаа, судалгаа, шинжилгээний болон олон нийтийн төлөөллүүдийг өргөнөөр оролцуулах боломж олгодгоороо онцлог юм. Энэ арга нь системийн шинжилгээний аргын нэг хэлбэр мөн.

Хэлэлцүүлэгт оролцож байгаа бүлгийн гишүүд асуудлаа хэр зэрэг мэддэг, асуудалд хэрхэн хариуцлага, сэтгэл гаргаж хандсанаас шалтгаалан гарах үр дүн нь бодитой эсвэл хийсвэр байх магадлалтай бөгөөд үүнд уг аргын дутагдалтай тал оршино.

БҮЛЭГ 3. САЛБАРУУДЫН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН ЗОРИЛТУУДЫН НЭГДСЭН ХҮРЭЭ БА НИЙТЛЭГ АСУУДЛУУД

Монгол Улсын эдийн засгийн 40 дэд салбарыг хамруулсан 17 удаагийн хэлэлцүүлгийн үр дүнд дараах 18 тэргүүлэх зорилтыг тодорхойлов. Салбаруудад хийсэн хэлэлцүүлгээс гарсан асуудлуудад шинжилгээ хийж үзэхэд хууль, эрх зүй, дүрэм, журам хоорондын уялдаа гэсэн асуудал 39 салбарт, төрийн бодлого, эдийн засгийн механизм (татвар, татаас, төрийн худалдан авалт) 33 салбарт, хүний нөөцийн бодлого, ажиллах хүчний хүрэлцээ, боловсон хүчний хөгжил, сургалт, сургалтын хөтөлбөр, мэргэжлийн сургалт, ур чадварыг хөгжүүлэхтэй холбоотой асуудал 30 салбарт, засаглал, институцийн удирдлага, тогтолцоо, зохион байгуулалт, залгамж халаа, сайн засаглалын асуудал 29 салбарт, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, иж бүрдэл, сав баглаа боодол, стандарт, өрсөлдөх чадвар муу гэсэн асуудал 22 салбарт, хөрөнгө оруулалт, зээл, банкны үйлчилгээ, санхүүжилтийн асуудал 20 салбарт, эрдэм шинжилгээ, судалгааны институц 20 салбарт, төр болон төрийн бус байгууллагуудын хоорондын уялдаа холбооны тухай 19 салбарт, үйлдвэрлэлийн дэд бүтэц (эрчим хүч, зам тээвэр, цэвэрлэх байгууламж), аж ахуйн үйлдвэрлэлийн экологи, кластер, уялдаа 18 салбарт, салбарын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх асуудал 12 салбарт, түүхий эд, материалын нөөц, чанар, хангамж, бэлтгэн нийлүүлэлт, борлуулалт, худалдан авалтын сүлжээ болон гадаад, дотоод зар сурталчилгаа, маркетинг, гадаад зах зээл, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийн хөгжил тус бүр 6 салбарт давтагдаж, бүх салбар дахь нийтлэг асуудлууд тодорхой болсон байна.

Хүснэгт 7. Салбаруудаас гарсан зорилтуудын давхардсан байдал

№	Холбогдох зорилтын ангилал	Давтамжийн тоо	Эрэмбийн жагсаалт
1	Хууль, эрх зүй, дүрэм, журам	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 39	15 салбарт - 1 6 салбарт - 2 5 салбарт - 3 4 салбарт - 4 3 салбарт - 5 1 салбарт - 6 2 салбарт - 7 3 салбарт - 8 Нийт - 39 салбарт
2	Төрийн бодлого, эдийн засгийн механизм (татвар, татаас, төрийн худалдан авалт)	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 33	7 салбарт - 1 6 салбарт - 2 3 салбарт - 3 4 салбарт - 4 5 салбарт - 5 5 салбарт - 6 3 салбарт - 7 Нийт - 33 салбарт
3	Хүний нөөцийн бодлого, ажиллах хүчний хүрэлцээ, боловсон хүчний хөгжил, сургалт, сургалтын хөтөлбөр, мэргэжлийн сургалт, ур чадварын дээшлэлт	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 30	1 салбарт - 1 6 салбарт - 2 8 салбарт - 3 3 салбарт - 4 5 салбарт - 5 4 салбарт - 6 3 салбарт - 7 Нийт - 30 салбарт

**БҮЛЭГ 3. САЛБАРУУДЫН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН
ЗОРИЛТУУДЫН НЭГДСЭН ХҮРЭЭ БА НИЙТЛЭГ АСУУДЛУУД**

4	Засаглал, институцийн удирдлага, тогтолцоо, зохион байгуулалт, залгамж халаа, сайн засаглал	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 29	7 салбарт - 1 7 салбарт - 2 1 салбарт - 3 4 салбарт - 4 4 салбарт - 5 4 салбарт - 6 2 салбарт - 7 Нийт - 29 салбарт
5	Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, иж бүрдэл, сав баглаа боодол, стандарт, өрсөлдөх чадвар	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 22	4 салбарт - 1 4 салбарт - 2 6 салбарт - 3 3 салбарт - 4 3 салбарт - 5 1 салбарт - 6 1 салбарт - 7 Нийт - 22 салбарт
6	Хөрөнгө оруулалт, зээл, банкны үйлчилгээ, санхүүжилтийн асуудал	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 20	4 салбарт - 1 4 салбарт - 2 2 салбарт - 3 1 салбарт - 4 6 салбарт - 5 3 салбарт - 6 Нийт - 20 салбарт
7	Эрдэм шинжилгээ, судалгааны институт	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 20	2 салбарт - 1 4 салбарт - 2 2 салбарт - 3 4 салбарт - 4 2 салбарт - 5 2 салбарт - 6 1 салбарт - 7 1 салбарт - 8 Нийт - 20 салбарт
8	Төр болон төрийн бус байгууллагуудын хоорондын уялдаа холбоо	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 19	2 салбарт - 1 5 салбарт - 2 4 салбарт - 3 5 салбарт - 4 1 салбарт - 5 2 салбарт - 6 Нийт - 19 салбарт
9	Үйлдвэрлэлийн дэд бүтэц / эрчим хүч, зам тээвэр, цэвэрлэх байгууламж/, аж үйлдвэрлэлийн экологи, кластер, уялдаа	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 18	2 салбарт - 1 1 салбарт - 2 1 салбарт - 3 3 салбарт - 4 4 салбарт - 5 3 салбарт - 6 3 салбарт - 7 1 салбарт - 9 Нийт - 18 салбарт
10	Техник, технологийн хүртээмж, суурилагдсан материаллаг бааз, хүчин чадлын ашиглалт, тоног төхөөрөмжийн хүрэлцээ, чанар, стандарт	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 12	2 салбарт - 1 3 салбарт - 2 2 салбарт - 3 1 салбарт - 4 1 салбарт - 5 3 салбарт - 6 Нийт - 12 салбарт

**БҮЛЭГ 3. САЛБАРУУДЫН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН
ЗОРИЛТУУДЫН НЭГДСЭН ХҮРЭЭ БА НИЙТЛЭГ АСУУДЛУУД**

11	Салбарын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 12	3 салбарт - 1 2 салбарт - 2 1 салбарт - 3 3 салбарт - 4 1 салбарт - 5 1 салбарт - 7 1 салбарт - 8 Нийт - 12 салбарт
12	Гадаад, дотоод зар сурталчилгаа, маркетинг, гадаад зах зээл, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийн хөгжил	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 6	1 салбарт - 1 1 салбарт - 2 1 салбарт - 4 3 салбарт - 5 Нийт - 6 салбарт
13	Экспорт, импортын худалдаа, гааль, тариф болон тарифын зохицуулалт, бусад гадаад, дотоод хүчин зүйлс	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 6	1 салбарт - 3 1 салбарт - 4 1 салбарт - 5 2 салбарт - 6 1 салбарт - 8 Нийт - 6 салбарт
14	Инноваци, зохиогчийн эрхийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хамгаалах тогтолцоо	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 5	1 салбарт - 1 1 салбарт - 2 2 салбарт - 3 1 салбарт - 4 Нийт - 5 салбарт
15	Түүхий эд, материалын нөөц, чанар, хангамж, бэлтгэн нийлүүлэлт, борлуулалт, худалдан авалтын сүлжээ	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 3	1 салбарт - 2 1 салбарт - 5 1 салбарт - 6 нийт - 3 салбарт
16	Байгаль орчны нөлөөлөл, бохирдлын асуудал /цэвэр усны хангамж, хог хаягдал, бохир ус/	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 3	1 салбарт - 3 2 салбарт - 4 Нийт - 3 салбарт
17	Компаний менежмент, засаглал	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 3	1 салбарт - 3 1 салбарт - 5 1 салбарт - 7 Нийт - 3 салбарт
18	Тээвэр, ложистикийн нэгдсэн сүлжээ	Салбар бүрд гарсан тэргүүлэх зорилтын давталтын тоо - 3	1 салбарт - 3 2 салбарт - 4 Нийт - 3 салбарт

Хүснэгт 7-оос дүгнэлт хийхэд салбаруудын хөгжлийг хамгийн их хязгаарлаж буй асуудал бол хууль эрх зүйн зохицуулалт оновчгүй, зүйл заалтууд нь давхардсан, өөр хоорондоо зөрчилтэй, хэрэгжүүлэхэд төвөгтэй байдаг явдал гэж хэлэлцүүлэгт хамрагдсан 40 дэд салбараас 39 салбар нь үзжээ.

Дараагийн дугаарт тухайн салбарыг хөгжүүлэхэд шаардлагатай санхүү, эдийн засгийн зохицуулалтын арга механизмуудын үйлчлэл ойлгомжгүй, зөрчилтэй (төлбөр, хураамж, татвар, хөнгөлөлт, чөлөөлөлт, татаас, шилжүүлэг дэмжлэг, үнэ тариф, өмчийн харьцаа, төрийн худалдан авалт), эдийн засгийн хөшүүргүүд дутагдалтай бөгөөд үндэсний үйлдвэрлэгчийг дэмжихэд чиглэгдээгүй гэж 33 дэд салбар үзсэн байна.

Ийм байдалд хүргэхэд тухайн салбарт ажиллаж байгаа боловсон хүчний ур чадвар сул, хариуцлага, сахилга бат муу, гүйцэтгэлийн түвшин доогуур, тэдгээрийн урамшууллын механизм хангалтгүй, хүний нөөцийг хөгжүүлэх мэргэжлийн сургалтын

чанар хангалтгүй, боловсон хүчнийг шилж сонгох, томилох, дэвшүүлэхэд улс төрийн оролцоо өндөр, төрийн албан хаагчийн тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрэлдээгүй зэрэг нь нөлөөлж байна гэж 30 дэд салбарын төлөөлөл үзжээ.

Засаглалын тогтолцоо оновчгүй, төрийн институцийн удирдлага, зохион байгуулалт тааруу, зөрчилтэй, засаглалын тогтолцоо популист¹ шинж чанартай, төрийн эрх барих дээд байгууллага, шүүх засаглалын эрх мэдэл давхардсан, бие биендээ хяналт тавьж чадахаа больсон, хэтэрхий улс төржсөн, төрийн байгууллагын бодлогын залгамж чанар алдагдсан хэмээн 29 дэд салбарын төлөөлөл дүгнэжээ.

Төрийн болон бизнесийн байгууллагуудын үйлдвэрлэж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа үйлчилгээний чанар, стандартын түвшин доогуур, тэдгээр нь гадаад, дотоодын зах зээл дээр өрсөлдөх чадваргүй гэж 22 дэд салбарын төлөөлөл үзсэн байна.

Салбарын үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэхэд санхүүгийн болон хөрөнгийн нөөц дутагдалтай, эх үүсвэр хомс, хүрэлцээгүй, гадаад эх үүсвэр татах боломж шавхагдсан, төр, засаг нь өрийг өрөөр төлдөг хэмээн 20 дэд салбарын төлөөлөл дүгнэсэн байна.

Төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явц тооцоо, судалгаа, шинжилгээн дээр суурилагүй, төрөөс тухайн салбарын хөгжлийн бодлого тодорхойлох эрдэм шинжилгээний байгууллага байхгүй, их, дээд сургуулиудын багш, судлаачдыг татан оролцуулах хөшүүргийг ашиглаж чадахгүй байна гэж 20 дэд салбарын төлөөлөл үзжээ.

Салбарын тодорхой ажил үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, төрийн байгууллагын ачааллыг хуваалцах талаар төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа байхгүй, бодлого боловсруулах шийдвэр гаргах үйл явцад төрийн бус байгууллагын дуу хоолой болон тэдний хүчийг ашиглах, тэднийг урамшуулах механизм байхгүй гэж 19 дэд салбарын төлөөлөл дүгнэв.

Салбар хоорондын бодлого, зохицуулалтын болон үйл ажиллагааны уялдаа холбоос дутмаг, салбар доторх болон салбар хоорондын мэдээллийн сангийн тогтолцоо байхгүй, үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг гадаад зах зээл гаргахад төрийн зүгээс үзүүлэх дэмжлэг, туслалцаа сул, хөнгөлөлт, чөлөөлөлтийн механизмуудыг ашиглахгүй байна. Мөн Монгол Улсыг төлөөлөн гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчдийн газрууд үндэсний үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалах, тэднийг тухайн улсад суугаа орныхоо бизнесийн субъектүүдтэй холбож өгөх, бараа, бүтээгдэхүүнийг сурталчлахад туслах талаар идэвх санаачилга хангалтгүй ажиллаж байгаа зэрэг нийтлэг асуудлууд шийдлээ хүлээж байна гэж 18 дэд салбарын төлөөлөл үзжээ.

¹ Популист - Олон нийтийн санаа сэтгэлээр тоглох хүн, улс төрийн ажилтан.

БҮЛЭГ 4. ДУНД ХУГАЦААНЫ (2020-2025) ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

4.1. Макро эдийн засгийн бодлогын тэргүүлэх чиглэлүүд

Монгол Улсын 2020-2025 оны дунд хугацааны макро эдийн засгийн бодлогын тэргүүлэх чиглэлүүд нь МУТХҮБ-2030 баримт бичигт тусгасан 2030 он хүртэлх Монгол Улсын алсын хараа, урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтуудаас урган гарсан, тэдгээртэй нягт холбоотой дараах гол чиглэлүүд юм. Үүнд:

1. Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг олон тулгууртай болгон төрөлжүүлнэ.
2. Эдийн засгийн өсөлтийг илүү хүртээмжтэй болгож, дундаж өсөлтийг 6,6 хувиас доошгүй байлгана.
3. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ.
4. Нэгдсэн төсвийн тэнцлийг алдагдалгүй байлгаж, Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх төсвийн нийт зарлагыг бууруулна.
5. Өрийн дээд хязгаарыг чанд сахин мөрдөж, өрийн зохистой түвшинг хангах, гадаад зах зээл дэх Монгол Улсын зээлжих зэрэглэлийг тогтмол дээшлүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.
6. Гадаад зах зээлийн болон түүхий эдийн үнэ ханшийн хэлбэлзлээс сэргийлэх бодлогыг баримталж, хуримтлалын санг бий болгон арвижуулна.
7. Гадаад валютын нөөцийн зохистой хэмжээг байнга бүрдүүлж байна.
8. Төлбөрийн тэнцлийг алдагдалгүй төлөвлөн хэрэгжүүлж, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг ханган, инфляцыг тогтвортой, нам түвшинд барина.
9. Банк, санхүүгийн тогтолцооны урт хугацааны тогтвортой, эрсдэлгүй, найдвартай байдлыг чанд хангаж, хөгжлийн бодлогын зорилтод нийцсэн зээл, хүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлнэ.
10. Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, санаачлагад нэгдэж, эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулж, бүс нутгийн шинжтэй томоохон төслүүдийг хэрэгжүүлнэ.
11. Урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, олон улсын байгууллага болон гадаадын урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийг түлхүү ашиглаж, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудтай бодлогоо уялдуулж, идэвхтэй хамтран ажиллана.

Макро эдийн засгийн бодлогын тэргүүлэх чиглэлүүд нь “Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой

ардчилсан засаглалтай улс болно” гэсэн Монгол Улсын 2030 он хүртэлх алсын харааг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

4.2. Эдийн засгийн салбаруудын тогтвортой хөгжлийн дунд хугацааны бодлогын тэргүүлэх чиглэлүүд

МУТХҮБ-2030-д “Салбарын хөгжлийн зорилт нь өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, инноваци шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин урамшуулахад чиглэнэ” гэж тодорхойлсон. Үүний хүрээнд дараах салбарын зорилтуудыг дэвшүүллээ.

4.2.1. Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд бэлчээрийн ашиглалт ба нөхөн сэргээлтийг тэнцвэржүүлж, бэлчээрийн доройтлыг бууруулах

Зорилт 1. Бэлчээрийн даацад нийцсэн мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх (МУТХҮБ-2030 ба хэлэлцүүлгээс²).

Зорилт 2. Бэлчээрийн даац хэтэрсэн нутагт малын тооны дээд хязгаарыг тогтоож, түүнээс давуулахгүй байлгах эдийн засгийн хөшүүргүүдийг бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Бэлчээрийн бодлогын судалгаанд үндэслэсэн бэлчээрийн нөхцөлийг сайжруулах, сөрөг нөлөөг харгалзсан үр дүн ба үр ашигтай бэлчээрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний чанарыг сайжруулж, малыг эрүүлжүүлэх

Зорилт 1. Үндэсний мал, амьтны эмнэлгийн тогтолцоог боловсронгуй болгох (МУТХҮБ-2030).

Зорилт 2. Мал, амьтны өвчний тандалт, хяналт үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний анхан шатны нэгжийн материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжилтний хүрэлцээ хангамж, чадавхыг сайжруулахад төрөөс дэмжих (“Монгол мал хөтөлбөр”, 3.1.2.2. дахь хэсэг).

Зорилт 4. Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталгаажуулсан худалдаа, хорио цээрийн шаардлагад нийцсэн мал, амьтны өвчингүй статустай нутгийн хэмжээг нийт газар нутгийн 10-аас доошгүй хувьд хүргэх (МУТХҮБ-2030 ба хэлэлцүүлгээс).

Зорилт 5. Мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг хөрш орнуудын зах зээлд гаргах мал эмнэлгийн эрүүл ахуйн зохистой орчныг бүрдүүлэх (МУТХҮБ-2030).

Зорилт 6. Олон улсын худалдааны хориг бүхий малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулах, зооноз халдварт өвчнөөс мал сүргийг хамгаалах (Хэлэлцүүлгээс ба “Монгол мал” хөтөлбөр, 3.3.1. дүгээр заалт).

Зорилт 7. Бодлогын судалгаанд үндэслэсэн мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах,

² МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх Мал аж ахуйн салбарын дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэлэлцүүлэг, ҮХГ, 2018.

сөрөг нөлөөг харгалзсан, үр дүн ба үр ашигтай бэлчээрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Мал үржлийн ажил, үйлчилгээний чанарыг сайжруулж, малын ашиг шимийг нэмэгдүүлж, тэсвэрт чанарыг хадгалах

Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх (МУТХҮБ-2030).

Зорилт 2. Бэлчээрийн монгол малыг тухайн орон нутагт зохицсон ашиг шимийн чиглэлийн үүлдэр, омог, хэвшлийн цөм сүргийн малаар сайжруулах (“Монгол мал” хөтөлбөр, 3.2.1.1. дэх хэсэг).

Зорилт 3. Хангайн бүсэд үхэр, адуу, тал хээрийн бүсэд хонь, адуу, говийн бүсэд ямаа, тэмээ зонхилж, томоохон хот суурин газрын ойролцоо болон тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг тодорхой зорилго, чиглэлтэйгээр төрөлжүүлэн хөгжүүлэх (“Монгол мал” хөтөлбөр, 3.2.1.2. дахь хэсэг).

Зорилт 4. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний анхан шатны нэгжийн материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжилтний хүрэлцээ хангамж, чадавхыг сайжруулахад төрөөс дэмжих (“Монгол мал” хөтөлбөр, 3.2.2.2. дахь хэсэг).

Зорилт 5. Нийт мал сүрэг дэх өндөр ашиг шимт малын эзлэх хувийг 5 хувьд хүргэх (МУТХҮБ-2030).

Зорилт 6. Бодлогын судалгаанд үндэслэсэн малын үржлийн үйлчилгээг сайжруулах, сөрөг нөлөөг харгалзсан үр дүн ба үр ашигтай бэлчээрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

Бодлогын тэргүүлэх чиглэл 4. Мал аж ахуйн ба туслах аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийг өргөтгөн хөгжүүлж, бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлж, малчид ба аж ахуй эрхлэгчдийн орлогыг өсгөн, мал аж ахуй ба туслах аж ахуйн эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх

Зорилт 1. Мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартад нийцүүлэн, экспортыг нэмэгдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг аймаг, сумын түвшинд хөгжүүлэх (МУТХҮБ-2030 ба хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Олон улсын стандарт шаардлагыг хангасан мах боловсруулах үйлдвэр, мал аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэлийн тогтолцоо, сүлжээ байгуулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Ноос, ноолуур, арьс шир зэрэг түүхийн эдийн бэлтгэл, тээвэрлэлт, үндэсний үйлдвэрт тогтвортой нийлүүлэх тогтолцоог бүрдүүлж, түүхий эдийн сан бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 5. Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, үйл ажиллагааг боловсронгуй болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 6. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, үхэр, хонины аж ахуйг махны чиглэлээр эрчимтэй хөгжүүлж, махны экспортын нөөцийг нэмэгдүүлэх (“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” (ТХХААтББ), 2.1.1. дүгээр заалт).

Зорилт 7. Бэлчээрийн болон фермерийн аж ахуйг зохистой хослуулж, мах, махан

бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 8. Байгалийн нөхцөл, зах зээлийн төвлөрлийг харгалзан эрчимжсэн мал аж ахуй ба гахай, тахианы аж ахуйг хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 9. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, дэвшилтэт техник, технологийн шинэчлэл хийх, инновацийг нэвтрүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 10. Мал аж ахуйн салбарт урт хугацааны хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлэх санхүү, зээлийн уян хатан бодлого хэрэгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 11. Мал аж ахуйн салбар дахь хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжих, энэ салбарын хүний нөөцийг чадавхжуулах (Хэлэлцүүлгээс ба "Монгол мал" хөтөлбөр, 3.1.3. дугаар заалт).

Зорилт 12. Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 5. Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахын тулд мал аж ахуйн салбарын тогтолцоо, засаглал, хууль эрх зүйг сайжруулах

Зорилт 1. Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбар болох мал аж ахуйг төрөөс онцгой анхаарч, эрх зүй, эдийн засаг, бүтэц, зохион байгуулалтын нэн таатай орчныг бүрдүүлж, тогтвортой хөгжлийг хангаж, сайн засаглалыг хөгжүүлэх ("Монгол мал" хөтөлбөр, 1. дүгээр зүйл).

Зорилт 2. Мал аж ахуйн салбарын төрийн зохицуулалт, үүрэг хариуцлагын тогтолцоо, хууль тогтоомжийг сайжруулах (Хэлэлцүүлгээс ба "Монгол мал хөтөлбөр", 3.1.1. дүгээр заалт).

Зорилт 3. Малчин өрх, хот айлын аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх (МУТХҮБ-2030).

Зорилт 4. Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг зах зээлийн эргэлтэд оруулах тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 5. Хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүний үнийн зохицуулалтын эрх зүйн орчныг сайжруулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 6. Мал аж ахуйн салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан, сүлжээг бий болгох (Хэлэлцүүлгээс).

4.2.2. Газар тариалангийн салбарын тогтвортой хөгжлийн бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд газрын ашиглалт ба хөрсний нөхөн сэргээлтийг тэнцвэржүүлж, хөрсний доройтлыг бууруулан газар тариалангийн үйлдвэрлэлийн эрсдэлийг багасган тогтвортой хөгжлийг хангах

Зорилт 1. Хөрсний хяналт тавих газар зохион байгуулалтын оновчтой тогтолцоо

бий болгох (Хэлэлцүүлгээс³).

Зорилт 2. Үр тарианы үйлдвэрлэлийн талбайд тэг элдэншүүлэлтийн технологи нэвтрүүлэх ажлыг 85 хувьд хүргэх (МУТХҮБ-2030 ба ТХХААТББ, 3.1.4. дүгээр заалт).

Зорилт 3. Усалгааны хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, усалгаатай тариалангийн талбайг 100,0 мянган га-д хүргэх (МУТХҮБ-2030 ба хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Жилд шаардагдах бордооны хангамжийг 70 хувьд хүргэх (МУТХҮБ-2030).

Зорилт 5. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, дэвшилтэт технологид суурилсан тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, тогтвортой хөгжүүлэх (ТХХААТББ, 1.4.2. дугаар заалт ба хэлэлцүүлгээс).

Зорилт 6. Газар тариалангийн эрсдэлийн даатгалыг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Үр, бордоо, ургамал хамгаалах бодисын чанар, хяналтыг сайжруулж, газар тариалангийн бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байдлыг хадгалж, хүн амыг эрүүл хүнсээр хангах

Зорилт 1. Генийн хувиргалтгүй нутагшсан соортын үрийн аж ахуйг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Нутагшсан соортын элит үрийн хангамжийг 90 хувьд хүргэх (МУТХҮБ-2030).

Зорилт 3. Бордоо, хамгаалах бодисын үйлдвэрлэл, импорт, хэрэглээний чанарын хяналтын тогтолцоог сайжруулах.

Зорилт 4. Генийн хувиргасан амьд организм, хорт нэгдэл, ургамал хамгааллын бодисын үлдэгдэл, антибиотикийн үлдэгдэл, микробиологи, шим тэжээлийн үзүүлэлт ба хүнд металлын агууламж зэргийг тодорхойлохын тулд газар тариалангийн гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг олон улсын магадлан итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж, худалдаанд нийлүүлэх зохицуулалтыг бий болгох.

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Газар тариалангийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн бүс нутаг, орц болон бүтээгдэхүүний төрөл ба хэмжээ, техник, технологийг оновчтой тодорхойлон бүтээмжийг дээшлүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах

Зорилт 1. Одоо амжилттай, тогтвортой ажиллаж байгаа аж ахуй нэгжүүдийн туршлагыг дэлгэрүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Аж ахуйн төрөлжилт, зохистой хэмжээ, бүс нутаг, технологийн сонголтыг оновчтой болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Үйлдвэржсэн жишиг болон төрөлжсөн аж ахуйг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Тариалангийн газрыг эдийн засгийн эргэлтэд бүрэн оруулж, үр ашигтай ашиглах, бүртгэл, хяналтыг сайжруулах (ТХХААТББ, 3.1.1. дүгээр заалт).

Зорилт 5. Таримлын төрөл зүйлүүдийг олшруулж, технологийг хөгжүүлэх

³ МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх Газар тариалангийн салбарын дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэлэлцүүлэг, ҮХГ, 2018.

(Хэлэлцүүлгээс).

Зорилт 6. Тэжээл үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж, тэжээлийн импортыг бууруулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 7. Төгс бүтээгдэхүүн болон ашигт ургамлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 4. Газар тариалангийн бүтээгдэхүүний ба орцын зах зээлийг хөгжүүлж, технологи, бүтээмжийг дээшлүүлэн тариаланчид ба газар тариалангийн салбарын орлогыг нэмэгдүүлэх

Зорилт 1. Зоорь агуулах, тээвэр, борлуулалтын ложистикийн сүлжээг бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Өрсөлдөх чадвартай импортыг орлох болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Газар тариалангийн бүтээгдэхүүний гадаад ба дотоод худалдааны үр ашигтай нэгдсэн бодлого боловсруулж мөрдөх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлэх (МУТХҮБ-2030).

Зорилт 5. Өвөл, зуны хүлэмжийн болон зоорийн аж ахуйг хөгжүүлэн хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, хот, суурингийн хүн амыг жилийн турш шинэ ургацын ногоогоор тогтвортой хангах (ТХХААтББ).

Зорилт 6. Хөдөө аж ахуйн техник хангамжийн талаар төрийн нэгдсэн бодлого зохицуулалт хийх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 7. Жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх (МУТХҮБ-2030).

Зорилт 8. Банк, санхүү, зээлийн бодлогыг төгөлдөржүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 9. Газар тариалангийн хөгжил, технологийн шаардлагад нийцсэн боловсон хүчнийг бэлтгэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 5. Газар тариалангийн салбарын тогтвортой хөгжлийг хангахын тулд тус салбарын тогтолцоо, хууль эрх зүйг сайжруулах

Зорилт 1. Хууль эрх зүй, институцийн тогтолцоог боловсронгуй болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Бүртгэл, мэдээллийн системийг боловсронгуй болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Тусгай сангуудын үйл ажиллагааг зохицуулж, уялдааг хангах (Хэлэлцүүлгээс).

4.2.3. Уул уурхай, олборлох, хүнд үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох (“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого” (ТЭБСББ), 3.1. дэх хэсэг)

Зорилт 1. Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтыг нарийвчлан тодорхойлох, хууль, дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг чанд хангуулах (Хэлэлцүүлгээс⁴).

Зорилт 2. Дэлхийн эдийн засаг, бүс нутгийн зах зээлийн төлөв байдал, цаашдын чиг хандлагад судалгаа, шинжилгээ тогтмол хийж, дотоодын эрдэс баялгийн бүтээгдэхүүний олборлолт, ашиглалт, нөөц бүрдүүлэх чиглэлээр урт, дунд, богино хугацааны хөтөлбөр боловсруулж, мөрдөн ажиллах (ТЭБСББ, 3.1.5. дугаар заалт).

Зорилт 3. Ашигт малтмалын нөөцийн бүртгэл, хяналтын тогтолцоог сайжруулах, ашигт малтмалын нөөцийг ангилах болон нөөц ашигласны төлбөрийг тооцох арга, аргачлалыг боловсронгуй болгох, нөөцийг ангилах, үндэсний гео мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Эрдэс баялгийн болон ашигт малтмалын ордын нөөцийг үнэлэх олон улсын стандартад шилжих (ТЭБСББ, 3.1.9. дүгээр заалт).

Зорилт 5. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хүрээнд геофизик, геохими, уул-өрөмдлөгийн ажлыг цогцоор нь гүйцэтгэж чанарыг сайжруулах, хүдрийн дүүрэг, илрэл бүхий талбайд зарим онцгой тохиолдолд нарийвчилсан судалгааг гүйцэтгэх (ТЭБСББ, 3.2.2.3. дахь хэсэг).

Зорилт 6. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод төрийн хяналт, зохицуулалт, хариуцлагыг дээшлүүлэх замаар үйл ажиллагаа, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг боловсронгуй болгох (ТЭБСББ, 3.3.2. дугаар заалт).

Зорилт 7. Гео мэдээллийн нэгдсэн сан бий болгож, ашигт малтмал хайгуулын салбарт хөрөнгө оруулалтын таатай орчныг бий болгох, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын хэмжээнд 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 45 хувьд гүйцэтгэх (МУТХҮБ-2030).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Салбарын бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох (шинээр томьёолсон)

Зорилт 1. Салбарын удирдлага, зохион байгуулалт, чиг үүргийг нарийвчлах, оновчтой механизмыг бүрдүүлж, сайн засаглалыг бий болгох (тайлан, шударга, ил тод, хариуцлагатай байх) (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэхийн тулд зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх зорилго, чиг үүрэг бүхий төрийн байгууллага, хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбоод болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн тэгш байдлыг хангасан бодлогын зөвлөлийг байгуулж, ажиллуулах (ТЭБСББ, 3.7.1. дүгээр заалт).

Зорилт 3. Төрийн байгууллагын үйлчилгээг сайжруулж, нээлттэй, ил тод, үр ашигтай болгох ба эрдэс баялгийн салбар хариуцсан Засгийн газрын бүх шатны байгууллагын ажлын тогтолцоо, зөвшөөрөл олголт, стандарт, хугацаа зэргийг нийтэд мэдээлж, иргэний нийгмийн хяналтыг тогтоох (ТЭБСББ, 3.7.6. дугаар заалт).

Зорилт 4. Олборлолт, боловсруулалтын хэмжээг улс орны эдийн засаг, аж үйлдвэржилтийн нөхцөл байдал, гадаад, дотоод зах зээлийн цаашдын хэтийн

4 МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх Уул уурхайн салбарын дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэлэлцүүлэг, ҮХГ, 2018.

төлөвтэй уялдуулан оновчтой төлөвлөх (ТЭБСББ, 3.3.4. дүгээр заалт).

Зорилт 5. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд төр, орон нутгийн зүгээс тавих хяналт, төлбөр, хураамж ногдуулалтыг хүнд суртал, давхардалгүй болгох (ТЭБСББ, 3.3.5. дугаар заалт).

Зорилт 6. Төрийн өмчийн аж ахуйн нэгж нь ерөнхий гэрээлэгчийн зарчмаар ажиллаж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг хэрэгжүүлэх (ТЭБСББ, 3.6.2. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн засаглал, хариуцлага, ил тод байдал, тайлагналтыг дээшлүүлэх (шинээр томъёолсон)

Зорилт 1. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн засаглалыг сайжруулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Уурхайн нөхөн сэргээлт, хаалтын стандарт, журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах (ТЭБСББ, 3.6.3. дугаар заалт).

Зорилт 3. Уул уурхайн олборлолтын хугацаанд нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулагч компани, нутгийн өөрөө удирдах байгууллагын хооронд орон нутгийг хөгжүүлэх гэрээг ил тод байх, оролцооны зарчмыг баримтлан байгуулах (ТЭБСББ, 3.5.2. дугаар заалт).

Зорилт 4. Олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийн үе шатуудад хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, хүрээлэн байгаа орчны экологийн тэнцвэрт байдлыг хангасан байх (ТЭБСББ, 3.6.1. дүгээр заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 4. Уул уурхайн түүхий эдийг боловсруулах салбарын хөгжлийг дэмжих (шинээр томъёолсон)

Зорилт 1. Эрдэс баялгийн боловсруулалтын түвшинг дээшлүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг бодлогоор дэмжих (ТЭБСББ, 3.4.3. дугаар заалт).

Зорилт 2. Нүүрс баяжуулах, кокс, химийн үйлдвэр байгуулах, нүүрсний ордод түшиглэсэн цахилгаан станц барих, хүрэн нүүрснээс утаагүй, шингэн түлш, хий, шатдаг занараас шингэн түлш гарган авах зэрэг төслийг дэмжих (ТЭБСББ, 3.4.4. дүгээр заалт).

Зорилт 3. Төрөөс боловсруулах үйлдвэрийг татвар, санхүүгийн бодлогоор дэмжиж, ашигт малтмалын боловсруулалтын түвшинг дээшлүүлэх (ТЭБСББ, 3.4.5. дугаар заалт).

Зорилт 4. Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангах (МУТХҮБ-2030, Зорилт 3).

Зорилт 5. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах (МУТХҮБ-2030, Зорилт 4).

Бодлогын тэргүүлэх чиглэл 5. Салбарт тэргүүлэх дэвшилтэт техник, технологийг ашиглах (шинээр томъёолсон)

Зорилт 1. Хүн, амьтан, байгальд сөрөг нөлөөлөл багатай, орчин үеийн дэвшилтэт техник, технологи, инновацийг нэвтрүүлэх, ордын геологийн тогтоц болон нөөцийн онцлогт тохирсон оновчтой техник, технологийг ашиглах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Уул уурхайн үйлдвэрлэлийн бүтээмжийг өсгөн нэмэгдүүлэх зорилгоор олборлох салбарт шинжлэх ухаан, техник, технологийн ололтыг нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх (ТЭБСББ, 3.3.7. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 6. Салбарын бодлого үйл ажиллагааг бусад салбарын бодлого үйл ажиллагаатай уялдуулах

Зорилт 1. Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх (МУТХҮБ-2030, Зорилт 1).

Зорилт 2. Уул уурхайн салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд бусад салбарын (байгаль орчин, усны нөөц, боловсруулах салбар, эрчим хүч, зам тээвэр, барилга, хот байгуулалт) бодлоготой уялдуулж, судалгаа, төлөвлөлт, удирдлага зохицуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоог бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Эрдэс баялгийн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлд газрын гүний цэнгэг усыг аль болох ашиглахгүй байх, гадаргын усыг түлхүү ашиглах, холбогдох хуульд заасны дагуу хэрэглэсэн усыг дахин ашиглах, уул уурхайн салбарын ахуйн хэрэглээнд саарал усыг ашиглах, орчин үеийн дэвшилтэт технологийг дэмжих (ТЭБСББ, 3.6.4. дүгээр заалт).

Зорилт 4. Боловсруулах салбарыг хөгжүүлэхдээ зах зээл дэх өрсөлдөх чадвар, үйлдвэрлэлд зарцуулагдах усны хэрэглээ болон үйлдвэрлэлээс гарах хорт хаягдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл зэрэг хүчин зүйлийг цогцоор нь судалж, шийдвэр гаргах (ТЭБСББ, 3.4.1. дүгээр заалт).

Зорилт 5. Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 25 хувьд хүргэж, дэвшилтэт технологи, инновацид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 70 хувьд хүргэх (МУТХҮБ-2030, Зорилт 1).

Бодлогын тэргүүлэх чиглэл 7. Салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, давтан сургах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Салбарын мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод үе шаттай бэлтгэх, давтан сургах, цалин хөлсний урамшууллын тогтолцоог бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Уул уурхайн салбарын удирдах ажилтны тогтвортой ажиллах нөхцөлийг хангах, мэргэшсэн инженер, техникийн ажилтныг дотоод, гадаадын зохих шатны сургуульд бэлтгэж, чадавхжуулах, тэдний мэргэжлийн ур чадвартай уялдсан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бий болгох (Хэлэлцүүлгээс).

4.2.4. Хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын зорилго нь дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгож, аж үйлдвэрийн салбарыг Монгол Улсын Тогтвортой хөгжлийг хангах тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд оршино (“Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”, 3.1. дэх хэсэг).

4.2.4.1. Арьс ширний салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Салбарын төрийн бодлого, зохицуулалт, хууль, эрх зүй, дүрэм, журмын уялдааг хангах (шинээр томъёолсон)

Зорилт 1. Арьс ширний салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх (МУТХҮБ-2030, 2.1.3. дугаар заалт).

Зорилт 2. Арьс ширэн бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээний салбарын хөгжих таатай орчныг бүрдүүлэх, экспортыг төрөлжүүлэх.

Зорилт 3. Нийт боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэх (МУТХҮБ-2030, 2.1.3. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Салбарын засаглалын тогтолцоог сайжруулах (Хэлэлцүүлгээс)

Зорилт 1. Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 25 хувьд хүргэж, дэвшилтэт технологи, инновацид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх (МУТХҮБ-2030, 2.1.3. дугаар заалт).

Зорилт 2. Арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 70 хувьд хүргэх (МУТХҮБ-2030, 2.1.3. дугаар заалт).

Зорилт 3. Арьс ширний салбарт экспорт давамгайлсан аж үйлдвэрийн бүтцийг бий болгож, өндөр технологи, машин, тоног төхөөрөмж, химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх (МУТХҮБ-2030, 2.1.3. дугаар заалт).

Зорилт 4. Арьс ширний салбарт төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааг дэмжих (МУТХҮБ-2030, 2.1.3. дугаар заалт).

Зорилт 5. Арьс ширний салбарын эрдэм шинжилгээний байгууллагыг үүсгэж, үйл ажиллагааг нь төрөөс дэмжих (Хэлэлцүүлгээс⁵).

Зорилт 6. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх (МУТХҮБ-2030, 2.1.3. дугаар заалт).

Зорилт 7. Арьс ширний салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, салбарын шинэ технологи, инновацийн хөгжлийг бодлогоор дэмжих (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хомсдлыг арилгах (шинээр томъёолсон)

Зорилт 1. Арьс ширний салбарт дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, инновацид суурилсан, эдийн засаг, нийгмийн үр ашиг бүхий боловсруулах, дахин боловсруулах бүтээлч аж үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжих (МУТХҮБ-2030, 2.1.3. дугаар заалт).

Зорилт 2. Хөнгөлөлттэй зээлийн хугацааг уртасгах (Хэлэлцүүлгээс).

⁵ МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэлэлцүүлэг, ҮХГ, 2018.

Зорилт 3. Аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн хэсгийн санхүүжилтийг шийдэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 4. Салбарын бүтээгдэхүүний нэр төрөл, чанар, иж бүрдэл, стандартыг сайжруулах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Арьс ширний салбарын бүтээгдэхүүний стандартыг шинэчлэн тогтоох (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 5. Салбарын хүний нөөц, ажиллах хүчний ур чадвар, мэргэжлийн сургалтыг чанаржуулах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Арьс ширний салбарын мэргэжилтнийг бэлтгэх тогтолцоог бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Арьс ширний салбарын хүний нөөцийг бэлтгэх, ур чадварыг дээшлүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх (МУТХҮБ-2030, 2.1.3. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 6. Салбарын түүхий эд, материалын нөөц, чанар, хангамжийг нэмэгдүүлэх (шинээр томьёолсон)

Зорилт 1. Арьс ширний салбарын түүхий эдийн чанар, стандартыг дээшлүүлэх (Хэлэлцүүлгээс).

4.2.4.2. Ноос, ноосон эдлэл, ноосон үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх (МУТХҮБ-2030)

Зорилт 1. Түүхий эдийн нөөцөө бүрэн ашиглаж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэх талаарх төрийн бодлого, хууль эрх зүйн орчинг оновчтой болгож, хэрэгжилтийг хангуулах (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хомсдлыг арилгах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Ногоон үйлдвэрлэлийн стандарт, байгаль орчинд халгүй, хаягдалгүй, үр ашигтай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай химийн бодис урвалжийг хянах, саармагжуулах, дахин ашиглах системийг бий болгож, төр орон нутгийн санхүүжилтээр дэмжих (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Салбарын хүний нөөц, ажиллах хүчний ур чадвар, мэргэжлийн сургалтыг чанаржуулах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Орчин үеийн техник, технологийг удирдах, эзэмших чадвар бүхий мэргэжилтэнтэй боловсон хүчнийг бэлтгэх бодлогыг оновчтой болгож, үйлдвэрлэлд тогтвортой ажиллах цалин хангамж, нийгмийн асуудлыг цогцоор шийдвэрлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 4. Салбарын түүхий эд, материалын нөөц, чанар, хангамжийг нэмэгдүүлэх (шинээр томьёолсон)

Зорилт 1. Түүхий эд бэлтгэлийн системийг шинэчлэн тогтоох, эрүүл ахуйн шаардлага хангасан малын ноосыг хяргах, савлах, баглах, хадгалах, тээвэрлэх, үйлчилгээний мэргэшсэн, төрөлжсөн байгууллагуудыг бий болгон хөдөлмөр хөнгөвчлөх, бүтээмж дээшлүүлэх арга хэмжээ авч, чанар, өртөг зардлын норматив,

стандартуудыг тогтоох (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 5. Ноос, ноосон эдлэл, ноосон үйлдвэрлэлийг дэмжих эдийн засгийн бодлогын механизмуудыг ашиглах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Ноосон эдлэлийн экспорт, импортыг орлох бүтээгдэхүүний эдийн засагт оруулж байгаа орлогын өсөлтөөс салбарын санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгцээг урамшуулдаг механизмыг тогтоох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлд техник, технологийн шинэтгэл хийхэд оруулсан хөрөнгө оруулалтыг урт хугацааны зээл, үнэ тариф, татварын ялгавартай бодлогоор дэмжиж, дотоодын зах зээлийг хамгаалах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Дотоодын ноосон эдлэлийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжиж, ард иргэдийн худалдан авалтыг идэвхжүүлэх (Хэлэлцүүлгээс).

4.2.4.3. Ноолуур, ноолууран эдлэл, ноолууран нэхмэлийн үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Салбарын төрийн бодлого, зохицуулалт, хууль, эрх зүй, дүрэм, журмын уялдааг хангах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Ноолуурын салбарт тогтвортой урт хугацааны бодлого явуулж, бодлогын залгамж чанарыг хангах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Ногоон хөгжлийн бодлогод нийцүүлэн байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Хөнгөн үйлдвэрийн салбарын кластерын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Салбарт тэргүүлэх дэвшилтэт техник, технологийг ашиглах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Технологийн паркийн хүрээнд эрдэм шинжилгээ, судалгаа хосолсон цогцолбор үйлдвэрийг байгуулах, ээрэх, гүйцэтгэн боловсруулах техник технологид оруулах хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжих (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Салбарын хүний нөөц, ажиллах хүчний ур чадвар, мэргэжлийн сургалтыг чанаржуулах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Ноолуурын салбарын хүний нөөцийг, ялангуяа инженер, техникийн ажилтнууд, нарийн мэргэжлийн ажилтнуудыг олноор нь бэлтгэх, тэдгээрийн ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, давтан сургах, тогтвортой ажиллуулах урамшууллын тогтолцоог хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Экспортод гаргах шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг олшруулж, бүтээгдэхүүний загвар, дизайныг сайжруулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор үйлдвэрлэлийн дэд бүтцийн таатай орчинг бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 4. Салбарын үйлдвэрлэлийг дэмжих эдийн засгийн бодлогын механизмуудыг ашиглах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Ноолуурын салбарт татварын таатай, тогтвортой эрх зүйн орчныг

бүрдүүлэх, ялангуяа түүхий эд бэлтгэгчдийг нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-т хамруулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Ноолуурын салбарын үйлдвэрлэлийн зориулалттай хагас боловсруулсан бүтээгдэхүүнд НӨАТ ногдуулахгүй байх, түүхий эдээ тушаасан тохиолдолд НӨАТ-ыг буцаан олголтоор урамшуулах (Хэлэлцүүлгээс).

4.2.4.4. Оёдол, хувцас үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Салбарын төрийн бодлого, зохицуулалт, хууль, эрх зүй, дүрэм, журмын уялдааг хангах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Хувцас үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэлийг дэмжсэн, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, боловсронгуй болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Оёдлын үйлдвэрүүдийг үйлдвэрлэл, технологийн паркийн зарчмаар хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодор гүйцэтгүүлж, төрөөс дэмжлэг үзүүлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Салбарт тэргүүлэх дэвшилтэт техник, технологийг ашиглах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Салбарын хөгжилд шаардагдах дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх болон нутагшуулахад дэмжлэг үзүүлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Салбарын үйлдвэрлэлийг дэмжих эдийн засгийн бодлогын механизмуудыг ашиглах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Үндэсний үйлдвэрлэлийг төрийн болон дотоодын худалдан авалт, санхүү зээлийн бодлогоор дэмжих, тусгай сан байгуулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний борлуулалт болон түүхий эд, материалыг бэлтгэн нийлүүлэлтэд үе шаттай санхүүгийн дэмжлэг үзүүлэх (Хэлэлцүүлгээс).

4.2.4.5. Ой мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Салбарт төрийн эдийн засгийн бодлого, зохицуулалт, хууль, эрх зүй, дүрэм, журмын зохицуулалтыг сайжруулах (Хэлэлцүүлгээс)

Зорилт 1. Бэлчээр, тариалангийн талбай, авто зам, төмөр замын сүлжээг хамгаалах зориулалт бүхий ойн зурвас, хот, суурин газар ногоон байгууламж байгуулах ажлын зардлыг захиалагч болон ашиглагчийн зураг төсөв, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ("Төрөөс ойн талаар баримтлах бодлого" (ТОТББ), 3.2.5. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Салбарын бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох (шинээр томьёолсон)

Зорилт 1. Ой мод, модон бүтээгдэхүүний салбарын институцийн удирдлага, тогтолцоо, зохион байгуулалт, чиг үүрэг, төр, төрийн бус байгууллагуудын уялдааг хангах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Ой мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн /эрчим хүч, зам тээвэр/ экологи, кластер болон цогцолборыг байгуулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн дэргэд ойжуулалт, нөхөн сэргээлт, ой хамгаалал, мод ашиглах, боловсруулах үйлдвэрлэлийн дэвшилтэт технологи боловсруулах, нэвтрүүлэх, дамжуулах нэгж, инкубаторийн төв, өндөр технологийн жижиг, дунд үйлдвэр байгуулахыг төрөөс дэмжих (ТОТББ, 3.5.3. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Салбарын хүний нөөц, ажиллах хүчний ур чадвар, мэргэжлийн сургалтыг чанаржуулах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Ой модны салбарын хүний нөөц, ажиллах хүчний хүрэлцээ, боловсон хүчний хөгжил, мэргэжлийн сургалт, ур чадварыг дээшлүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Ойн мэргэжлийн их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн материаллаг баазыг бэхжүүлэх, багш нарын чадавхыг дээшлүүлэх ажилд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх, улмаар ойн мэргэжилтэн, мэргэжлийн ажилтан, ажилчин бэлтгэх шаталсан сургалттай тогтолцоо бий болгох (ТОТББ, 3.5.4. дүгээр заалт).

Зорилт 3. Олон нийтийн мэдээлэл, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, ойн экологийн үнэ цэнийг иргэдэд ойлгуулах талаар бүх нийтийг хамарсан ажил өрнүүлэх, ойн салбарын мэдээ, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх мэргэжлийн сэтгүүл, студи байгуулахыг төрөөс дэмжих (ТОТББ, 3.5.5. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 4. Салбарт тэргүүлэх дэвшилтэт техник, технологийг ашиглах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Тарьц, суулгац ургуулах дэвшилтэт шинэ технологи нэвтрүүлж, ойжуулалтын ажлын чанарыг сайжруулж, улирлын хамаарлыг багасгах (ТОТББ, 3.2.2. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 5. Салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хомсдлыг арилгах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Ойг нөхөн сэргээх, ойжуулах, таримал ойг худалдан авах санхүүжилтийг үе шаттай нэмэгдүүлэх (ТОТББ, 3.2.6. дугаар заалт).

Зорилт 2. Ойн цэвэрлэгээгээр бэлтгэсэн хатсан болон унанги мод, ойн бусад үлдэгдлийг боловсруулан, төрөл бүрийн модлог хавтан, шахмал болон био түлшний дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, ойн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах (ТОТББ, 3.3.5. дугаар заалт).

Зорилт 3. Ойн нөхөрлөл өөрийн эзэмшлийн ойд менежментийн төлөвлөгөөний дагуу бие даасан үйл ажиллагаа явуулахад санхүүгийн болон техник, технологийн дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжүүлэх (ТОТББ, 3.3.10. дугаар заалт).

Зорилт 4. Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд хувийн болон аж ахуйн нэгж, байгууллагаас оруулах хөрөнгө оруулалтыг дэмжих хөшүүрэг, механизмыг бий болгох (ТОТББ, 3.4.2. дугаар заалт).

Зорилт 5. Ойн салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цөлжсөн бүс нутгийг ойжуулах томоохон төслийг олон улсын байгууллага, бусад орны дэмжлэг, тусламжаар хэрэгжүүлэх (ТОТББ, 3.4.3. дугаар заалт).

Зорилт 6. Ойн хүлэмжийн хий шингээх, хүчилтөрөгч ялгаруулах, хөрс, ус болон биологийн олон янз байдлыг хамгаалах зэрэг экологийн ач холбогдлыг үнэлсэн экосистемийн үйлчилгээний төлбөрийг бий болгон мөрдөх (ТОТББ, 3.4.4. дүгээр заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 6. Ой мод, модон бүтээгдэхүүний салбар ба бусад салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх (шинээр томьёолсон)

Зорилт 1. Ой модны салбар ба бусад салбарын уялдаа, холбоог хангах (Байгаль орчин, цэвэр усны хангамж, хог хаягдал, бохир ус, зам тээвэр, харилцаа, холбоо) (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор байгалийн гамшиг болон хууль бус мод бэлтгэл, уул уурхайн олборлолт, хүний хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас устсан ойг нэн тэргүүнд нөхөн сэргээх (ТОТББ, 3.2.7. дугаар заалт).

4.2.4.6. Хүнсний үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Салбарт төрийн эдийн засгийн бодлого, зохицуулалт, хууль, эрх зүй, дүрэм, журмын зохицуулалтыг сайжруулах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр хүн амыг жигд, хүртээмжтэй хангах, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, импорт орлох хүнсний үйлдвэрлэлийг дэмжих (ТХХААтББ, 4.1.2. дугаар заалт).

Зорилт 2. Стратегийн хүнсний улирлын нөөцийг эрэлт, нийлүүлэлт, хэрэглээний онцлогтой уялдуулан хувийн хэвшлийн оролцоотойгоор бүрдүүлэх (ТХХААтББ, 4.1.3. дугаар заалт).

Зорилт 3. Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авах, анхан шатны болон хагас боловсруулалт хийх нөхцлийг бүрдүүлэх, хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх (ТХХААтББ, 4.1.5. дугаар заалт).

Зорилт 4. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импортыг хязгаарлах, хэрэглээнд нөлөөлөх, дэлхий нийтээр хэрэглээнээс хасаж байгаа өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ, импорт, худалдааг хориглох (ТХХААтББ, 4.1.12. дугаар заалт).

Зорилт 5. Хүнсний үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх (МУТХҮБ-2030, Зорилт 2).

Зорилт 6. Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх (МУТХҮБ-2030, Зорилт 2).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Хүнсний салбарын бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох (шинээр томьёолсон)

Зорилт 1. Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог төлөвшүүлж хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх (ТХХААтББ, 4.1.6. дугаар заалт).

Зорилт 2. Хүнсний сүлжээний бүх үе шатанд хадгалалт, тээвэрлэлтийн стандарт,

шаардлага хангасан ложистик сүлжээг хөгжүүлэх (ТХХААтББ, 4.1.7. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Хүнсний салбарт тэргүүлэх дэвшилтэт техник, технологи ашиглах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх үе шатанд хэрэглэх, дэвшилтэт технологийг нутагшуулах, үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг дэмжих (ТХХААтББ, 4.1.10. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 4. Хүнсний салбар ба бусад салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх (шинээр томьёолсон)

Зорилт 1. Хүнсээр дамжуулан хүний эрүүл мэндэд хохирол учруулж байгаа зөрчилд хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлэх, зөрчилтэй эвлэрсэн ойлголт, хандлагыг өөрчлөх, тавигдах шаардлагыг өндөрсгөх, нутгийн захиргааны байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааны үр дүнтэй арга хэлбэрийг хэвшүүлэх (ТХХААтББ, 4.1.11. дүгээр заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 5. Хүнсний салбарын түүхий эд, материалын нөөц, чанар, хангамжийг нэмэгдүүлэх (шинээр томьёолсон)

Зорилт 1. Малын эм, бордоо, ургамал хамгааллын бэлдмэл, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх үлдэгдэл бодис, тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг тодорхойлох чадавх, хяналтыг сайжруулах (ТХХААтББ, 4.1.9. дүгээр заалт).

4.2.4.7. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Салбарт төрийн эдийн засгийн бодлого, зохицуулалт, хууль, эрх зүй, дүрэм, журмын зохицуулалтыг сайжруулах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох (Хэлэлцүүлгээс⁶).

Зорилт 2. Хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлэх (МУТХҮБ-2030, Зорилт 2).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Салбарын бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох (шинээр томьёолсон)

Зорилт 1. Төрөөс үйлдвэрлэлийн хөгжил, байршлыг тодорхойлж, дэд бүтцийг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Салбарын эрдэм шинжилгээ, судалгааг хөгжүүлж, үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, инновацийг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Мах, махан бүтээгдэхүүний салбарт кластерын тогтолцоог нэвтрүүлж, хаягдалгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

6 МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх Хүнс үйлдвэрлэлийн салбарын дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэлэлцүүлэг, ҮХГ, 2018.

Зорилт 4. Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан мах, сүүн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх (ТХХААтББ, 4.1.4. дүгээр заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Салбарын хүний нөөц, ажиллах хүчний ур чадвар, мэргэжлийн сургалтыг чанаржуулах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын хүний нөөцийг чадавхжуулах (Хэлэлцүүлгээс).

4.2.4.8. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Салбарт төрийн эдийн засгийн бодлого, зохицуулалт, хууль, эрх зүй, дүрэм, журмын зохицуулалтыг сайжруулах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарыг тогтвортой хөгжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Үндэсний үйлдвэрт чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан сүү нийлүүлсэн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд сүүний урамшуулал олгох механизмыг бүрдүүлж хэрэгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Орон нутгийн ашиглагдахгүй байгаа сүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Салбарын бодлогыг хэрэгжүүлэгч институтийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох (шинээр томьёолсон)

Зорилт 1. Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх.

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Салбарт тэргүүлэх дэвшилтэт техник, технологийг ашиглах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Сүүний гарал үүслийг баталгаажуулах, ул мөрийг мөшгөх тогтолцоог болон импортын бүтээгдэхүүний хяналтыг сайжруулах, лабораторийн чадавхыг дээшлүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Сүү, сүүн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, инновацийг нэвтрүүлэх, салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар экспортыг нэмэгдүүлэх (Хэлэлцүүлгээс).

4.2.4.9. Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Салбарт төрийн эдийн засгийн бодлого, зохицуулалт, хууль, эрх зүй, дүрэм, журмын зохицуулалтыг сайжруулах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбартай холбогдох хууль, дүрэм, журмыг сайжруулах, шинээр бий болгох (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Салбарын бодлогыг хэрэгжүүлэгч институтийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох (шинээр томьёолсон)

Зорилт 1. Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын бодлогыг

хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, сайн засаглалыг бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй компанийн засаглал, менежментийг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Бүтээгдэхүүний болон сав баглаа боодлын стандарт, чанарыг сайжруулах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, маркетингийн тогтолцоог боловсронгуй болгох (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбар ба бусад салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх (шинээр томьёолсон)

Зорилт 1. Үйлдвэрлэлийн дэд бүтэц (эрчим хүч, зам тээвэр, ус, цэвэрлэх байгууламж), аж үйлдвэрлэлийн экологи (уялдаа)-ийг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 4. Салбарт тэргүүлэх дэвшилтэт техник, технологийг ашиглах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын барилга, тоног төхөөрөмжийн хангамжийг дээшлүүлэх, сайн технологи нэвтрүүлэх (Хэлэлцүүлгээс).

4.2.4.10. Ус, ундаа, жүүс, исгэлтийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Салбарын бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох (шинээр томьёолсон)

Зорилт 1. Ус, ундаа, шүүс, исгэлтийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын байгууллагуудын үйл ажиллагааны чиг үүргүүдийг нарийвчлан, хоорондын уялдааг сайжруулж, бодлогын нэгдмэл цогц залгамж чанарыг хадгалах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Импортын ижил төрлийн бүтээгдэхүүний татварыг нэмэгдүүлж, дотоодын зах зээлийг хамгаалах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Ундаа, шүүсэнд агуулагдаж буй элсэн чихрийн хэмжээг үе шаттайгаар бууруулах стратеги боловсруулж хэрэгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Мэргэжлийн холбоод, нийгэмлэгийн чадавхыг сайжруулж, чиг үүргийг бодлогоор нэмэгдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 5. Хүн амд хүнсний хэрэглээний талаар шинжлэх ухааны нотолгоонд суурилсан үнэн зөв мэдээллийг хүргэж, сурталчлах (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Салбарын хүний нөөц, ажиллах хүчний ур чадвар, мэргэжлийн сургалтыг чанаржуулах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Салбарын боловсон хүчнийг үе шаттай бэлтгэхэд анхаарах (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Ус, ундаа, жүүс, исгэлтийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбар ба бусад салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх (шинээр томьёолсон)

Зорилт 1. Цэвэр ус үйлдвэрлэхэд шаардагдах үйлдвэрлэлийн дэд бүтэц, шугам хоолой, шүүлтүүрийг шинэчлэх (Хэлэлцүүлгээс).

4.2.4.11. Хоол, нийтийн хоолны салбар, хоол үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Салбарт төрийн эдийн засгийн бодлого, зохицуулалт, хууль, эрх зүй, дүрэм, журмын зохицуулалтыг сайжруулах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт төрөөс баримтлах бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулах.

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Салбарын бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох (шинээр томьёолсон)

Зорилт 1. Нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулсан түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, хагас боловсруулсан бүтээгдэхүүний үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний хангамжийн ложистикийг бий болгох, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх (ТХХААТББ, 4.1.16. дугаар заалт).

Зорилт 2. Хүнсний түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, түүнийг хадгалах, үйлдвэрлэх, тээвэрлэх, борлуулах явцад чанарыг алдагдуулахгүй байх иж бүрэн тогтолцоог бий болгох, хангамжийн ложистик системийг бий болгоход дэмжлэг үзүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Нийтийн хоолны шим тэжээл, чанар, түүнд тавих хяналтыг сайжруулах, нийтийн хоолны үйлдвэрлэлд зэрэглэл тогтоох (ТХХААТББ, 4.1.14. дүгээр заалт).

Зорилт 4. Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах оролцоог нэмэгдүүлэх (ТХХААТББ, 4.1.18. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Салбарын хүний нөөц, ажиллах хүчний ур чадвар, мэргэжлийн сургалтыг чанаржуулах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Хоол үйлдвэрлэлийн салбарт хүний нөөцийг хөдөлмөрийн эрэлт, ур чадвар, мэргэжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бэлтгэх, давтан сургах тогтолцоог хөгжүүлэх, тогтвортой ажиллах механизмыг бий болгох (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 4. Хоол, нийтийн хоолны салбар, хоол үйлдвэрлэлийн салбар ба бусад салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх (шинээр томьёолсон)

Зорилт 1. Хөдөө аж ахуй, газар тариалан, хоол хүнс үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын уялдаа холбоог хангах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Хоол үйлдвэрлэлийг хүний эрүүл мэндийг дэмжих чиглэлээр хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 5. Салбарт тэргүүлэх дэвшилтэт техник, технологийг ашиглах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Хоол, нийтийн хоолны салбар, хоол үйлдвэрлэлийн салбарт шинжлэх ухаан технологи, инновацийг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Нийтийн (сургууль, цэцэрлэг, эмнэлэг, цэргийн анги, хорих газар болон тэдгээртэй адилтгах бусад газар) хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, шим тэжээлийн агууламжийг дээшлүүлэх, нэгдсэн жор, технологийг боловсруулах, мөрдүүлэх, тоног

төхөөрөмжийн шинэчлэлт хийх, дотоод хяналтыг сайжруулах (ТХХААтББ, 4.1.15. дугаар заалт).

4.2.4.12. Бусад хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл (Хүнсний ногоо, хүнсний ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбар, зөгийн бал, жимс жимсгэний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, амттан чихэр, шоколад, чипс гэх мэт), бүх төрлийн будаа, элсэн чихэр болон импортын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын Тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Салбарын бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох (шинээр томьёолсон)

Зорилт 1. Хүнсний тухай хууль, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилт, хүнсний бүтээгдэхүүний зохиогчийн эрхийн хамгаалалтыг сайжруулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулах, хадгалалтын нэгдсэн (нэр төрлөөр нь ангилан төрөлжүүлсэн хадгалалт, агуулах) стандартыг бий болгож, тээвэрлэлт борлуулалт, зохион байгуулалтын нэгдсэн кластерын сүлжээг байгуулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Ургамал, мал амьтны гаралтай хүнсний түүхий эдийн хяналтыг сайжруулж, түүхий эд, нөөцийг бүрэн ашигладаг болох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Сав, баглаа боодол болон хаяг шошгын олон улсын болон үндэсний (пластик, полимер, нийлэг бүтээгдэхүүний хяналт, хязгаарлалт, зөвшөөрлийн) нэгдсэн стандартыг бий болгон мөрдүүлж, сав, баглаа боодлын түүхий эдийн импортын лицензийг сэргээх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Салбарын хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх (шинээр томьёолсон)

Зорилт 1. Хүнсний үйлдвэрлэлийг дэмжих зээлийн шалгуурыг тодорхой болгож, барьцаагүй, итгэлцлийн хөнгөлөлттэй зээл олгон, түүний хүүг бууруулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлж, төрөөс худалдан авах шалгуур үзүүлэлтийг тодорхой болгон, хүнсний бүтээгдэхүүний импортлогчдыг лицензжүүлэн квот тогтоож, ногоон эдийн засгийн тэргүүлэх үйлдвэрлэлд төрөөс татаас, урамшуулал олгох (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Салбарт тэргүүлэх дэвшилтэт техник технологийг ашиглах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Хүнсний үйлдвэрийн барилга байгууламж, техник, технологийн хангамжийг нэмэгдүүлж, хүчин чадлын ашиглалтыг сайжруулан хүнсний бүтээгдэхүүний лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх (Хэлэлцүүлгээс).

4.2.5. Эрчим хүчний салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах (“Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого” (ТЭХтББ), 3.1.1. дүгээр заалт)

Зорилт 1. Эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх (Хэлэлцүүлгээс⁷).

Зорилт 2. Эрчим хүчний чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх (ТЭХТББ, 3.1.5. дугаар заалт).

Зорилт 4. Эрчим хүчний хэрэгцээнийхээ 90 хувийг дотоодын эх үүсвэрээр хангах (МУТХҮБ-2030, Зорилт 1).

Зорилт 5. Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 25-д хүргэх, цөмийн эрчим хүч ашиглах бэлтгэл ажлыг бүрэн хангах (МУТХҮБ-2030, Зорилт 2).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Салбарын бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох (шинээр томьёолсон)

Зорилт 1. Эрчим хүчний эдийн засаг, үйлдвэрлэл, туршилт, тохируулгын судалгаа, хөгжлийн үндэсний хүрээлэнг хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх (ТЭХТББ, 2.3.2. дугаар заалт).

Зорилт 2. Эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Салбарын санхүү, хөрөнгө оруулалтын чадавхыг бэхжүүлэх (шинээр томьёолсон)

Зорилт 1. Эрчим хүчний чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангаж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 4. Салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, давтан сургах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Эрчим хүчний инженер-техникийн ажилтан бэлтгэх дотоодын сургалтын байгууллагын сургалтын чанарыг сайжруулах, салбарын инженер-техникийн ажилтан, менежерийн чадамжийг олон улсын түвшинд хүргэх (ТЭХТББ, 3.2.3.1. дэх хэсэг).

Зорилт 2. Эрчим хүчний салбарын хүний нөөцийн балансыг зохистой түвшинд хадгалан, удирдлагын бүх түвшинд мэргэжлийн боловсон хүчний шаталсан байршуулалтын тогтолцоог мөрдөх (ТЭХТББ, 3.2.3.3. дахь хэсэг).

Зорилт 3. Эрчим хүчний салбарын хүний нөөцийн балансыг зохистой түвшинд хадгалан, удирдлагын бүх түвшинд мэргэжлийн боловсон хүчний шаталсан байршуулалтын тогтолцоог мөрдөх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 5. Эрчим хүчний салбарын гадаад, дотоод хамтын ажиллагааг эрчимжүүлэх (шинээр томьёолсон)

Зорилт 1. Олон улсын байгууллага, бүс нутгийн орнуудын эрчим хүчний хамтын ажиллагааны санал санаачилгад идэвхтэй оролцох, хамтран ажиллах (ТЭХТББ, 3.2.2.2. дахь хэсэг).

7 МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх Эрчим хүчний салбарын дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэлэлцүүлэг, ҮХГ, 2018.

Зорилт 2. Монгол орны говийн бүсийн нар, салхины арвин нөөцөд тулгуурлан том чадлын сэргээгдэх эрчим хүчний цогцолбороос Зүүн хойд Азийн орнуудад цахилгаан экспортлох Гобитек-Азийн нэгдсэн сүлжээ санаачлагыг хэрэгжүүлэхэд бүс нутгийн орнуудтай хамтран ажиллах (ТЭХтББ, 3.2.2.3. дахь хэсэг).

Зорилт 3. Хөрш орнуудтай эрчим хүч импортлох, экспортлох урт хугацааны харилцан ашигтай гэрээ байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэх (ТЭХтББ, 3.2.2.1. дэх хэсэг).

Бодлогын тэргүүлэх чиглэл 6. Эрчим хүчний салбарт тэргүүлэх дэвшилтэт техник, технологийг ашиглах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааны удирдлага, хяналт, мэдээллийн системийг тоон системд бүрэн шилжүүлж, нэгдсэн ухаалаг сүлжээг бий болгох (ТЭХтББ, 3.2.5.1. дэх хэсэг).

Зорилт 3. Үндэсний хэмжээнд эрчим хүчний хэмнэлтийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэглэгч талын менежментийг хөгжүүлэх (ТЭХтББ, 3.2.5.4. дэх хэсэг).

4.2.6. Барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Салбарын бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын үйл ажиллагааг боловсронгуй болгох (шинээр томьёолсон)

Зорилт 1. Барилгын материалын үйлдвэрлэлийн бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлэх (Хэлэлцүүлгээс⁸).

Зорилт 2. Барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын судалгаа, шинжилгээ - ний байгууллагыг байгуулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Барилгын материалын чанарт шинжилгээ, лавлагаа хийх лабораторийг байгуулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Барилгын материалын чанар, стандартад тавих хяналт шалгалт, баталгаажуулалтыг сайжруулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 5. Орон нутгийн түүхий эдийн нөөцөд тулгуурлан барилгын материалын үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Салбарыг мэргэжлийн хүмүүсээр удирдуулах, улс төрийн нөлөөллөөс ангид болгох (шинээр томьёолсон)

Зорилт 1. Барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын хууль, дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох замаар салбарын бодлого зохицуулалтыг сайжруулах (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Салбарын хөгжлийг хангахад төрийн зохицуулалтын механизмыг ашиглах (шинээр томьёолсон)

8 МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх Барилгын салбарын дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэлэлцүүлэг, ҮХГ, 2018.

Зорилт 1. Барилгын материалын үйлдвэрлэлийг гааль, татварын хөнгөлөлт чөлөөлөлт, татаас, урамшуулал, төрийн худалдан авалтаар дэмжих (шинээр томьёолсон).

Зорилт 2. Барилгын материалын гол нэрийн бүтээгдэхүүний (цемент, төмөр хийц, модон эдлэл) дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 4. Салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, давтан сургах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх нэгдсэн бодлого боловсруулж, давтан сургах тогтолцоог хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

4.2.7. Барилгын салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Хууль эрх зүй, дүрэм, стандарт, хяналтын тогтолцоог бүрдүүлэх

Зорилт 1. Барилгын салбарын ойрын болон дунд хугацааны хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг бий болгож хэрэгжүүлэх, хянах байгууллагын удирдлагын тогтолцоог шинэчлэх, олон улсын жишигт нийцсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хянах тогтолцоог бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Шинэчлэгдсэн "Барилгын тухай" хуулийг дагалдсан барилгын норм, стандарт, дүрэм журмын шинэчлэлтийг хийж, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ (ОСНААҮ)-ний байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулийг боловсронгуй болгох, ажилчдад өндөр цалин өгөх боломжийг бүрдүүлэх, хууль, тогтоомжийн тогтвортой байдлыг хангах, зөвлөх ажил үйлчилгээний хуультай болох (Хэлэлцүүлгээс болон "Төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого").

Зорилт 3. Барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг хангах хяналтын тогтолцоог боловсронгуй болгох (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Салбарын удирдлага, зохион байгуулалтыг шинэчлэх

Зорилт 1. Түүхий эд, материалын нөөц хангалттай нөхцөлд импортын материалыг хязгаарлах, Монголд үйлдвэрлэсэн материалыг ашиглахыг дэмжих (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг хангах хяналтын тогтолцоог боловсронгуй болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Барилга угсралтын ажлыг хот төлөвлөлттэй уялдуулах замаар барилгын гадна дэд бүтэц, инженерийн байгууламжийг цогцоор нь хонгилын системд шилжүүлэх, тоног төхөөрөмж, угсралтын стандартыг боловсронгуй болгож смарт технологи руу шилжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Салбарын эрдэм шинжилгээ, судалгааны төв байгуулах, боловсон хүчний ур чадварыг нэмэгдүүлэх (Хэлэлцүүлгээс).

4.2.8. Худалдаа үйлчилгээ, дэд бүтцийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Хууль эрх зүй, байгууллагын тогтолцоог бэхжүүлэх

Зорилт 1. Худалдааны салбарын үйл ажиллагааг зохицуулах төрийн байгууллагын тогтолцоог бий болгох, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих (Хэлэлцүүлгээс⁹).

Зорилт 2. Гадаад болон дотоод худалдааны бие даасан хуультай болох, холбогдох журам, стандартыг боловсруулах, шинэчлэх, батлуулах, Монгол Улсын хууль тогтоомжуудыг олон улсын гэрээ, хэлэлцээрүүдтэй уялдуулах (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Стандарт хангасан худалдааны бүтцийг бий болгох

Зорилт 1. Бүсүүдэд загвар худалдааны төв, сүлжээ дэлгүүрийг бий болгож, тэдгээрийн бараа, бүтээгдэхүүнд чанар, стандартын хяналт тавих үйл ажиллагааг сайжруулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Худалдааны салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, мэргэшлийн ур чадварт суурилсан ажлын үнэлгээг бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Худалдааны салбарыг ложистикийн стандартын шаардлага хангасан лаборатори, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах (Хэлэлцүүлгээс).

4.2.9. Аялал жуулчлалын салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогыг сайжруулах

Зорилт 1. Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог сайжруулж, төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын оролцоог хангах (Хэлэлцүүлгээс¹⁰).

Зорилт 2. Аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсронгуй болгож, эрх зүйн орчныг сайжруулах (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх

Зорилт 1. Үйлчилгээний чанар, стандартыг сайжруулж, жуулчдын аялах таатай орчин, аюулгүй байдлыг хангах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх (Хэлэлцүүлгээс болон "Аялал жуулчлалыг 2016-2025 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр", МУТХҮБ-2030).

Зорилт 3. Жуулчин тээврийн төрөл, хүчин чадал, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг нэмэгдүүлж, аялал жуулчлалын дэд бүтцийг үе шаттай хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс болон "Аялал жуулчлалыг 2016-2025 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр", МУТХҮБ-2030).

Зорилт 4. Аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Компанийн засаглал, санхүү хөрөнгийн чадавхыг бэхжүүлэх

9 МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх Худалдаа үйлчилгээний салбарын дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэлэлцүүлэг, ҮХГ, 2018.

10 МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх Аялал жуулчлалын салбарын дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэлэлцүүлэг, ҮХГ, 2018.

Зорилт 1. Аялал жуулчлалын салбарын тогтвортой аялал жуулчлалын шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангасан аж ахуйн нэгжүүдийг төрөөс татвар, санхүү, зээлийн бодлогоор дэмжих (Хэлэлцүүлгээс болон "Аялал жуулчлалыг 2016-2025 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр", МУТХҮБ-2030).

Зорилт 2. Хүний нөөцийн урт хугацааны бодлого төлөвлөлтийг боловсруулж, сургалт, үйлдвэрлэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох (Хэлэлцүүлгээс болон "Аялал жуулчлалыг 2016-2025 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр", МУТХҮБ-2030).

4.2.10. Хот байгуулалтын салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Хууль эрх зүйн тогтолцоог шинэчлэн, хот байгуулалтад төлөвлөлтийн системийг нэвтрүүлэх

Зорилт 1. Хот байгуулалтын тухай суурь хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн салбарын бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох (Хэлэлцүүлгээс¹¹).

Зорилт 2. Барилгын салбарын хөгжилд шаардлагатай инженер, техникийн ажилтан, мэргэжлийн ажилчдыг төлөвлөгөө, системтэйгээр бэлтгэн, ахин дэвшүүлэх зарчмаар ажиллуулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. УИХ-ын 1996 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг цаг үеийн шаардлагад нийцүүлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын холбогдолтой шийдвэр гаргахад мэргэжлийн оролцоог нэмэгдүүлэх

Зорилт 1. Салбарын аж ахуйн нэгжүүдэд мэргэжлийн хүчин чадлаар нь зэрэглэл тогтоож, ажлын гүйцэтгэлийн чанар, үр дүнгээр нь үнэлэх тогтолцоог бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Зураг төсөл, инженер хайгуул, судалгааны ажлын чанар, үр дүнд хийх магадлалын үйл ажиллагааны хараат бус бие даасан байдлыг хангаж, хариуцлагын тогтолцоог сайжруулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. УИХ тухайн оны төсвийн тухай хуульд хөрөнгө оруулалтын хөтөлбөр, санхүүжилтийн дүнг батлахдаа, Засгийн газар төсөл, арга хэмжээ нэг бүрээр хэлэлцэхдээ татвар төлөгчдийн мэргэжлийн төлөөллөөр хянуулдаг механизм бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Үндэсний орон зайн мэдээллийн санг байгуулж, улсын хэмжээнд ашиглах (Хэлэлцүүлгээс).

4.2.11. Агаарын тээврийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Хууль эрх зүй, бодлого, байгууллагын тогтолцоог бэхжүүлэх

Зорилт 1. Агаарын тээврийг хөгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог

¹¹ МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх Барилгын салбарын дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэлэлцүүлэг, ҮХГ, 2018.

сайжруулж, төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын оролцоог хангах (Хэлэлцүүлгээс¹²).

Зорилт 2. Агаарын тээврийн цаашдын хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, холбогдох хууль тогтоомжид шаардлагатай өөрчлөлтийг оруулах (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Агаарын тээврийн хүчин чадал, гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх

Зорилт 1. Ерөнхий зориулалтын нисэх, аялал жуулчлалын нислэгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Нэгдсэн тээвэр, ложистикийн сүлжээг бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Төрөөс иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг навигацийн орлогын тодорхой хувиар санхүүжүүлэх тогтолцоог бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

4.2.12. Төмөр замын тээврийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Хууль эрх зүйд нийцүүлэн бие даасан байдлыг хангах, бодлогын шинэчлэл хийх

Зорилт 1. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцод дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, төрийн бодлогын баримт бичгийг хууль эрх зүйн шинжлэх ухааны үндэстэй болгох, улс төрийн болон хувийн ашиг сонирхлын оролцоог багасгах, тэдгээрийн уялдааг сайжруулж, хэрэгжүүлэх механизмыг бий болгох (Хэлэлцүүлгээс болон “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого” (ТТЗТББ), МУТХҮБ-2030).

Зорилт 2. Салбарын хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэхэд эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаач, мэргэжлийн холбоо, хэрэглэгчийн оролцоог хангасан нийгмийн түншлэл бүхий судалгааны байгууллага бий болгох (Хэлэлцүүлгээс болон ТТЗТББ, МУТХҮБ-2030).

Зорилт 3. Тээвэр, ложистикийн салбарын хүний нөөцийн бодлого, сургалтын тогтолцоог боловсронгуй болгох (Хэлэлцүүлгээс болон ТТЗТББ, МУТХҮБ-2030).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Төмөр замын хүчин чадлыг бэхжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх

Зорилт 1. Зам, тээврийн салбарын санхүүжилтийн оновчтой тогтолцоог бий болгох, хөрөнгө оруулалтын бодлогын үр өгөөжийг нэмэгдүүлэх (Хэлэлцүүлгээс болон ТТЗТББ, МУТХҮБ-2030).

Зорилт 2. Төмөр замын салбарын нөөц, хүчин чадлын ашиглалтыг сайжруулах, салбарын засвар үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх (Хэлэлцүүлгээс болон ТТЗТББ, МУТХҮБ-2030).

Зорилт 3. Салбарын нэгдсэн үнэ, тарифын уян хатан зохицуулалтыг бий болгох, төмөр замын өрсөлдөх чадвар, маркетингийг сайжруулах (Хэлэлцүүлгээс болон ТТЗТББ, МУТХҮБ-2030).

12 МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх Зам тээврийн салбарын дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэлэлцүүлэг, ҮХГ, 2018.

Зорилт 4. Үндэсний төмөр замын сүлжээ, суурь бүтцийг улсын эдийн засаг, нийгмийн хөгжил, батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах, нийтийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлыг хангахуйц түвшинд шинэчлэн өргөтгөж, транзит тээвэр, олон улсын төмөр замын сүлжээнд холбогдож, бүс нутгийн эдийн засгийн интеграцад идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлэх (ТТЗТтББ, МУТХҮБ).

4.2.13. Авто тээврийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Авто тээврийн салбарын удирдлага зохион байгуулалтын бүтцийг шинэчлэх

Зорилт 1. Авто тээврийн компанийн засаглалыг сайжруулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Нэгдсэн тээврийн бодлого буюу бусад тээврийн төрлүүдтэй хамтарсан үр ашигтай тээвэрлэлтийг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Тээвэрлэлтийн аюулгүй байдлын түвшинг дээшлүүлэх (Хэлэлцүүлгээс болон МУТХҮБ-2030).

Зорилт 4. Улс, хот, хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг олон улсын стандартын шаардлагад нийцүүлэх (Хэлэлцүүлгээс болон МУТХҮБ-2030).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Авто тээврийн үйлчилгээний чанар, стандартын түвшинг дээшлүүлэх

Зорилт 1. Үнэ, тарифын уян хатан бодлого баримтлах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Зориулалтын, стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслээр үйлчлэх (Хэлэлцүүлгээс болон МУТХҮБ-2030).

Зорилт 3. Тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн санхүү, үйл ажиллагааны чадавхыг дээшлүүлэх (Хэлэлцүүлгээс).

4.2.14. Авто замын байгууламжийн салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Авто замын хөгжлийн бодлого хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлэх

Зорилт 1. Салбарын инноваци, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг эрхлэх бүтцийг бий болгож, мэдээллийн санг цахимжуулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Авто замын салбарын төрийн бодлогын зорилтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллагыг бэхжүүлж тогтвортой ажиллуулах, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх үйл ажиллагааг дэмжих (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Авто зам, замын байгууламж байгуулах асуудлыг МУТХҮБ болон хүн амын нутагшил суурьшил, үйлдвэржилтийн бодлоготой нягт уялдуулж төлөвлөх тогтолцоог бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Авто замын байгууламжийн норм, стандартад тавих хяналтыг сайжруулах

Зорилт 1. Монгол орны нөхцөлд тохирсон авто замын байгууламж барих үндэсний технологи, стандарт, норм нормативыг боловсронгуй болгох замаар Техник

эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), зураг төсөл боловсруулах ажлыг шинэ шатанд гарган хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Авто замын барилга байгууламжийн хөрөнгө оруулалтыг олон эх үүсвэрээс бүрдүүлэх, замын сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх механизмыг бүрдүүлэх, ажлын чанарыг сайжруулах талаар гэрээний талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг ижил тэгш байлгах тогтолцоог бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Салбарын хууль тогтоомж, дүрэм журам, ажлын хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоог сайжруулах (Хэлэлцүүлгээс).

4.2.15. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

Зорилт 1. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрх зүйн тогтолцоо, зохион байгуулалтыг оновчтой болгох замаар салбарын хөгжлийн таатай орчныг бүрдүүлэх (“Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого” (ТМХХХтББ)).

Зорилт 2. Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, шаардлагыг хангах, мэдээлэл, харилцаа холбооны үндэсний суурь сүлжээ, дэд бүтцийг төрийн дэмжлэг, хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулах (ТМХХХтББ).

Зорилт 3. Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологид суурилсан үйлчилгээний төрөл, хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх (ТМХХХтББ).

4.3. Нийгмийн тогтвортой хөгжлийн дунд хугацааны бодлогын тэргүүлэх чиглэлүүд

МУТХҮБ-2030-ын 2.2. дахь хэсэгт “Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь жендэрийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ” гэж тодорхойлсон.

4.3.1. Хүн ам, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

“Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого” (ТХАХтББ) тусгагдсан дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд:

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Хүн амын өсөлтийг төрөөс дэмжих

Зорилт 1. Хүний нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэсэн чөлөөт сонголт бүхий зохистой төрөлтийг дэмжиж, өвчлөл, нас баралтыг бууруулах замаар хүн амын тогтвортой өсөлтийг хангана (ТХАХтББ).

Зорилт 2. Хүүхдийг оюун ухаан, бие бялдрын хувьд өв тэгш хөгжилтэй, эсэн мэнд,

эрүүл чийрэг, сайн сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлж, 20-39 насны эхчүүдийн 2-3 жилийн зайтай төрөлтийг түлхүү дэмжинэ (ТХАХтББ).

Зорилт 3. Гэр бүлийн хос 3 ба түүнээс дээш тооны хүүхэд төрүүлж, эсэн мэнд өсгөхийг урамшуулж, өрхийн орлогыг нь нэмэгдүүлэх чиглэл баримтална (ТХАХтББ).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Төрөөс хүн амын шилжих хөдөлгөөн, байршлыг оновчтой зохицуулах

Зорилт 1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан зах зээлийн эрэлт хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцсэн хүн амын байршлыг дэмжиж, дотоод шилжих хөдөлгөөний сөрөг үр дагаврыг арилган, гадаад шилжих хөдөлгөөний үр ашгийг нэмэгдүүлнэ (ТХАХтББ).

Зорилт 2. Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасган, байгаль орчны даац, түүний нөөцтэй уялдуулан хүн амын зохисгүй бөөгнөрлийг сааруулж, дагуул хот, бүсийн тулгуур төвүүд болон бүлэг сууринг түшиглэсэн орон нутагтаа суурин амьдрах хүн амын байршлыг дэмжинэ (ТХАХтББ).

Зорилт 3. Үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн Монголын иргэд хилийн чанадад амьдарч ажиллах, мэдлэг боловсрол эзэмших, өндөр хөгжилтэй орнуудын дэвшилтэт техник, технологийг эх орондоо нэвтрүүлэх санаачилгыг урамшуулж, иргэд харилцан сурч, хөдөлмөр эрхлэх талаар хоёр ба олон талт идэвхтэй хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжинэ (ТХАХтББ).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Гэр бүлийг төрийн бодлогын төвд байлгах

Зорилт 1. Гэр бүл нь хүний амьдралын анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж гэж үзэж түүний хөгжлийн тухай асуудлыг төрийн бодлогын төвд байлгана. Гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангана (ТХАХтББ).

Зорилт 2. Жендэрийн тэгш байдлыг эдийн засаг, нийгэм, улс төр, соёл, гэр бүлийн болон хүний эрхийн хүрээнд хангах, аливаа тэгш бус байдал, ялгаварлал, хавчин гадуурхлын бүх шалтгааныг багасган, улмаар арилгах чиглэл баримтална (ТХАХтББ).

Зорилт 3. Өсвөр үе, залуучуудыг оюун ухаан, бие бялдрын өв тэгш хөгжилтэй, нийгмийн хөгжлийг бүтээх, хяналт тавих, боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулах, шийдвэр гаргахад санаа бодлоо илэрхийлж оролцох чадвартай, идэвхтэй иргэд болгон төлөвшүүлэхэд төрийн бодлого чиглэгдэнэ (ТХАХтББ).

Зорилт 4. Залуу гэр бүлийг орон сууцаар хангах, орлогыг нь нэмэгдүүлэх, зээл, хөгжлийн тусламжид хамруулах боломжийг өргөжүүлнэ (ТХАХтББ).

Зорилт 5. Хүүхдийг үл хайхрах, хаях, доромжлох, хүчирхийлэх, хэрцгийлэх, гэмт хэрэг, садар самууны зорилгоор ашиглах, татан оруулах, дамжуулан худалдах зэрэг болзошгүй аюулаас хамгаална (ТХАХтББ).

4.3.2. Хөдөлмөр эрхлэлтийн талаарх дунд хугацааны бодлогын тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна (МУТХҮБ-2030, 2.2.1. дүгээр заалт, Зорилт 2).

Зорилт 2. Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг өндөр түвшинд байлгах (МУТХҮБ-2030, 2.2. дахь хэсэг).

Зорилт 3. Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг бүтээмжид суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоонд шилжүүлэх (МУТХҮБ-2030, 2.2. дахь хэсэг).

4.3.3. Боловсрол, соёл, урлаг, биеийн тамир, спортын салбарын бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Боловсролын салбарт олон улсын стандарт болон өөрийн орны онцлогийг харгалзсан шинэчлэлтийг хэрэгжүүлэх (шинээр томъёолсон)

Зорилт 1. Бүх нийтэд тэгш, хүртээмжтэй, ялгаварлалгүй, тогтвортой, улс төрөөс ангид, боловсролын түвшин хоорондын уялдааг хангасан, шинжлэх ухааны ололт судалгаанд суурилсан, үр дүнд чиглэсэн боловсролын бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс¹³).

Зорилт 2. Боловсролын байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг бүтэц, байршил, онцлог хэв шинжтэй уялдуулан уян хатан тогтоож байх (“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” (ТБтББ), 1.3.3. дугаар заалт).

Зорилт 3. Иргэн бүрд үзүүлэх боловсролын үйлчилгээг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх чанартай, хүртээмжтэй болгох (ТБтББ, 2.1.1. дүгээр заалт).

Зорилт 4. Боловсролын олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн орон нутаг, үндэсний онцлогт суурилсан музей, кино, хэрэглэгдэхүүн, лабораторид түшиглэн үйл ажиллагааны явцад суралцах боломжийг бүрдүүлэхэд бүх талын оролцоог хангана (ТБтББ, 4.2. дахь хэсэг).

Зорилт 5. Бүх шатны сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний төлөвшил, хөгжил, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлнэ (ТБтББ, 4.6. дахь хэсэг).

Зорилт 6. Боловсролын захиргаа, мэргэжлийн удирдлага, хяналтын байгууллагын чиг үүрэг, уялдааг тодорхой болгож, удирдлагын төвлөрлийг сааруулах, сургалтын нэгж байгууллагын бие даасан чадавх, эрх мэдлийн хүрээг өргөжүүлэх, багшийн хүний нөөцийн хөгжил, ачаалал, нийгмийн асуудлыг тэгш шийдвэрлэсэн эрх зүй, үйл ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 7. Хүртээмж, чанарыг тэгш баримжаалан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, нэгж байгууллагын бие даах эрхэд суурилсан хөрөнгө оруулалтын тогтолцоо, боловсон хүчний чадавх, төр, хувийн хэвшлийн байгууллагын үйлчилгээний чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлэх (МУТХҮБ-2030, 2.2.3. дугаар заалт, Зорилт 1)

¹³ МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэлэлцүүлэг, ҮХГ, 2018.

Зорилт 1. Сургуулийн өмнөх боловсролыг “хүүхдийг сургах, сургуульд бэлтгэх” гэсэн зорилгоос илүүтэйгээр хүний хөгжлийн үндэс, өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих, насан туршийн боловсролын суурь үе хэмээн хөгжүүлнэ (ТБтББ, 3.2. дахь хэсэг).

Зорилт 2. Төр, хувийн хэвшлийн байгууллагын чиг үүрэг, нийгмийн хариуцлага, иргэний нийгмийн оролцоо, дэмжлэгийг бага насны хүүхдийн хөгжил, хамгаалалд төвлөрүүлэн, татвар, урамшууллын бодлогоор дэмжих, эцэг эх, асран хамгаалагчдын хариуцлагыг нэмэгдүүлэх, гэр бүлийн боловсрол эзэмших тогтолцоо бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Хүүхэд хамгааллын асуудлыг нийгмийн анхаарлын төв, төрийн бодлогын түвшинд хүргэж, бага насны хүүхдийн эрүүл, аюулгүй байдал, тэгш хамрагдалт, хоол тэжээлийн нэгдмэл, уян хатан, мэргэжлийн, стандартад суурилсан үйлчилгээ-хяналтын тогтолцоог бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Олон улсын болон үндэсний стандартын шаардлагыг хангасан, дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх үйл явцыг дэмжсэн, бага насны хүүхдийн хөгжлийн суурь судалгаанд үндэслэсэн сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулах (МУТХҮБ-2030, 2.2.3. дугаар заалт, Зорилт 2)

Зорилт 1. Ерөнхий боловсрол нь 12 жилийн тогтолцоотой байх бөгөөд ерөнхий боловсрол эзэмших сургалтын тасралтгүй, залгамж чанарыг хангаж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шатлал, бүтцийг баримтална (ТБтББ, 3.9. дэх хэсэг).

Зорилт 2. Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд хамрагдах, хоёр ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн тоог 30 хүртэл хувиар бууруулах, анги дүүргэлтийг багасгаж, улсын дунджийг 25-аас илүүгүй байлгах (МУТХҮБ-2030, 2.2.3. дугаар заалт, Зорилт 2).

Зорилт 3. МУТХҮБ-2030-д үндэслэн Монгол Улсын боловсролын хөгжлийн үзэл баримтлал, бодлого, стратеги, бүх түвшний төлөвлөгөөг уялдуулан тогтвортой мөрдөхөөр сайжруулан шинэчилж, тэдгээрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бэхжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Хөгжлийн хөтөлбөр бүх шатны төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт, шинжилгээ, үнэлгээ болон эрх зүйн хэрэгжилтийн хяналт шалгалт, боловсролын чанарын үнэлгээ, баталгаажуулалтын шинэ индикатор, арга зүйг нэвтрүүлж, тэдгээрийн уялдаа холбоог хангаж, хариуцлагын менежментийг бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 5. Урт, дунд хугацааны төлөвлөгөө ба боловсролын стандарт, хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг дэмжсэн төсвийн ангилал зүйлчлэлийг оновчтой болгож, төсвийн төлөвлөлт, хуваарилалт ба санхүүжилт, хөрөнгө оруулалтыг үр ашигтай болгох (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх зорилт 4. Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог боловсронгуй болгож, төгсөгчдөд мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшүүлэх (МУТХҮБ-2030, 2.2.3. дугаар заалт, Зорилт 3)

Зорилт 1. Мэргэжлийн боловсрол, сургалтын эрэлтэд нийцсэн тогтолцоог төлөвшүүлж, суралцагчдын тоог нэмэгдүүлэх (МУТХҮБ-2030, 2.2.3. дугаар заалт, Зорилт 3).

Зорилт 2. Дээд болон мэргэжлийн боловсролын чанарын баталгаажилт, магадлан итгэмжлэлийн тогтолцоог төгөлдөржүүлэх, олон улсын сургалтын хөтөлбөр, боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлнэ (ТБтББ, 4.12. дахь хэсэг).

Зорилт 3. Дээд болон мэргэжлийн боловсролыг олон улсын нийтлэг жишгийг баримжаалан төрөл бүрийн хэв шинжтэйгээр хөгжүүлнэ (ТБтББ, 4.13. дахь хэсэг).

Бодлогын тэргүүлэх чиглэл 5. Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгох (МУТХҮБ-2030, 2.2.3. дугаар заалт, Зорилт 4)

Зорилт 1. Хөгжлийн тэргүүлэх чиглэлийн дагуу шинжлэх ухаан, технологийн кластер, парк байгуулж, үндэсний дөрвөөс доошгүй их сургууль Азийн шилдэг их сургуулийн эгнээнд орсон байх (МУТХҮБ-2030, 2.2.3. дугаар заалт, Зорилт 4).

Зорилт 2. Дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, шинжлэх ухаан, технологийн дэвшил, иргэдийн сурах хэрэгцээ, ажлын байранд тавих шаардлагатай уялдуулан тасралтгүй хөгжүүлнэ (ТБтББ, 4.11. дэх хэсэг).

Зорилт 3. Их, дээд сургуулиудын санхүүгийн бие даасан байдлыг хангаж, олон талт санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Дээд болон мэргэжлийн боловсролын боловсон хүчин бэлтгэх бодлого, менежмент, зохицуулалтын салбар хоорондын уялдааг хангах байгууллагыг бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 5. Их, дээд сургуулийн дундын лабораторийг байгуулах замаар аж үйлдвэрийн кластер, өндөр технологийн баазад түшиглэсэн бүтээлч, эрдэм шинжилгээ, сургалтын тогтолцоог бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 6. Судалгаанд суурилсан их сургуулийн тэргүүлэх чиглэлийг тогтоох, хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 7. Дээд боловсролын болон мэргэжлийн боловсролын багш бэлтгэдэг болон чадварлаг профессоруудын өрсөлдөөнт тогтолцоог бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 8. Сургалтын шаталсан дэд тогтолцоонуудыг хооронд нь уялдуулах (Ерөнхий боловсролын сургууль - Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв - Дээд боловсрол) (Хэлэлцүүлгээс).

Зорилт 9. Дээд болон мэргэжлийн боловсролын талаарх хууль эрх зүй, стандартыг боловсронгуй болгох болон сургалтын байгууллагуудын бүтэц, зааг ялгааг оновчтой болгох, засаглал, төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, статус, эрх зүйн чадамж, бие даасан байдлыг дээшлүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 10. Насан туршийн боловсролын үйлчилгээний төрөл, хэлбэр, сургалтын байгууллагыг өргөжүүлэн бэхжүүлнэ (ТБтББ, 3.14. дэх хэсэг).

Бодлогын тэргүүлэх чиглэл 6. Үндэсний соёлын өвийг хамгаалж, хөгжүүлэн сурталчлах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Тогтвортой хөгжилд соёлын гүйцэтгэх үүргийг тодотгох, үндэсний үнэт зүйлийг төлөвшүүлэх, соёлын өвийг өвлүүлэн уламжлуулах, соёлын дархлааг бэхжүүлэх, үндэсний соёлын гадаад сурталчилгааг идэвхжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Салбарын өрсөлдөх чадварыг дэмжсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлал, зохиогчийн эрхийн тогтолцоог бүрдүүлэх, соёлын гадаад худалдааны бодлоготой уялдуулсан үндэсний брэндийн бодлого боловсруулах (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 7. Урлагийн салбарыг хөгжүүлэн сурталчлах (шинээр томьёолсон)

Зорилт 1. Соёл, урлагийн салбарын засаглал, институцийг оновчтой болгох, төр, төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагуудын хоорондын уялдаа, зохион байгуулалт, хамтын ажиллагааг сайжруулах, оюуны өмч, боловсрол, аялал жуулчлал болон бусад салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Соёл, урлагийн салбартай холбогдох хууль, дүрэм, журам, стандартыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх, хяналтыг сайжруулах, судалгаа шинжилгээнд үндэслэсэн соёлын бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Соёл, урлагийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх сургалтыг сайжруулж, чанартай хүний нөөцийг бэлтгэх, хангах ба салбарын ажиллагчдыг мэргэжлийн боловсон хүчнээр бүрдүүлж, цалин, нийгмийн хангамжийг сайжруулах (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 8. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх (шинээр томьёолсон).

Зорилт 1. Идэвхтэй хөдөлгөөн, спортыг хүн амын амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсны хэрэглээ болгон чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ажиллах чадварыг дээшлүүлэх хэрэглүүр болгох бодлогыг хэрэгжүүлэх (“Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого” (БТСХтТББ), 3.2. дахь хэсэг).

Зорилт 2. Тамирчдын ур чадварыг үндэсний шигшээ багийн бүх түвшинд ахиулах, сургалт-дасгалжуулалт, тэмцээн, спортын наадмыг шаталсан тогтолцоогоор зохион байгуулж, спортыг хөгжүүлэх, тамирчдыг олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөхүйц чадвартай болгох бодлогыг хэрэгжүүлэх (БТСХтТББ, 3.3. дахь хэсэг).

Зорилт 3. Биеийн тамир, спортын салбарт төрийн ба төрийн бус байгууллагын зохистой түншлэл, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурласан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгох (БТСХтТББ, 3.5. дахь хэсэг).

Зорилт 4. Салбарын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхдээ эрдэм, шинжилгээ, судалгаа, туршилт, нотолгоонд үндэслэсэн байх, спортын шинжлэх ухаанд суурилсан биеийн тамир, спортын ажил, үйлчилгээг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 5. Хүн амын суурьшил, иргэдийн хэрэгцээ сонирхол, олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн аймаг, нийслэл, дүүргүүдийн биеийн тамир, спортын барилга байгууламж, дэд бүтцийг бүтээн байгуулж, санхүүжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 6. Биеийн тамирын үйл ажиллагаа, идэвхтэй хөдөлгөөн, спортын үйлчилгээнд зарцуулж буй улсын төсвийн санхүүжилтийг газар зүйн байршил, хүн амын тоотой уялдуулж төлөвлөх (Хэлэлцүүлгээс).

4.3.4. Шинжлэх ухаан, инновацийн тогтвортой хөгжлийн дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлэх (МУТХҮБ-2030, 2.2.3. дугаар заалт, Зорилт 5)

Зорилт 1. Технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг 2025 он гэхэд ДНБ-ий 2,5 хувь хүртэлх түвшинд хүргэх (МУТХҮБ-2030, 2.2.3. дугаар заалт, Зорилт 5).

Зорилт 2. Шинжлэх ухаан, технологийн салбарын бүтэц, зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгох (“Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого” (ТШУТтББ), 2.2.1. дүгээр заалт).

Зорилт 3. Судалгаа боловсруулалтын ажлыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх (ТШУТтББ, 2.2.2. дугаар заалт).

Зорилт 4. Шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгож, ДНБ-д шинжлэх ухаан, технологийн салбарын төсвийн санхүүжилтийн эзлэх хувийг 2016-2020 онд 2 хувь, 2020-2025 онд 2,5 хувьд хүргэх (ТШУТтББ, 2.2.3. дугаар заалт).

Зорилт 5. Шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийг тогтвортой хөгжүүлэн эрдэм шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлж, эрдэмтэн, судлаачдын бүтээлч үйл ажиллагааг дэмжих (ТШУТтББ, 2.2.4. дүгээр заалт).

Зорилт 6. Шинжлэх ухаан, технологийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга байгууламж, лабораторийн орчин, нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгох (ТШУТтББ, 2.2.5. дугаар заалт).

Зорилт 7. Шинжлэх ухаан, технологийн салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх (ТШУТтББ, 2.2.6. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Инновацийн үйл ажиллагааг бүх талаар дэмжин хөгжүүлэх (шинээр томъёолсон)

Зорилт 1. Судалгаа, боловсруулалтын ажлын үр дүнд бий болсон шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн инновацийн үйл ажиллагааг хөгжүүлэх (“Төрөөс иновацийн талаар баримтлах бодлого” (ТИтББ), 2.2.1. дүгээр заалт).

Зорилт 2. Аж үйлдвэрийн тэргүүлэх салбарын өрсөлдөх чадвар, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нутагшуулах, гарааны компанийг дэмжих замаар аж ахуйн нэгжийн инновацийг хөгжүүлэх (ТИтББ, 2.2.2. дугаар заалт).

Зорилт 3. Орчин үеийн аж үйлдвэр, өндөр технологийн салбарт байгальд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай технологийг хөгжүүлэх, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чанар, хүртээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ (ТИтББ, 2.2.4. дүгээр заалт болон хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан олон эх үүсвэрт санхүү, хөрөнгө оруулалтын механизмыг бүрдүүлж, шинжлэх ухаан, технологи, инновацийн

салбарын ДНБ-д эзлэх хувийг нэмэгдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 5. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт ажиллаж байгаа гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлж, гадаадтай хамтарсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 6. Судалгаа боловсруулалтын ажил, сонгон шалгаруулалт, тэдгээрийн санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгон үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чанар, хүртээмж, өрсөлдөх чадварыг олон улсын жишигт хүргэх (Хэлэлцүүлгээс).

4.3.5. Эрүүл мэндийн салбарын бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх (шинээр томъёолсон)

Зорилт 1. Эрүүл мэндийн асуудлыг бусад салбарын бодлогод тусган уялдуулж, нэгдсэн зохицуулалттайгаар хэрэгжүүлэх механизмыг бий болгосноор хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ (“Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” (ТЭМтББ), 2.4.1.1. дэх хэсэг).

Зорилт 2. Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгана (МУТХҮБ-2030, 2.2.2. дугаар заалт, Зорилт 1).

Зорилт 3. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна (МУТХҮБ-2030, 2.2.2. дугаар заалт, Зорилт 2).

Зорилт 4. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна (МУТХҮБ-2030, 2.2.2. дугаар заалт, Зорилт 3).

Зорилт 5. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакцинийг хүн бүрт хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна (МУТХҮБ-2030, 2.2.2. дугаар заалт, Зорилт 4).

Зорилт 6. Импортын болон дотоодын үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүний агууламжид тавих хяналтыг сайжруулан хүнсний аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл, зохистой хооллолтыг дэмжих замаар хүн амын дундах жингийн илүүдэл, амин дэм, эрдэс бодисын дутагдлыг бууруулах (ТЭМтББ, 2.4.1.3. дахь хэсэг).

Зорилт 7. Хүүхдийг эхийн сүүгээр хооллох эрх зүйн орчинг боловсронгуй болгож, энэ чиглэлээр хамтрагч талуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх (ТЭМтББ, 2.4.1.4. дэх хэсэг).

Зорилт 8. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулах (ТЭМтББ, 2.4.2.1. дэх хэсэг).

Зорилт 9. Өрх, сумын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэгт үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний багцыг өргөжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар хүндрэлийг багасгах (ТЭМТББ, 2.4.2.2. дахь хэсэг).

Зорилт 10. Өмчийн хэлбэрээс үл хамааран орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг үйл ажиллагааны нэгдмэл байдлаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг болгох (ТЭМТББ, 2.4.2.3. дахь хэсэг).

Зорилт 11. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилгоор хүний нөөцийг чадавхжуулах (Хэлэлцүүлгээс).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах тусламж, үйлчилгээний тогтвортой, оновчтой бүтцийг бий болгох (шинээр томьёолсон)

Зорилт 1. Гэнэтийн аюул, байгалийн гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлт гэх мэт нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ шуурхай авах чадавхыг бүрдүүлэх (ТЭМТББ, 2.4.1.5. дахь хэсэг).

Зорилт 2. Эрүүл, аюулгүй ажлын байрыг дэмжих зорилгоор ажил олгогчдод хандсан цогц арга хэмжээг хэрэгжүүлэх (ТЭМТББ, 2.4.1.6. дахь хэсэг).

Зорилт 3. Хүн амд , ялангуяа цэцэрлэг, ерөнхий боловсролын болон их дээд, сургууль, коллежид суралцагчдад эрүүл мэндийн мэдлэг олгох, ухуулга нөлөөлөл, мэдээлэл сурталчилгаа хийх, иргэдийн эрүүл мэндийн талаарх хүчин чармайлтыг дэмжих, урамшуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, хүн амын ёс заншилд тохирсон уламжлалт анагаах ухааны аргыг ашиглан өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйл, аж төрөх хэв маягийг төлөвшүүлэх (ТЭМТББ, 2.4.1.7. дахь хэсэг).

Зорилт 4. Иргэн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоонд тулгуурлан хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаан, үр дагаврыг судлах, эрт сэрэмжлүүлэх, насанд нь тохирсон өвчний эрт илрүүлэлт, хяналтын тогтолцоог бүрдүүлэх (ТЭМТББ, 2.4.1.10. дахь хэсэг).

Зорилт 5. Эмнэлгийн яаралтай тусламжийн төвлөрлийг сааруулах, түргэн тусламжийн дуудлагын хугацааг багасгах, алслагдсан болон газар зүйн саад бэрхшээлтэй нутагт оршин сууж байгаа иргэдэд үзүүлэх яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх (ТЭМТББ, 2.4.2.7. дахь хэсэг).

Зорилт 6. Нийгмийн эрүүл мэндийн бодлогыг бусад салбарын бодлогод тусган салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах (Хэлэлцүүлгээс¹⁴).

Зорилт 7. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртөг, зардлын бодит тооцоон дээр үндэслэн түүний үйл ажиллагааны санхүүжилтийг нэмэгдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 8. Хүн амын ёс заншилд тохируулан урьдчилан сэргийлэх эрүүл зан үйл, аж төрөх хэв маягийг төлөвшүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 9. Нийгмийн эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох (Хэлэлцүүлгээс).

14 МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх Эрүүл мэндийн салбарын дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэлэлцүүлэг, ҮХГ, 2018.

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанар, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх (шинээр томъёолсон)

Зорилт 1. Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн нэгдсэн зохицуулалт, чанарт суурилсан худалдан авалтын бие даасан тогтолцоог бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Зах зээлд гарсан эмийн чанар, аюулгүй байдлын тандалт, судалгааг тогтмол хийх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг шинэчлэн найруулж батлуулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Эм зүйн тусламж үйлчилгээний ил тод, хариуцлагатай байдлыг хангахад төр, хувийн хэвшлийн түншлэл, салбар дундын хамтын ажиллагааг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

4.3.6. Нийгмийн даатгал, халамжийн бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Нийгмийн даатгал, халамжийн тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлэх (шинээр томъёолсон)

Зорилт 1. Үндэсний онцлог, хүн амын насны бүтцийн өөрчлөлтөд нийцүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог хөгжүүлнэ (МУТХҮБ-2030, 2.2.1. дүгээр заалт, Зорилт 3).

Зорилт 2. Нийгмийн даатгалын олон давхаргат тогтолцоог боловсронгуй болгох, хүн амыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг үе шаттай, зах зээлийн нөхцөлтэй уялдуулан тогтоох (МУТХҮБ-2030, 2.2.1. дүгээр заалт, Зорилт 3).

Зорилт 3. Нийгмийн хамгааллын үйлчилгээг баталгаатай, хүртээмжтэй болгож, зорилтот бүлэгт чиглүүлэх (МУТХҮБ-2030, 2.2. дахь хэсэг).

4.3.7. Хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын талаарх дунд хугацааны бодлогын тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. 2025 он гэхэд ядуурлыг эрс бууруулах (шинээр томъёолсон)

Зорилт 1. Иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан тогтвортой ажил, хөдөлмөр эрхлэхийг дэмжиж, ядуурлын түвшинг нэг оронтой тоонд хүртэл бууруулж, нийгмийн дундаж давхаргыг өргөжүүлэх (МУТХҮБ-2030, 2.2.1. дүгээр заалт, Зорилт 1).

4.4. Байгаль орчны тогтвортой хөгжлийн дунд хугацааны бодлогын тэргүүлэх чиглэлүүд

4.4.1. Усны нөөцийн хамгаалалт, нөхөн сэргээлт ба зохистой ашиглалтын бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Усны нөөцийг хамгаалж, хомсдлоос сэргийлэх (МУТХҮБ-2030)

Зорилт 1. Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, Хэрлэн, Орхон, Сэлэнгэ зэрэг томоохон голуудыг түшиглэн

усны нөөцийн цогцолбор төслүүдийг хэрэгжүүлэх (МУТХҮБ-2030 ба “Ус” үндэсний хөтөлбөр, 3.1.7. дугаар заалт).

Зорилт 2. Гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 23 хувьд хийх (МУТХҮБ-2030).

Зорилт 3. Усны экосистемийн үнэлгээний чанарыг хянах ба усны экосистемийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох (Хэлэлцүүлгээс¹⁵).

Зорилт 4. Томоохон голуудын сав газрын усны экосистемийн биологийн төлөв байдлын индексийг олон улсын стандартын дагуу боловсруулан гаргаж, сав газрын ашиглалт, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас усны экосистемд үзүүлж байгаа нөлөөллийг тогтоож, хянах үзүүлэлтийг тодорхойлох (“Ус” үндэсний хөтөлбөр, 3.2.10. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх (МУТХҮБ-2030)

Зорилт 1. Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 85 хувьд хүргэж, хүн амын 50 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох (МУТХҮБ-2030).

Зорилт 2. Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалттай бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж хэвшүүлэх (“Ус” үндэсний хөтөлбөр 3.1.10. дугаар заалт).

Зорилт 3. Ундны усны чанар, аюулгүй байдлын зохицуулалтын хууль эрх зүй ба институцийг боловсронгуй болгож, хяналт, хүртээмжийг сайжруулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Усны шинжилгээний лабораторийн гүйцэтгэлийн чадварыг сайжруулж, орчин үеийн өндөр мэдрэмтгий аналитик багаж төхөөрөмжөөр тоноглон, усны чанарын төлөв байдал, бохирдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллээр хэрэглэгчдийг хангах (“Ус” үндэсний хөтөлбөр, 3.2.7. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Усны нөөцийг оновчтой ба хэмнэлттэй ашиглаж, усны нөөц ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх

Зорилт 1. Усыг хэмнэлттэй, үр ашигтай хэрэглэх, дахин ашиглах технологийн шийдлийг дэмжиж, хэрэглээг хэвшүүлэх (Хэлэлцүүлгээс ба “Ус” үндэсний хөтөлбөр, 3.4.2. дугаар заалт).

Зорилт 2. Усны нөөц ашиглалтын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хууль тогтоомжийг олон нийтэд танин мэдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Усны нөөц ашигласны төлбөрийг уян хатан бөгөөд оновчтой тогтоох, өөрчлөх болон усны нөөц ашигласны төлбөрийн орлогоос усны нөөцийг хамгаалахад зарцуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Уул уурхай, усалгаатай газар тариалан болон бусад салбарын гадаргын усны хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд гадаргын ус хуримтлуулах усан сан, хөв цөөрөм байгуулах (Хэлэлцүүлгээс ба МУТХҮБ-2030).

Зорилт 5. Томоохон барилга байгууламжийн дээврийг хур тунадасны ус

¹⁵ МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэх Байгаль орчны салбарын дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэлэлцүүлэг, ҮХГ, 2018.

цуглуулах боломжтойгоор хийх, барилга байгууламжийн зураг төсөлд хур борооны усыг хуримтлуулан авах бололцоотой байхаар өөрчлөлт оруулж, норм, дүрэмд тусгах, түүнийг ахуйн хэрэглээ болон ногоон байгууламжийн усан хангамжид ашиглах нөхцөлийг бүрдүүлэх (“Ус” үндэсний хөтөлбөр, 3.5.11. дүгээр заалт).

Зорилт 6. Усны салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг шинэ шатанд гаргаж, усыг зүй зохистой ашиглах, хэмнэх, тоолууржуулах, цэвэршүүлэх дэвшилтэт технологийг судлах, нэвтрүүлэх, усны нано бүтцэд боловсруулалт хийж, ус хангамж, хэрэглээ, ашиглалтын түвшин, үр өгөөжийг эрс дээшлүүлэх, усны физик, хими, биологи, эрдсийн шинж чанар болон мэдээлэл дамжуулах, хадгалах, материал орлох, шинэ материал бий болгох шинж чанаруудад хийсэн судалгаа шинжилгээний ололт, мэдлэгийг шуурхай судлан нэвтрүүлэх ажлыг нэн тэргүүний чиглэл болгон хөгжүүлэх (“Ус” үндэсний хөтөлбөр, 3.6.8. дугаар заалт).

Зорилт 7. Усны салбарын шинжлэх ухааны суурь судалгааны ажлыг уур амьсгалын өөрчлөлт, түүнээс улбаалан бий болсон дэлхий нийтийг хамарсан өөрчлөлтүүд, түүний Монгол орон дахь илрэл, нөлөө, өөрчлөлтийн хандлага, түүнд дасан зохицох, сөрөг нөлөөг зөөллөх, саармагжуулах арга хэмжээг тодорхойлох, усны нөөцийн бүрэлдэн бий болох үйл ажиллагааг дэмжих, хэвээр хадгалах чиглэлд түлхүү хандуулах (“Ус” үндэсний хөтөлбөр, 3.6.9. дүгээр заалт).

4.4.2. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, эрсдэлийг бууруулах бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх

Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, байгалийн гамшиг, байгаль орчны бохирдлыг бууруулах талаарх бодлого, хууль эрх зүйг боловсронгуй болгож, хэрэгжилтийг сайжруулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох жишиг төслүүдийг хэрэгжүүлж сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх (МУТХҮБ-2030).

Зорилт 3. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, байгалийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд орон нутгийн эрх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, байгалийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон улсын сангуудад хандах боломжийг нэмэгдүүлэх, сангийн санхүүжилттэй үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 5. Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, гамшигт үзэгдлийг даван туулах тогтолцоог боловсронгуй бөгөөд үр ашигтай болгох (Хэлэлцүүлгээс ба МУТХҮБ-2030).

Зорилт 6. Уур амьсгалын өөрчлөлтөд нэн эмзэг бүс нутгийн усны нөөцийг нарийвчлан тогтоох, салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах (“Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр” (УАӨҮХ), 3.2.5. дугаар заалт).

Зорилт 7. Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг биологийн олон янз байдлыг хамгаалах, дасан зохицоход дэмжлэг үзүүлэх ажлыг орон нутгийн тусгай

хамгаалалттай газар нутагт өргөжүүлэх (УАӨҮХ, 3.2.21. дүгээр заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологийг үйлдвэрлэл ба хэрэглээнд нэвтрүүлэх, байгаль орчинд хэт сөрөг нөлөөтэй үйлдвэрлэлийн хэмжээг хязгаарлах болон бусад үйл ажиллагаагаар нүүрстөрөгчийн ялгарлыг багасгаж, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад хувь нэмрээ оруулах

Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг сааруулах арга хэмжээг тогтвортой хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон хэмжээнээс 7 хувиар бууруулах (МУТХҮБ-2030).

Зорилт 2. Эдийн засгийн бодлогоор байгаль орчин, экологи ба малчдын орлогыг харгалзан малын тоог бууруулж, мал аж ахуйн салбарын үр ашгийг дээшлүүлэх замаар бэлчээрийн ургамлын бүрхэцийн ба ойн нөхөн сэргээлтийг сайжруулах.

Зорилт 3. Газар тариалангийн үр ашиг муутай ашиглаж буй газрыг эдийн засгийн бодлогоор багасгах болон шинэ газар олголтыг зогсоож, ус, хөрсний болон ургамлын бүрхэцийн нөхөн сэргээлтийг сайжруулах.

Зорилт 4. Хуурайшилттай нөхцөлд зохицсон ус хэмнэх, хөрс хамгаалах технологид тулгуурласан усалгаатай газар тариаланг хөгжүүлэх (УАӨҮХ, 3.2.23. дугаар заалт).

Зорилт 5. Орчны бохирдлыг бууруулах удирдлага, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог сайжруулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 6. Бэлчээр ашиглах, хөрс хамгаалах, эрчим хүч хэмнэх, үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх, ногоон хөгжлийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах хариу арга хэмжээ зэрэг харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх (УАӨҮХ, 3.1.2. дугаар заалт).

Зорилт 7. Хүлэмжийн хийн тооллого, тооцоонд шаардлагатай эх мэдээг улсын статистикийн мэдээлэлд бүрэн оруулах чиглэлээр эрх зүйн орчныг бий болгох (УАӨҮХ, 3.1.3. дугаар заалт).

Зорилт 8. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан салбар дундын зохицуулалт хийх үүрэг бүхий бүтцийг бий болгох (УАӨҮХ, 3.1.5. дугаар заалт).

Зорилт 9. Ойн нөөцийг хамгаалах болон нөхөн сэргээх бодлогын хөшүүргийг оновчтой болгох, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож хэрэгжилтийг сайжруулах.

Зорилт 10. Төвлөрсөн томоохон хот, суурины ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх (УАӨҮХ, 3.2.7. дугаар заалт).

Зорилт 11. Уул уурхайн үр ашиг муутай ашиглагдаж буй газруудыг эдийн засгийн бодлогоор хязгаарлаж, ой, ус, хөрсний болон ургамлын бүрхэцийн нөхөн сэргээлтийг сайжруулах.

Зорилт 12. Уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшиг, агаар орчны бохирдлыг бууруулахын тулд эдийн засгийн салбаруудад технологийн шинэчлэл хийж, тэдгээрийн үйл ажиллагааны хоорондын уялдааг хангах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 13. Нар, салхи, усны сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 14. Нүүрс боловсруулах, цэвэр түлш гаргах технологи нэвтрүүлэх, нутагшуулах арга хэмжээ авах (УАӨҮХ, 3.3.8. дугаар заалт).

Зорилт 15. Хотын замын хөдөлгөөний зохицуулалтыг сайжруулах, нягтралыг багасгах арга хэмжээ авах (УАӨҮХ, 3.3.14. дүгээр заалт).

Зорилт 16. Хатуу хог хаягдлыг бүрэн боловсруулах, эргүүлэн ашиглах үйлдвэр байгуулах (УАӨҮХ, 3.3.22. дугаар заалт).

Зорилт 17. Төмөр замын тээврийг цахилгаанд шилжүүлэх эхлэл тавих (УАӨҮХ, 3.3.37. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Уур амьсгалын ажиглалтын сүлжээг өргөтгөх, технологийн шинэчлэл хийх, судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлыг өргөжүүлэх, боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх (УАӨҮХ, 3.4. дэх хэсэг)

Зорилт 1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг өргөтгөх, технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх (УАӨҮХ, 3.4.1. дүгээр заалт).

Зорилт 2. Тусгай хамгаалалттай газрыг түшиглэн ой, хээрийн түймрийн тандалт, судалгааны цэгийг байгуулах (УАӨҮХ, 3.4.2. дугаар заалт).

Зорилт 3. Тусгай хамгаалалттай газрыг түшиглэн биогеоценозийн ажиглалт, мониторингийн сүлжээг байгуулж эхлэх (УАӨҮХ, 3.4.3. дугаар заалт).

Зорилт 4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг түшиглүүлэн мөстөлт, цэвдэг, цөлжилтийн мониторингийн сүлжээ байгуулах (УАӨҮХ, 3.4.4. дүгээр заалт).

Зорилт 5. Гадаргын болон гүний усны мониторингийн сүлжээг шинэчлэх, өргөтгөх (УАӨҮХ, 3.4.5. дугаар заалт).

Зорилт 6. Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээг 3-5 жил тутамд шинэчлэн хийж байх (УАӨҮХ, 3.4.7. дугаар заалт).

Зорилт 7. Хүлэмжийн хийн ялгаралт, шингээлтийн тооцооны үзүүлэлтийг Монгол орны нөхцөлд судлан тогтоох (УАӨҮХ, 3.4.9. дүгээр заалт).

Зорилт 8. Уур амьсгалын өөрчлөлтийн байгаль экологи, нийгэм, эдийн засгийн салбарт нөлөөлөх байдлын болон эрсдэлийн үнэлгээг тодорхой давтамжтай хийж байх (УАӨҮХ, 3.4.10. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 4. Олон нийтийг уур амьсгалын өөрчлөлт, түүний үр дагаврын тухай мэдээллээр хангах, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үзэл санааг төлөвшүүлэхэд туслах

Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох талаар ном, товхимол, гарын авлага, материал бэлтгэн хэвлүүлэх (УАӨҮХ, 3.5.1. дүгээр заалт).

Зорилт 2. Төр, засгийн бодлого, шийдвэр, шинжлэх ухааны ололт, дэвшилтэт технологийн тухай мэдээллийг олон нийтэд цаг тухайд нь хүргэх (УАӨҮХ, 3.5.2. дугаар заалт).

Зорилт 3. Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн хөгжлийн тухай хичээлийг бүх шатны сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах (УАӨҮХ, 3.5.3. дугаар заалт).

Зорилт 4. Аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл, төрийн бус байгууллага, иргэдийн ногоон үйлдвэрлэл эрхлэх, түүний хэрэглээг нэмэгдүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх зэргээр уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг дэмжих (УАӨҮХ, 3.5.7. дугаар заалт).

Зорилт 5. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх олон улс болон бүс нутгийн арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл, төрийн бус байгууллага, иргэд, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих, хамтын ажиллагааг өрнүүлэх (УАӨҮХ, 3.5.8. дугаар заалт).

Зорилт 6. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх (УАӨҮХ, 3.5.10. дугаар заалт).

4.4.3. Биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах бодлогын дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Биологийн олон янз байдал, экосистемийн тэнцвэрт байдлын тухай шийдвэр гаргагчид ба олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх

Зорилт 1. Биологийн олон янз байдлын талаарх судалгааны ажлыг дэмжих төр, хувийн хэвшлийн тогтолцоо, эдийн засгийн хөшүүргийг бий болгох (“Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр” (БОЯБҮХ), 4.8.1. дүгээр заалт).

Зорилт 2. Биологийн олон янз байдлын үнэ цэнэ, ач холбогдол, хамгаалал, түүнийг зохистой ашиглах талаарх мэдээллийг шийдвэр гаргагч болон олон нийтэд ойлгомжтой, системтэйгээр хүргэх тогтолцоог бүрдүүлэх (БОЯБҮХ, 4.8.2. дугаар заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Биологийн олон янз байдал ба экосистемийн тэнцвэрт байдлыг хамгаалах

Зорилт 1. Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгалах (МУТХҮБ-2030).

Зорилт 2. Байгалийн нөөцийг шинжлэх ухааны үндэслэлтэй эдийн засгийн эргэлтэд оруулах замаар биологийн олон янз байдлыг ашиглах, хамгаалах, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх механизмыг бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 3. Монгол орны унаган, нэн ховор, ховор зүйлийг цогцоор хамгаалах, ашиглах хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх (БОЯБҮХ, 4.10.1. дүгээр заалт).

Зорилт 4. Талуудын оролцоонд тулгуурласан тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, чадавхыг сайжруулах (БОЯБҮХ, 4.11.2. дугаар заалт).

Зорилт 5. Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өвөрмөц экосистемийг тодорхойлж, хамгаалах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх (БОЯБҮХ, 4.11.3. дугаар заалт).

Зорилт 6. Хотжилт, уул уурхай, үйлдвэржилтээс үүдэлтэй химийн бодисын бохирдолтой холбоотой хуулийн хэрэгжилтийн хяналтад төр, олон нийтийн хамтын оролцоог хангах (БОЯБҮХ, 4.12.1. дүгээр заалт).

Зорилт 7. Хөдөө аж ахуйд ашигладаг химийн бодисын зохистой хэрэглээ, түүний хяналт, биологийн олон янз байдалд үзүүлэх шууд болон дам нөлөөний талаар олон нийтийн ойлголтыг сайжруулах (БОЯБҮХ, 4.12.2. дугаар заалт).

Зорилт 8. Ургамал хамгаалах болон ургац нэмэгдүүлэх бодисын зохистой хэрэглээний хяналтын механизм бүрдүүлэх (БОЯБҮХ, 4.12.3. дугаар заалт).

Зорилт 9. Төрөөс ойн талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдааг хангах (БОЯБҮХ, 4.13.1. дүгээр заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Биологийн олон янз байдлын нөөц ба экосистемийн үйлчилгээг тогтвортой бөгөөд оновчтой ашиглах

Зорилт 1. Орон нутгийн удирдлагын хүний нөөцийг чадавхжуулж, газар, бэлчээр, газрын баялгийн нөөцийн бодлого, менежментийг зөв хэрэгжүүлэх нөхцөлийг хангах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 2. Нутгийн иргэдийн нөхөрлөл бэлчээр, ан амьтан, ургамал, ой, ойн дагалдах баялаг зэрэг хүрээлэн байгаа байгалийн нөөцийг цогцоор хариуцах эрх зүйн орчин бий болгох (БОЯБҮХ, 4.14.1. дүгээр заалт).

Зорилт 3. Газар, бэлчээр, газрын баялгийн нөөцийн гүйцэтгэх үүргийг тодотгох, оновчтой ашиглах ба хамгаалахад салбаруудын уялдаа холбоо ба хамтын ажиллагааг хөгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Агнуурын бүс нутагт ан агнуурын менежментийг хэрэгжүүлэх (БОЯБҮХ, 4.14.2. дугаар заалт).

Зорилт 5. Газрын тухай багц хууль болон холбогдох бусад эрх зүйн баримт бичигт экосистемийн тэнцвэрт байдлыг бүрэн хамгаалсан мал аж ахуй эрхлэх эдийн засгийн хөшүүрэг бий болгох (БОЯБҮХ, 4.15.1. дүгээр заалт).

Зорилт 6. Үржил шимийн доройтолд орсон хөрсийг нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг хөрсийг хамгаалах, доройтолд орохоос урьдчилан сэргийлэх санхүүгийн тогтвортой тогтолцоог бий болгох (БОЯБҮХ, 4.15.2. дугаар заалт).

Зорилт 7. Хөдөө аж ахуйн салбарын газар ашиглалтыг биологийн олон янз байдлыг хамгаалах бодлоготой уялдуулах (БОЯБҮХ, 4.16.1. дүгээр заалт).

Бодлогын тэргүүлэх чиглэл 4. Биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээг хамгаалах, ашиглах бодлого, эрх зүйн орчин, засаглал, эдийн засаг, санхүүжилтийн орчныг сайжруулж, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх

Зорилт 1. Цогц судалгаанд үндэслэсэн биологийн олон янз байдлын шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, үндэсний тооцооны системд нэвтрүүлэх (БОЯБҮХ, 4.17.1. дүгээр заалт).

Зорилт 2. Биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглах асуудлыг холбогдох салбаруудын бодлого, хөтөлбөртэй уялдуулах (БОЯБҮХ, 4.17.2. дугаар заалт).

Зорилт 3. Ой мод, биологийн олон янз байдалд хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, иргэн, албан тушаалтны хариуцлагыг дээшлүүлэх, сонирхогч талуудын оролцоог хангах, салбарын судалгаа шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэх, сайн засаглалыг бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 4. Биологийн олон янз байдлыг хамгаалах, зохистой ашиглахыг дэмжих эдийн засгийн механизмыг боловсруулж хэрэгжүүлэх (БОЯБҮХ, 4.18.2. дугаар заалт).

Зорилт 5. Биологийн олон янз байдлын генетик нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах, зохистой ашиглах, хамгаалах хууль эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 6. Газар болон бэлчээрийн харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бусад хуультай нийцүүлэн боловсронгуй болгож хэрэгжүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 7. Салбарын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн механизмыг бүрдүүлэх (Хэлэлцүүлгээс).

Зорилт 8. Экосистемийн үйлчилгээг үнэлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох (БОЯБҮХ, 4.19.1. дүгээр заалт).

Зорилт 9. Газар, бэлчээр, газрын баялгийн нөөцийн үнэлгээний чанарыг сайжруулах, салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж ажиллуулах ба салбарын статистик мэдээллийг олон улсын стандартын дагуу хөгжүүлэх, судалгаа шинжилгээний чадавхыг бий болгох (Хэлэлцүүлгээс).

Зорилт 10. Экосистемийн үйлчилгээний төлбөрийг нэвтрүүлэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх (БОЯБҮХ, 4.19.2. дугаар заалт).

Зорилт 11. Газрын асуудал эрхэлдэг төрийн байгууллагуудын засаглал, институцийг оновчтой болгох, тэдгээрийн уялдаа, зохион байгуулалт, хамтын ажиллагааг сайжруулах (Хэлэлцүүлгээс).

Зорилт 12. Салбарын боловсон хүчнийг бэлтгэх сургалтыг сайжруулж чанартай хүний нөөцийг бэлтгэх ба салбарын ажиллагчдыг мэргэжлийн боловсон хүчнээр бүрдүүлж, цалин, нийгмийн хангамжийг сайжруулан, урт хугацаанд тогтвор суурьшилтай ажиллуулах (Хэлэлцүүлгээс).

4.5. Засаглалын тогтвортой хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлүүд

Бодлогын тэргүүлэх чиглэл 1. Хариуцлагатай засаглалын бүтэц, үүрэг чиглэлийг шинэчлэн тогтоох

Зорилт 1. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх салбар, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хяналт тавих хариуцлагатай, чадварлаг засаглалын бүтцийг бүрдүүлж, бэхжүүлнэ (МУТХҮБ-2030).

Зорилт 2. Төрийн байгууллагын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, засаглалын ардчилсан, нээлттэй, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай байдлыг идэвхжүүлэх, инноваци, цахим засгийн хөгжлийг боловсронгуй болгон дэмжих (ТМХХХтББ).

Бодлогын тэргүүлэх чиглэл 2. Төрийн албаны хяналт, ил тод байдал, албан хаагчдын хариуцлага, ёс зүйн манлайллыг дээшлүүлэх, авилгыг устгах

Зорилт 1. Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлж, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлнэ (МУТХҮБ-2030).

Зорилт 2. Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авилга, хээл хахуулийг устгана (МУТХҮБ-2030).

Зорилт 3. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж,

төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх (“Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр” (АТҮХ)).

Зорилт 4. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авилгын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах (АТҮХ).

Зорилт 5. Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно (МУТХҮБ-2030).

Зорилт 6. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх (АТҮХ).

Бодлогын тэргүүлэх чиглэл 3. Төрийн бүх шатны байгууллагын үйл ажиллагааны зарчим, эрх зүйн орчныг шинэчлэх

Зорилт 1. Дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах замаар түншлэл, итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх (“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого”).

Зорилт 2. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх (АТҮХ).

Зорилт 3. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх (АТҮХ).

Зорилт 4. Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах (АТҮХ).

БҮЛЭГ 5. МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030-ЫН ХҮРЭХ ТҮВШИН

2016 оны 2 сард батлагдсан МУТХҮБ-2030 хэмээх баримт бичигт “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцыг дараах 20 үндсэн үзүүлэлтээр тодорхойлж үнэлнэ” гэж тусгасан бөгөөд эдгээр 20 үзүүлэлтийн суурь оны түвшинг 2014 оноор харуулж, 2030 онд хүрэх түвшинг тодорхойлсон байна.

Төслийн баг энэхүү 20 үзүүлэлтийн 2020 болон 2025 онд хүрэх түвшинг тооцож, доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 8. МУТХҮБ-2030-ын үндсэн 20 үзүүлэлтийн хүрэх түвшний төсөөлөл

№	МУТХҮБ-2030-ын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь он 2014	2020 он	2025 он	2030 он
1	Эдийн засгийн жилийн дундаж өсөлт	хувь	7.8		6.6	
2	Нэг хүнд ногдох ҮНО	ам.доллар	4280	7000	12000	17500
3	Хүний хөгжлийн үзүүлэлт	эзлэх байр	90	85	80	70
4	Дундаж наслалт	жил	69.57	71a	74a	78
5	Ядуурлын түвшин	хувь	21.6	18a	9	0
6	Өрсөлдөх чадварын үзүүлэлт	эзлэх байр	104	97	80	70
7	Бизнес эрхлэлтийн үзүүлэлт	эзлэх байр	56	50	45	40
8	Байгаль орчны багц үзүүлэлт	эзлэх байр	111	105	98	90
9	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан байдал	хувь	84.4	88	94	99
10	Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт	оноо	36.5	34	32	30
11	1000 амьд төрөлт дэх нялхсын эндэгдлийн түвшин	промилль	15.1	13a	11a	8
12	100000 амьд төрөлт дэх эхийн эндэгдлийн түвшин	продецемиль	30.6	25a	20a	15
13	Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт (улсын дундаж)	хүүхдийн тоо	27.3	25	22	20

**БҮЛЭГ 5. МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030-ЫН ХҮРЭХ ТҮВШИН**

14	Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын хорио, цээрийн шаардлагад нийцсэн газар нутгийн эзлэх хэмжээ	хувь	0	10	30	60
15	Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хэмжээ	хувь	78.2	76	72	68
16	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	хувь	17.4	25a	27a	30
17	Монгол Улсад аялах гадаад жуулчдын тоо	сая хүн	0.392	1.0a	1.5a	2
18	Цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан өрх	хувь	89	93	97	100
19	Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ	хувь	17	20a	25a	50
20	Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь	хувь	0	20a	70a	100

Тайлбар: Ардаа жижиг –“а” үсэгтэй түвшингүүд нь тухайн онд хүрэх түвшинг МУТХҮЗ-2030-д тогтоож өгсөн хэмжээ болно. Ийм тэмдэглэгээгүй түвшингүүд бидний тооцсон, төсөөлсөн түвшин болно.

Энэхүү хүрэх түвшинг тооцохдоо эдгээр үзүүлэлтийн 2014 оны суурь түвшин болон 2030 онд хүргэхээр төлөвлөсөн түвшинг харгалзан 2020 болон 2025 онд хүрсэн байх хэмжээг тодорхойлсон болно.

МУТХҮБ-2030-д дээрх үндсэн 20 үзүүлэлтээс гадна салбарын хөгжлийн хүрэх түвшинг илэрхийлсэн 52 үзүүлэлтийг текстэндээ тусгасан.

МУТХҮБ-2030-ын бүх зорилтыг үе шатаар нь хэмжих үзүүлэлтийн хамт Хавсралт 1-т жагсааж, дээрх 52 үзүүлэлтийн хүрэх түвшинг харуулав. Бусад үзүүлэлтийн хувьд салбарын яам, агентлагуудын ажлын хэсгийн оролцоотойгоор тоо мэдээлэл гаргаж чадах эсэхийг тодорхойлж, хүрэх түвшинг дахин тооцоолох шаардлагатай.

Дүгнэж хэлэхэд, МУТХҮБ-2030-д зарим үзүүлэлтийн 2030 он гэхэд хүргэхээр тодорхойлсон түвшин бүрэн хэрэгжих эсэх нь нэлээд эргэлзээтэй байна. Тухайлбал, 2030 он гэхэд дэлхий нийтийн жишгээр Монгол Улсад ядуурлыг эцэс болгохоор тусгасан. 2000-2015 оны хоорондох 15 жилд Монгол Улс дэлхий нийтийн жишгээр ядуурлыг 2 дахин бууруулах зорилт дэвшүүлсэн боловч бүрэн хэрэгжээгүй төдийгүй 2016 оны байдлаар ядуурлын түвшин 29,6 хувь болж, өмнөх 2010 оны 21,6 хувиас эргээд нэмэгдсэн билээ. Энэ байдлаас харахад ядуурлыг 2030 он гэхэд бүр мөсөн устгахаар тогтоосон түвшин хэрэгжих магадлал багатай байна.

МУТХҮБ-2030-д эдийн засгийн өсөлтийг жилд дунджаар 6,6 хувь байхаар тусгасан боловч 2016 онд дөнгөж 1 хувь, 2017 онд 5,1 хувиар өссөн билээ. Харин 2018 онд манай орны эдийн засгийн өсөлтийг 5,8 хувь орчим гарна гэж дэлхийн банк урьдчилан

тооцсон бол Сангийн яам 6,3 орчим хувиар өснө гэж үзэж байна. Иймээс өмнөх онуудын өсөлтийн дутууг дараа дараагийн онуудад нөхөх замаар төлөвлөн өсөлтийн түвшинг хангах шаардлага гарч байна. Төрөөс тухайн салбарын хөгжлийн талаар тодорхойлсон бодлого нь МУТХҮБ-2030-д тодорхойлсон бодлогоос ихэвчлэн илүү өргөн хүрээтэй зорилтуудыг хамруулсан боловч тэдгээрээс тэргүүлэх гол чиглэл нь аль болох нь тодорхойгүй, бодлогын зарим зорилт нь ердийн арга хэмжээнээс ялгагдахааргүй жижиг, үнэлж дүгнэхэд бэрхшээлтэй болжээ. Иймээс салбарын бодлогын зорилтуудыг нэгтгэн эмхэлж, цэгцлэх, тэргүүлэх чиглэлийн хүрээнд оруулан ангилах, цөөлөх шаардлагатай байна.

МУТХҮБ-2030-д тусгагдсан болон төрөөс баримтлах бодлогод тодорхойлсон олон бодлого Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт бүрэн тусгагдаагүй, тэдгээрийг тууштай хэрэгжүүлэх механизм нь тодорхойгүй, хоосон тунхаглал болон үлдэх магадлал өндөр байна.

Эдийн засаг, нийгмийн хөгжлийнхөө талаар Монгол Улсын төрөөс тодорхойлсон бодлогууд, түүнээс урган гарсан урт, дунд хугацааны зорилтууд олон байгаа боловч алсын хараатайгаа уялдаагүй, тэргүүн зэргийн ач холбогдолтойг нь тодорхойлж эрэмбэлээгүй, нэгтгэн цэгцлээгүй, салбарын бодлого нь макро түвшний бодлоготойгоо уялдаагүй зэрэг зөрчилтэй зүйлс их байна. Яам, агентлаг бүр бие дааж бодлогоо тодорхойлдог боловч тэдгээрийг нэгтгэн чиглүүлдэг механизм сул байна. Өөр нэг анхаарал татсан асуудал нь төрөөс тодорхойлсон бодлогын хэрэгжилт хангалтгүй, түүнийг хэрэгжүүлэх механизм, хариуцах институц нь тодорхой бус байгаа явдал юм. Энэ талаар бидний судалгааны эхний тайлан I-т авч үзсэн.

Монгол Улсын төрийн байгууллагуудын чадавх, менежмент сул, зах зээлийн нөхцөлд төрийн бодлогын хэрэгслүүдийг чадамгай ашиглах чадвар муу байна. Энэ талаар төслийн эхний тайланд (тайлан I-т) бид дүгнэсэн. Тухайлбал, зах зээлийн нөхцөлд төр өөрөө татварын бодлого, зээлийн бодлого, хөрөнгө оруулалтын уян хатан бодлогоор гаргасан бодлогынхоо хэрэгжилтийг дэмжих механизм ажиллахгүй байна.

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаар төрөөс баримталж ирсэн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр дутагдалтайгаас хэрэгжихгүй тохиолдол их байна. Ялангуяа сонгуулийн хуулийн сул тал хүчтэй нөлөөлж байна. УИХ-ын гишүүд эдийн засаг, нийгмийн хөгжлийн гол зорилтуудыг хэрэгжүүлэхэд хөрөнгө хүчийг төвлөрүүлэхийн оронд төсвийг өөрсдийн тойрогтоо хуваарилах сонирхолд хөтлөгдөж, жил бүрийн төсвийг хэлэлцэж батлахдаа Засгийн газраас оруулсан төслийг ихээхэн өөрчилж байна. Энэ нь хөгжлийн тэргүүлэх чиглэлд хөрөнгө мөнгийг хуваарилах зарчмыг алдагдуулж байна.

Сонгуулийн хуульд Монгол Улс томсгосон нэг тойрогтой болж, УИХ-ын гишүүдийг олон тойргоос нэр дэвшүүлэхийг зогсоох шаардлагатай байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгууд болон Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын зорилгууд, төрөөс тодорхой салбарын талаар баримтлах бодлогын баримт бичгүүдийг хооронд нь уялдуулах, нөлөөллийн үнэлгээ хийх, салбаруудын өмнө тулгамдаж буй нийтлэг асуудлуудыг эрэмбэлэх, салбарын дунд хугацааны тогтвортой хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл, зорилтуудыг тодорхойлох, МУТХҮБ-2030-д хүрэх түвшинг тогтоох арга зүйг боловсруулах, судалгааны ажилдаа турших зэрэг ажлыг зохион байгуулж байна.

Бидний туршсан энэхүү арга зүй нь төр, захиргааны болон судалгаа, шинжилгээ, бизнес, олон нийтийн байгууллагын төлөөллийг өргөнөөр оролцуулж, Монгол Улсын макро түвшний болон салбарын дунд хугацааны тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэл болон МУТХҮБ-2030-ын хүрэх түвшинг тодорхойлох боломжийг олгож байгаа бөгөөд ойлгоход хялбар, практик дээр ашиглахад энгийн, цаг хугацаа, хүн хүч хэмнэхэд чухал ач холбогдолтой юм.

Хэлэлцүүлэгт оролцож байгаа бүлгийн гишүүд асуудлаа ямар түвшинд мэддэг, асуудалд хэрхэн хариуцлага, сэтгэл гаргаж хандсан зэргээс шалтгаалан гарах үр дүн нь бодитой, эсвэл хийсвэр байх магадлалтай нь уг аргын сул тал юм.

Энэхүү аргыг ашиглан бидний хийсэн хэлэлцүүлгээс харахад салбаруудад тулгамдаж буй асуудлаас хамгийн олон удаа давхардсаныг нь эрэмбэлж үзвэл:

1. Хууль эрх зүйн зохицуулалт оновчгүй, тэдгээрийн үзэл баримтлал, зүйл заалтууд өөр хоорондоо зөрчилтэй байна.
2. Дараагийн дугаарт салбарыг хөгжүүлэх эдийн засгийн зохицуулалтын арга механизмууд бүрэн ашиглагдахгүй, үндэсний үйлдвэрлэгчдэд дэмжлэг болж чадахгүй байгаа бодит байдал оржээ.
3. Салбарын боловсон хүчний мэдлэг, мэргэжлийн ур чадвар сул, сахилга, хариуцлага тааруу, гүйцэтгэлийн түвшин доогуур, мэргэжлийн сургалтын чанар хангалтгүй, боловсон хүчнийг шилж сонгох, томилох, дэвшүүлэхэд улс төрийн оролцоо ихтэй, төрийн албан хаагч тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрэлдээгүй зэрэг асуудал нийтлэг байна.
4. Засаглалын тогтолцоо оновчгүй, институцийн удирдлага, зохион байгуулалт хангалтгүй байна. Салбарын бодлого нь хэтэрхий улс төржсөн, дөнгөж өнөө маргаашийг харсан, гал унтраасан шинжтэй, иргэд, сонгогчдод таалагдахад чиглэгдсэн, популист шинж чанартай, төрийн байгууллагын бодлогын залгамж чанарыг хангаагүй байна.
5. Төр, засаг нь өөрийн үйл ажиллагааныхаа зардлыг хянаж чадахгүй учир их хэмжээний гадаад, дотоод өр тавьдаг, төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явц тооцоо, судалгаа, шинжилгээн дээр суурилагагүй, салбарын хөгжлийн төрийн бодлого тодорхойлох явцад эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах механизм байхгүй зэрэг дутагдал илэрч байна.
6. Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоо, хяналтын тогтолцоо байхгүй, салбар хооронд мэдээлэл

солилцох боломж байхгүй, үндэсний үйлдвэрлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргахад төрийн зүгээс дэмжлэг туслалцаа үзүүлэх, гадаадын бараанаас хамгаалах бодлого байхгүй зэрэг асуудал нийтлэг байна.

Бидний өмнө хийсэн судалгааны үр дүнд ДТХЗ-ууд ба МУТХҮБ-2030-ын зорилтууд нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон жил тутмын төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл, улсын төсөв, төрөөс мөнгөний талаар баримтлах бодлого, нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр зэрэг эдийн засаг, санхүү, мөнгөний богино болон дунд хугацааны бодлогуудад хангалттай тусгалаа олоогүй байгаа талаар дурьдсан. Өөрөөр хэлбэл, улс орны хөгжлийн бодлогын баримт бичгүүд хоорондоо уялдаагүй гэж үзэж болно.

Өмнө дурьдсан богино, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэх эдийн засаг, эрх зүйн механизмууд тодорхойгүй учир хоосон тунхаглал болон үлдэх магадлал өндөр байна.

Одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд макро түвшний бодлого, салбар хоорондын бодлого болон бүсийн хөгжлийн бодлогуудын хоорондын уялдаа холбоо байхгүй байна. Тухайлбал, хөгжлийн бодлого нь ямар алсын хараанд хүрэхэд чиглэгдэх, ямар арга замаар, ямар зарчим, үзэл баримтлалыг удирдлага болгон ямар дэс дараалалтай хэрэгжих, ямар ямар механизмыг ашиглах, хэдий хэмжээний санхүү, ажиллах хүч, материал, техникийн нөөц хэрэгцээтэй байгаа, ямар үр дүн гарах, хэн тэдгээрийг хэрэгжүүлэх зэрэг асуудлууд тодорхойгүй бөгөөд ихээхэн учир дутагдалтай болжээ.

Хөгжлийн бодлогын баримт бичгүүд нь ихэнх тохиолдолд гаднын жишээг шууд авч хуулбарласан, үндэсний онцлог, соёлыг тооцоогүй, тухайн нөхцөл байдалд зохицуулж тааруулсан, эрх барьж байгаа улс төрийн нам, хүчний мөрийн хөтөлбөр, хувь улс төрчийн ашиг сонирхол шингэсэн шинжтэй байна. Ийм байдалд хүргэхэд яам, агентлаг бусад яамтай харилцан уялдаагүйгээр өөрсдөө бие дааж бодлогоо тодорхойлдог явдал нөлөөлсөн.

Нөгөө талаас, улс орны хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгийг шинжлэх ухааны үндэстэй тодорхойлдог, түүний хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж зохион байгуулдаг, зангидаж чиглүүлдэг, хяналт тавьдаг төрийн удирдлагын институцийн эрх, үүрэг саармагжсан байдалтай байна. Тухайлбал, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажил болон салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрөөс баримтлах бодлогыг Сангийн яам холбогдох яамтай хамтран гүйцэтгэж боловсруулахаар заасан байхад ҮХГ хөгжлийн бодлого төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлох, хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхыг бэхжүүлэхэд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлнэ гэж тусгажээ. Иймд, улс орны хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн бодлогыг зангидаж удирдан зохицуулдаг, хянадаг, салбарын яамны сайдад шууд үүрэг, чиглэл өгдөг эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагыг ҮХГ-ын суурин дээр байгуулах эрх зүйн үндсийг уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдэх шаардлагатай байна.

Өнөөдөр төрийн албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, хариуцлага сул байгаа нь аливаа асуудалд мэргэжлийн үүднээс сэтгэл, зүтгэл гаргаж хандах чанар дутагдаж, зөвхөн дээрээс ирсэн шийдвэр буюу даргын өгсөн үүрэг даалгаврыг ёс төдий биелүүлэх байдлаар илэрч байна. Тэдний бүтээлч санаачилга гаргах, идэвхийг өрнүүлэх урамшуулах хөшүүрэг дутагдалтай байна. Энэ нь төрийн албанд хүнд суртал,

авилга, хээл хахууль, намын нөлөөллийг нэмэгдүүлж, төрийн албаны орон тоо, зардлыг нэмэгдүүлэхэд хүргэж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай бус, чанаргүй болгож байна. Ийм ч учир Монгол Улсын төр, засагт МУТХҮБ-2030 зорилгуудыг хэрэгжүүлэх, түүний хүрэх түвшинг хангахад мөнгө, зээл, татвар, төсвийн худалдан авалт, татаас шилжүүлэг, урамшуулал, хөнгөлөлт, чөлөөлөлт, хөрөнгө оруулалт, үнэ тариф, өмч хөрөнгө, гадаад зах зээлийн хамгаалалтын механизмуудыг уян хатан ашиглах мэдлэг, ур чадвар дутагдаж байна. Эдгээр бодлогын хэрэгслүүдийг дангаар буюу хослуулан ашиглах мэдлэгтэй, чадвартай, сэтгэлтэй боловсон хүчин ховорджээ. Бидний дүгнэлтийг дараах баримт нотолж байна. Үүнд:

1. УИХ-ын 2018 оны намрын ээлжит чуулганы нээлт дээр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга хэлсэн үгэндээ “1992 оноос өнөөдрийг хүртэл явсан төрийн тогтолцоо дампуурч, цаашид улс орныг удирдан явах чадвараа алдсан” гэж дүгнэсэн.

2. Монгол Улсын үндэсний оюун санааны нэгдмэл философи, үнэт зүйлс бүрдээгүйгээс нийгмийн ухамсар төлөвшиж, эв нэгдэл хангагдахгүй байна.

3. Монгол Улс нийгмийн шинэ тогтолцоонд хөгжих зарчим, үзэл баримтлал, нэгдмэл бодлогоо тодорхойлон хэрэгжүүлэх чадваргүй байна. 1990 оноос хойш хөгжлийн талаар төрөөс уялдаа холбоо, тооцоогүй 490 шахам бодлогын баримт бичиг баталсан боловч тэдгээр нь хангалттай хэрэгжээгүй.

4. Төрийн тогтолцоог бүрдүүлэхдээ гадны улс төрийн загварыг хэт хуулбарлан хэлбэрдсэнээс үндэсний онцлогт тохирсон бодитой, хариуцлагатай засаглал, удирдлагын механизм бий болсонгүй.

5. Төрийг бүрдүүлдэг улс төрийн механизм дампуурч, мафийн бүлэглэлийн хуйвалдааны хэрэгсэл болсон гэж үзэхэд хилсдэхээргүй нөхцөл байдал үүссэн.

6. Хүний нөөцийг бэлтгэх, мэдлэг, мэргэжлийн ур чадвараар сонгон ажиллуулах систем дампуурснаас бүх түвшинд ажил хариуцах чадвар суларсан.

7. Монгол хүний үндэсний ухамсар, итгэл үнэмшил, ирээдүйн зорилго, идэвх санаачилга алдарч, зарим нь ёс суртахууны доройтолд орсон.

8. Улс төрийн бодлогын гажуудлаас үүдэн эдийн засаг өөрийгөө тэтгэх чадваргүй болж, улсын гадаад өр 27,5 тэрбум доллар, төсвийн алдагдал 2017 онд 2,4 их наяд төгрөг болж, баялаг бүтээдэг эдийн засгийн бодит салбаруудаа удирдах, төлөвлөх, зохицуулах механизмыг төр засаг дутуу ашиглаж, зөвхөн улсын төсвөөр улс орны хөгжлийн санхүүгийн бүх эрэлтийг хангах гэсэн ухаалаг биш оролдлого хийх болжээ.

9. Улс төрийн гажуудлаас шалтгаалсан эрсдэлүүд нийгмийн амьдралын бүх хүрээнд бугшсаныг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр байнга давтан бичих болов.

10. ДТХЗ-ууд, МУТХҮБ-ыг дунд хугацаанд хэрэгжүүлэх зорилтуудыг тодорхойлох зорилгоор Үндэсний хөгжлийн газраас 2017-2018 онд хамруулан 13 яамны 40 дэд салбарын төрийн албан хаагч, эрдэмтэн судлаачид, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, аж ахуйн байгууллагын төлөөллийг хамруулж, оролцооны аргаар хийсэн хэлэлцүүлгийн дүнгээс харахад Монгол орны хөгжлийг хамгийн их саатуулж байгаа хүчин зүйлсийн тэргүүн эрэмбэд “хөгжилд чиглүүлсэн, залгамж чанартай төрийн нэгдмэл бодлого байхгүй”, “хөгжлийг удирдах засаглал, институцийн тогтолцоо бүрдээгүй” байгаа явдал гэж үзжээ. Энэ бүхнээс Монгол орон нийгмийн амьдралд тулгарсан олон арван эрсдэлийн суурь дэвсгэр болсон улс төрийн ноцтой

эрсдэлд орсон гэж дүгнэж болохоор байна.

Иймд төрөөс МУТХҮБ-2030-ын зорилтуудтай салбарын бодлогын зарим зорилтуудыг уялдуулах, тэдгээрийг эмхэлж, цэгцлэх, цөөлөх шаардлагатай байна. Төрийн яам, агентлагууд нь шинээр байгуулагдах шаардлагатай Үндэсний хөгжлийн яамны гаргасан шийдвэрийг шууд авч хэрэгжүүлдэг, тодорхой үүрэг, хариуцлага хүлээдэг, гүйцэтгэлийн хяналт тавьдаг тогтолцоог бий болгох шаардлагатай.

Монгол Улсыг нэг том тойрог гэж үзэн томсгож УИХ-ын сонгуулийг зохион байгуулахын зэрэгцээ нэг тойрогт нэр дэвшин сонгогдоод юу ч хийгээгүй байж дараагийн сонгуульд өөр тойрогт нэр дэвшин гарч, бас юу ч хийдэггүй зальхай явдлыг таслан зогсоох шаардлагатай байна.

Монгол Улсын гадаад, дотоод хүчин зүйлсээр нөхцөлдсөн улс төр, эдийн засгийн эрсдэлийг багасгах чиглэлд хийх алхмаас эхлээд нийт үндэсний хэмжээний шинэчлэлийг эхлүүлэх үндэсний язгуур эрх ашигт нийцсэн төрийн бодлого, зохицуулалттай хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцоог нэн даруй бүрдүүлж төлөвшүүлэх шаардлагатай тулгараад байна.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. МУТХУБ-2030-ын үндсэн үзүүлэлтээс гадна текстэд орсон 52 үзүүлэлтийн хүрэх түвшний төсөөлөл

№	МУТХУБ-2030-ын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2020 он	2025 он	2030 он
1	Чинээлэг болон дундаж давхаргын нийт хүн амд эзлэх хувь	хувь			80
2	Суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшин	хувь			100
3	Ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийд эзлэх байр	эзлэх байр			30
4	Төсвийн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь	хувь	15	10	2
5	ДНБ-д төсвийн зарлагын эзлэх хувь	хувь	35	32	30
6	Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт малын эзлэх хувь	хувь	3	5	8
7	Эрчимжсэн мал аж ахуй дахь цэвэр үүлдрийн үхрийн тоо	мянга	90	150	200
8	Үр тарианы үйлдвэрлэлийн талбайд тэг элдэншүүлэлтийн технологи нэвтрүүлэх ажил	хувь	70	85	90
9	Усалгаатай тариалангийн талбай	мянган га	65	100	120
10	Жилд шаардагдах бордооны хангамж	хувь	50	70	100
11	Нутагшсан соортын элит үрийн хангамж	хувь	75	90	100
12	Малчдын өрхийн аж ахуй эрхлэхэд нь хүрэлцэхүйц чадалтай цахилгааны эх үүсвэр, техник, технологиор хангах хувь	хувь	50	75	80
13	Арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин	хувь	60	70	80
14	Хүн амд нийлүүлсэн махны дотор үйлдвэрийн аргаар боловсруулсан махны эзлэх хувь	хувь	30	50	70
15	Хүн амд нийлүүлсэн сүүний дотор үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний эзлэх хувь	хувь	40	60	80
16	Ашиглалтад оруулах хар төмөрлөгийн үйлдвэрийн хүчин чадал	мянган тонн	ган бөмбөлөг: 100	ган туйван: 100	
17	Геологийн 1:200000 масштабын зураглалын нутаг дэвсгэрийн хамралтын хувь	хувь	100		
18	Сав газрын 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын нутаг дэвсгэрийн хамралтын хувь	хувь	40	45	50
19	Эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээр хангах хувь	хувь	85	90	100
20	Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь	хувь	20	25	30

21	Олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг нэмэгдүүлэх хэмжээ	км	1600	800	470
22	Барилгын дулааны алдагдлыг бууруулах хувь	хувь	20	25	40
23	Өндөр хурдны интернетийн сүлжээнд хамрагдсан хүн амын эзлэх хувь	хувь	70	90	95
24	Улсын төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь	хувь	2	0	0
25	Санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувь	хувь	10	12	16
26	Санхүүгийн зах зээлд арилжааны банкны эзлэх хувь	хувь	90	86	82
27	Гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	58.6	50	40
28	Худалдаа, үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, чанарыг сайжруулах, хилийн боомт дахь байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, хялбаршуулж, гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг бууруулах хэмжээ	хоног	25	18	10
29	Хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхийн түвшин	хувь	66	68	70
30	Ажилгүйдлийн түвшин	хувь	6	4	3
31	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийн хэмжээ	тэрбум төгрөг	100	200	300
32	1000 амьд төрөлтөнд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	промилль	15	12	9
33	10000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт	продецемиль	17.4	16	14
34	10000 хүн амд ногдох хорт хавдраас шалтгаалсан нас баралт	продецемиль	10.5	9	8
35	Товлолт дархлаажуулалтын хамралт	хувь	98.5	99	99.8
36	10000 хүн амд вируст гепатитын өвчлөлт	продецемиль	3	2.5	2
37	10000 хүн амд сүрьеэгийн тохиолдол	продецемиль	14.4	14	13
38	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн хамралт	хувь	70	80	90
39	Сургуулийн өмнөх боловсролын нэг багшид ногдох хүүхдийн тоо	хүүхдийн тоо	30	25	20
40	Хоёр ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн тоог бууруулах хувь	хувь	35	30	50
41	Анги дүүргэлтийн улсын дундаж	хүүхдийн тоо	35	25	20
42	Мэргэжлийн боловсрол, сургалтын сурагчдын тоо	мянга	60	70	80
43	Шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийн ДНБ-д эзлэх хувь	хувь	2	2.5	3

44	Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг тусгай хамгаалалтад авах хувь	хувь	50	55	60
45	Гидрогеологийн дунд масштабын зураглал хийх газар нутгийн эзлэх хувь	хувь	15	23	30
46	Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	80	85	90
47	Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрхийн эзлэх хувь	хувь	40	50	60
48	Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хувь	хувь	2	7	14
49	Байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог нэмэгдүүлэх хэмжээ	дахин	2	5	10
50	Нийт газар нутагт ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	хувь	8.5	8.7	9
51	Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувь	хувь	15	25	30
52	Нийт хог хаягдалд дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	хувь	20	30	40

Хавсралт 2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ

№	Бодлогын зорилтууд	Салбар хооронд		МУТХҮБ-2030		Нэгдсэн үр дүн	
		Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ
1	Салбарын хууль, дүрэм, журам, стандартыг шинээр бий болгох, хуулийн хэрэгжилтийг чанд хангуулах	20	II	41.5	I	32.9	I
2	Салбарын бодлогыг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт, чиг үүргийг нарийвчлах, оновчтой механизмыг бүрдүүлж, сайн засаглалыг бий болгох	21	I	40	III	32.4	II
3	Аж үйлдвэрийн салбарын зорилтуудыг үндэсний хөгжлийн стратеги, төлөвлөлтөд тусгах, зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд санхүү, татвар, зээл, төрийн болон орон нутгийн худалдан авалтаар дэмжих, оюуны өмч, патентыг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох	17.3	IV	38	V	29.7	III

4	Хүнд аж үйлдвэрийн мега төслүүдийн ТЭЗҮ-ийг боловсруулах, тооцоолох, зураглах, үнэлэх, магадлал хийдэг үндэсний чадавхыг олон улсын стандартын түвшинд бэхжүүлж, төслийг хэрэгжүүлэхдээ бүс, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, олон улсын зах зээлийн интеграцад нэгтгэх	12.8	VII	40	III	29.1	IV
5	Ашигт малтмалын стратегийн ордуудыг монголчууд өөрсдөө ашиглаж, тэдгээрт тулгуурлан аж үйлдвэр, инновацийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн инкубатор, паркийг байгуулах ажлыг зохион байгуулах	17.5	III	36.5	VI	28.9	V
6	Хүнд аж үйлдвэрийн салбарыг байгаль орчин, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, зам, тээвэр, холбоо, мэдээлэл, ус, цахилгаан, дулаан хангамж зэрэг дэд бүтцийн салбаруудтай уялдуулах	10.8	X	40.5	II	28.6	VI
7	Хүнд аж үйлдвэрийн инженер, техникийн ажилтныг гадаад, дотоодод үе шаттай бэлтгэх, давтан сургах, МСҮТ-ийг техник, технологийн хувьд шинэчлэх	12	IX	32	VII	24	VII
8	Олон улсын худалдааг хөнгөвчлөх, тарифын болон тарифын бус саад тотгорыг багасгах арга хэмжээний хүрээнд хүнд аж үйлдвэрийн салбарын бараа, бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд нэвтрэх боломжийг бий болгох, зах зээлийн тоог олшруулах, бараа, бүтээгдэхүүнийхээ өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	12.3	VIII	31.8	VIII	24	VIII
9	Өндөр бүтээмжтэй, байгаль орчинд ээлтэй техник, технологи нэвтрүүлэх, хяналт тавих, дүгнэлт зөвлөмж гаргах үүрэг бүхий аж үйлдвэрийн бодлогын зөвлөлийг мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцуулан байгуулах	13.8	V	29.5	IX	23.2	
10	Хүнд аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагааг шинжлэх ухааны байгууллагууд, их дээд сургууль, мэргэжил сургалтын төв, зохион бүтээх үүсгэл санаачлагын бүтцүүдтэй нягт уялдуулах замаар үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлж, төсвийн хөрөнгөөр дэмжих	13	VI	26.3	X	21	
11	Хүнд аж үйлдвэрийн дагалдах жижиг, дунд боловсруулах үйлдвэрүүдийг татвар, мөнгө, зээл, гадаад худалдаа, засгийн газрын болон төрийн өмчит том компаниудын худалдан авалтаар дэмжих	8.25	XI	21.5	XI	16.2	

Хавсралт 3. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ

№	Бодлогын зорилтууд	Салбар хооронд		МУТХУБ-2030		Нэгдсэн үр дүн	
		Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ
1	Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог сайжруулж, төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын оролцоог хангана.	24.5	I	28.6	II	26.1	I
2	Аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсронгуй болгож, эрх зүйн орчныг сайжруулна.	22.75	II	30.6	I	25.9	II
3	Үйлчилгээний чанар, стандартыг сайжруулж, жуулчдын аялах таатай орчин, аюулгүй байдлыг хангана.	21.5	IV	27	IV	23.7	III
4	Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.	23.3	III	21.6	VIII	22.6	IV
5	Жуулчин тээврийн төрөл, хүчин чадал, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг нэмэгдүүлж, аялал жуулчлалын дэд бүтцийг үе шаттай хөгжүүлнэ.	20.3	V	23	VII	21.3	V
6	Аялал жуулчлалын салбарын тогтвортой аялал жуулчлалын шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангасан аж ахуйн нэгжүүдийг төрөөс татвар, санхүү, зээлийн бодлогоор дэмжинэ.	17.5	X	24.7	V	20.4	VI
7	Хүний нөөцийн урт хугацааны бодлого төлөвлөлтийг боловсруулж, сургалт үйлдвэрлэлийн нэгдсэн тогтолцоог бий болгоно.	18.0	IX	23.6	VI	20.2	VII
8	Аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулна.	19.5	VI	21	IX	20.1	VIII
9	Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөрөнгө оруулалт, санхүүжилтийн механизмыг бий болгоно.	14.8	XII	28	III	20.0	IX
10	Мэргэжлийн удирдлага, оновчтой бүтэц, зохион байгуулалт бүхий тогтвортой институцийн тогтолцоог бий болгоно.	19.0	VII	19.6	XII	19.2	X
11	Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	16.0	XI	20.7	X	17.9	XI
12	Монгол Улсын маркетинг, сурталчилгааны цогц бодлогыг хэрэгжүүлнэ.	15.8	XII	20.2	X	17.5	XII
13	Аялал жуулчлалын статистикийн үзүүлэлт тооцох аргачлалыг сайжруулж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ.	18.8	VIII	11.6	XIII	15.9	XIII

Хавсралт 4. Худалдааны салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ

№	Бодлогын зорилтууд	Салбар хооронд		МУТХҮБ-2030		Нэгдсэн үр дүн	
		Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ
1	Худалдааны салбарын үйл ажиллагааг зохицуулах төрийн институцийн тогтолцоог бий болгох, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих	26	II	43	1	32.8	I
2	Бүсүүдэд загвар худалдааны төв, сүлжээ дэлгүүрийг бий болгож, тэдгээрийн бараа, бүтээгдэхүүнд чанар, стандартын хяналт тавих үйл ажиллагааг сайжруулах	27	I	40	3	32.2	II
3	Худалдааны салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, мэргэшлийн ур чадварт суурилсан ажлын үнэлгээг бий болгох	22	III	43	1	30.4	III
4	Гадаад болон дотоод худалдааны бие даасан хуультай болох, холбогдох журам, стандартыг боловсруулах, шинэчлэх, батлуулах, Монгол Улсын хууль тогтоомжуудыг олон улсын гэрээ, хэлэлцээрүүдтэй уялдуулах	20	IV	42	2	28.8	IV
5	Худалдааны салбарыг ложистикийн стандартын шаардлага хангасан лаборатори, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах	22	III	29	6	24.8	V
6	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, үндэсний хэмжээнд мэдээллийн нэгдсэн кодчлолыг олон улсын стандартад нийцүүлэх, худалдааны бүртгэл мэдээлэл, хяналт шалгалтын үйл ажиллагааг программчлах, нэгдсэн сүлжээтэй болох	18	VI	34	4	24.4	VI
7	Үндэсний үйлдвэрлэлийг тарифын болон тарифын бус зохицуулалтаар дэмжих, төрийн хяналтын байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, хяналт шалгалтын давхцлыг арилгах (гааль, мэргэжлийн хяналт, татвар, оюуны өмчийн газар, хууль сахиулах байгууллага, цагдаа, тагнуул гэх мэт)	22	III	27	7	24	VII
8	Худалдааны салбарыг хөнгөлөлттэй зээлийн бодлого, буцалтгүй тусламж, төрийн худалдан авалтаар дэмжих тогтолцоог бий болгох	19	V	31	5	23.8	VIII

9	Нийлүүлэлтийн сүлжээнд оролцогчдын (үйлдвэрлэгч, нийлүүлэгч, тээвэрлэгч, агуулах, экспортлогч, импортлогч, гаалийн байгууллага, мэргэжлийн хяналтын газар, гаалийн зуучлагч, банк, санхүү, татварын байгууллага, бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгчид) хамтын ажиллагааг бий болгож, ложистикийн зардлыг бууруулах	19	V	24	9	21	IX
10	Импортын нэг болон ижил төрлийн барааны худалдааны луйврыг (демпинг, шилжүүлэх үнэ, нөхөн төлбөрт татаас) хянах зохицуулалтын тогтолцоог бий болгох (дистрибьютерийн худалдаа, оюуны өмчийн эрхийн худалдаа)	18	VI	22	10	19.6	X
11	Худалдааны салбарын сайн засаглалын туршлагыг дэмжиж, шударга, ил тод тайлан, ёс суртахуунтай, хариуцлагатай байдлыг хэвшүүлэх	12	VII	26	8	17.6	XI

Хавсралт 5. Банкны салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ

№	Бодлогын зорилтууд	Салбар хооронд		МУТХУБ-2030		Нэгдсэн үр дүн	
		Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ
1	Олон тулгуурт санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжсэн, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн хууль эрх зүйн орчныг сайжруулна.	16	IV	24	III	19.2	I
2	Санхүүгийн салбарт мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэн, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлнэ.	20	I	13	VIII	17.2	II
3	Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулна.	17	II	16	VI	16.6	III
4	Зээлийн хүү буурах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.	5	XI	32	I	15.8	IV
5	Санхүүгийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.	14	V	16	VI	14.8	V
6	Валютын захын үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	6	X	28	II	14.8	V

7	Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийг оновчтой бүрдүүлж, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулна.	12	VIII	18	V	14.4	VII
8	Банкнаас бусад санхүүгийн салбарт дэвшилтэт мэдээллийн технологийг нэвтрүүлж, үйлчилгээний өртгийг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлнэ.	14	V	13	VIII	13.6	VIII
9	Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллага болон холбоодод шилжүүлэх замаар мэргэжлийн холбоодын чадавхыг нэмэгдүүлнэ.	17	II	5	XI	12.2	IX
10	Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх, сурталчлах ажлыг өргөжүүлнэ.	7	IX	20	IV	12.2	IX
11	Банк, санхүүгийн салбарт эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоог бэхжүүлнэ.	13	VII	10	X	11.8	XI

Хавсралт 6. Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ

№	Бодлогын зорилтууд	Салбар хооронд		МУТХУБ-2030		Нэгдсэн үр дүн	
		Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ
1	Ахуйн үйлчилгээний салбартай холбогдох хууль, дүрэм, журмыг сайжруулах, холбогдох хууль, дүрэм, журмуудад тухайн салбарыг тусгайлан зохицуулах заалтуудыг оруулах, шинээр бий болгох	15	I	31	I	21.4	I
2	Ахуйн үйлчилгээний салбарын хүний нөөцийн сургалтыг сайжруулж, чанартай мэргэжлийн боловсон хүчин бэлтгэж ажиллуулах	10	V	27	II	16.8	II
3	Үйлчилгээний стандартыг боловсруулж мөрдүүлэх	11	IV	22	III	15.4	III
4	Ахуйн үйлчилгээний салбарын үйл ажиллагааг зохицуулж буй институцийг оновчтой болгох, сайн засаглалыг бий болгох	14	II	15	V	14.4	IV
5	Үйлчилгээний маркетинг, менежментийг сайжруулж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	10	V	17	IV	12.8	V
6	Ахуйн үйлчилгээний салбарын үйлчилгээ явуулах дэд бүтэц бүхий цогцолбор төвүүдийг байгуулж, байрны чанар, хангамжийг дээшлүүлэх	11	IV	14	VI	12.2	VI

7	Ахуйн үйлчилгээний салбарын нийгэм, эдийн засаг, техник, технологи болон бодлогын судалгаа, шинжилгээний хүчин чадлыг бий болгох	12	III	7	IX	10	VII
8	Санхүүжилтийн боломжуудыг өргөсгөх, зээлийн хүү болон нөхцөлийг сайжруулах	8	VI	12	VII	9.6	VIII
9	Ахуйн үйлчилгээний салбарын ангиллаар статистикийн мэдээллийг бэлтгэн гаргах	11	IV	6	X	9	IX
10	Түүхий эдийн чанар, стандартыг олон улсын жишигт нийцүүлэн бий болгож мөрдүүлэх	6	VII	10	VIII	7.6	X

Хавсралт 7. Төрийн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ

№	Бодлогын зорилтууд	Салбар хооронд		МУТХУБ-2030		Нэгдсэн үр дүн	
		Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ
1	Хууль эрх зүйн орчныг судалгаанд үндэслэн боловсронгуй болгож, хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.	17	I	59.5	I	34	I
2	Төрийн дэмжлэг, зээл тусламжийн хөрөнгийг оновчтой хуваарилах, үр ашигтай зарцуулж буй байдалд хяналт тавих механизмыг бий болгоно.	15.5	III	56	II	31.7	II
3	Ур чадвартай мэргэшсэн боловсон хүчнийг цалин, хангамжийг нэмэгдүүлэх замаар бүрдүүлж, тогтвортой ажиллах нөхцөл, боломжийг бий болгоно.	14.5	IV	50	III	28.7	III
4	Экспорт, импортын бараа бүтээгдэхүүний үнэ, чанарт хяналт тавих, зохицуулах төрийн бүтцийг боловсронгуй болгоно.	17	I	40	V	26.2	IV
5	Хүрээлэн буй орчин, хүн амын эрүүл мэндэд ээлтэй, сөрөг нөлөөгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдаалж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг төрийн бодлогоор урамшуулан дэмжих замаар хүн амын аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	9	VII	49	IV	25	V
6	Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох системийг хөгжүүлэх замаар иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх боломжийг бүрдүүлнэ.	11	VI	37	VIII	21.4	VI
7	Худалдаа, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлийг төрөлжүүлж, стандартын түвшинг дээшлүүлнэ.	9	VII	40	V	21.4	VI

8	Дотоодын үйлдвэрлэлийг гаалийн тариф болон тарифын бус зохицуулалтаар дэмжинэ.	8.5	IX	39	VII	20.7	VIII
9	Албан бус эдийн засгийн салбарт хөдөлмөр эрхлэгчдийг албан секторт хамруулан бүртгэлжүүлж, албан секторт шилжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	12	V	22	IX	16	IX

Хавсралт 8. Барилга угсралт, нийтийн орон сууцны дэд салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ

№	Бодлогын зорилтууд	Салбар хооронд		МУТХҮБ-2030		Нэгдсэн үр дүн	
		Оноо	Эрэмбэ 60%	Оноо	Эрэмбэ 40%	Оноо	Эрэмбэ
1	Барилгын салбарын ойрын болон дунд хугацааны хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг бий болгож хэрэгжүүлэх, хянах институцийн удирдлагыг шинэчлэх, олон улсын жишигт нийцсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хянах тогтолцоог бий болгох	26	I	41	II	32	I
2	Шинэчлэгдсэн Барилгын тухай хуулийг дагалдсан барилгын норм, стандартууд, дүрэм, журмын шинэчлэлтийг хийж, ОСНААҮ-ний байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулийг боловсронгуй болгох, ажилчдад өндөр цалин өгөх боломжийг бүрдүүлэх хууль, тогтоомжийг тогтвортой мөрдүүлэх, зөвлөх ажил үйлчилгээний хуультай болох	22	II	40	III	29.2	II
3	Түүхий эд, материалын нөөц хангалттай нөхцөлд импортын материалыг хязгаарлах, Монголд үйлдвэрлэсэн материалыг ашиглахыг дэмжих	19	IV	45	I	29.4	III
4	Барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг хангах хяналтын тогтолцоог боловсронгуй болгох	21	III	37	IV	27.4	IV
5	Барилга угсралтын ажлыг хот төлөвлөлттэй уялдуулах замаар барилгын гадна дэд бүтэц, инженерийн байгууламжийг цогцоор нь хонгилын системд шилжүүлэх, тоног төхөөрөмж, угсралтын стандартыг боловсронгуй болгож ухаалаг технологи руу шилжүүлэх	19	IV	37	IV	26.2	V

6	Салбарын эрдэм шинжилгээ, судалгааны төв байгуулах, боловсон хүчний ур чадварыг нэмэгдүүлэх						VI
7	Төсвийн хөрөнгө оруулалтын барилгын төслийг хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, ингэхдээ хүлээх хариуцлагын тогтолцоог бий болгох	16	VIII	36	VI	24	VI
8	Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудад тавих хяналт, үнэлгээний тогтолцоо бий болгох, барилгын төсөв, үнэ бүрдүүлэлт, хяналтын тогтолцоог шинэчлэх	18	VI	32	IX	23.6	VII
9	Салбарын эрдэм шинжилгээ, судалгааны төв байгуулах	16	VIII	35	VII	23.6	VII
10	Барилгын үйлдвэрлэлийн процессын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, барилгын компаниудын үйл ажиллагаанд зэрэглэл тогтоох, үнэлэх тогтолцоог бий болгох, тусгай зөвшөөрөл олгох шалгуурыг оновчтой болгох	17	VII	32	IX	23	IX
11	Барилгын салбарын төрийн захиргааны төв байгууллагын газар, хэлтсийн удирдлагын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, салбарын хүний нөөцийг сургах, мэргэшүүлэх тогтолцоог бий болгож, мэргэжлийн зөвлөх үйлчилгээг цэгцлэх, ёс суртахууныг дээшлүүлэх, гаднаас авч буй ажиллах хүчийг хязгаарлах	13	XII	34	VIII	21.4	X
12	Барилга, ОСНААҮ-ний байгууллагуудад хөрөнгө оруулалт, зээл, санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалтын даатгалын тогтолцоог бий болгох	15	XI	29	XI	20.6	XI
13	Барилгын салбар дахь төрийн оролцоог багасгах, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлэх тогтолцоог бий болгох, хүнд суртлыг арилгах, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага (ТББ)-ын үйл ажиллагааны уялдааг хангах	16	VIII	23	XII	18.8	XII

Хавсралт 9. Барилга, хот байгуулалт, зураг төсөл төлөвлөлтийн дэд салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ

№	Бодлогын зорилтууд	Салбар хооронд		МУТХУБ-2030		Нэгдсэн үр дүн	
		Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ
1	Хот байгуулалтын тухай суурь хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн салбарын бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.	21	I	44	I	30.2	I
2	Барилгын салбарын хөгжилд шаардлагатай инженер, техникийн ажилтан, мэргэжлийн ажилчдыг төлөвлөгөө, системтэйгээр бэлтгэн, ахин дэвших зарчмаар ажиллуулна.	17	II	31	VI	22.6	II
3	Үндэсний орон зайн мэдээллийн санг байгуулж, улсын хэмжээнд ашиглана.	14	V	33	IV	21.6	III
4	УИХ-ын 1996 оны 38-р тогтоолоор батлагдсан Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг цаг үеийн шаардлагад нийцүүлнэ.	14	V	32	V	21.2	IV
5	Салбарын аж ахуйн нэгжүүдэд мэргэжлийн хүчин чадлаар нь зэрэглэл тогтоож, ажлын гүйцэтгэлийн чанар, үр дүнгээр үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ.	14	V	31	VI	20.8	V
6	Зураг төсөл, инженер хайгуул, судалгааны ажлын чанар, үр дүнд хийх магадлалын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангана.	17	II	26	VIII	20.6	VI
7	УИХ тухайн оны төсвийн тухай хуульд хөрөнгө оруулалтын хөтөлбөр, санхүүжилтийн дүнг оруулахдаа, Засгийн газар түүнийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр батлахдаа татвар төлөгчдийн мэргэжлийн төлөөллөөр хянуулдаг механизм бүрдүүлнэ.	8	IX	38	II	20	VII
8	Барилгын ажлын үе шатуудад мэргэжлийн зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, оролцогч талуудын хариуцлагыг дээшлүүлнэ.	15	IV	25	X	19	VIII
9	Ногоон хөгжлийн бодлогыг хот байгуулалтын салбарт дэмжиж ажиллана.	8	IX	35	III	18.8	IX
10	Барилгын салбарын эрдэм шинжилгээ, хайгуул-судалгаа, ТЭЗҮ, зураг төсөл, норм норматив боловсруулах, магадлал хийх оюуны бүтээлийн үнэлэмжийг дээшлүүлнэ.	12	VIII	26	VIII	17.6	X

Хавсралт 10. Барилгын материалын үйлдвэрлэлийн дэд салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ

№	Бодлогын зорилт	Салбар хооронд		МУТХУБ-2030		Нэгдсэн үр дүн	
		Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ
1	Салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх нэгдсэн бодлого боловсруулж, давтан сургах тогтолцоог хөгжүүлж, салбарыг мэргэжлийн удирдлагаар хангана.	12	III	28	I	18.4	I
2	Барилгын материалын үйлдвэрлэлийн бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлж, судалгаа шинжилгээний нэгжийг бий болгоно.	20	I	15	IV	18	II
3	Барилгын материалын ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.	11	IV	23	II	15.8	III
4	Барилгын материалын үйлдвэрлэлтэй холбогдох хууль, дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгох замаар салбарын бодлого зохицуулалтыг сайжруулна.	16	II	12	VII	14.4	IV
5	Орон нутгийн түүхий эдийн нөөцөд тулгуурлан барилгын материалын үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлнэ.	7	VII	22	III	13	V
6	Барилгын материалын чанарт шинжилгээ хийх лавлагаа лабораторийн сүлжээг бий болгоно.	10	V	13	VI	11.2	VI
7	Гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	8	VI	11	VIII	9.2	VII
8	Барилгын салбарын цалин хөлсний тариф, хөдөлмөрийн норм, нормативыг шинэчлэн тогтооно.	4	IX	14	V	8	VIII
9	Барилгын материалын чанар, стандартад тавих хяналт шалгалт, баталгаажуулалтыг сайжруулна.	4	VIII	10	IX	6.4	IX
10	Барилгын материалын мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.	3	X	7	X	4.6	X
11	Барилгын материалын үйлдвэрлэлийн улирлын хамаарлыг бууруулна.	4	X	1	XI	2.8	XI

Хавсралт 11. Арьс ширний салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ

№	Зорилтууд	Салбар хооронд		МУТХУБ-2030		Нэгдсэн үр дүн	
		Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ
1	Засаглал, институцийн тогтолцоог сайжруулах	24.8	I	29.3	II	26.6	I
2	Аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн хэсгийн санхүүжилтийг шийдэх	24.2	II	17.3	VI	21.4	II
3	Хууль, дүрэм, журмыг сайжруулах, шинээр бий болгох	15.4	III	30.3	I	21.3	III
4	Бүтээгдэхүүний стандартыг шинэчлэн тогтоох	14.8	V	17.7	V	15.9	VI
5	Мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог бий болгох	13	VI	19.7	IV	15.6	IV
6	Хөнгөлөлттэй зээлийн хугацааг уртасгах	15.4	III	14.7	VIII	15.1	V
7	Салбарын эрдэм шинжилгээний байгууллагыг үүсгэж, үйл ажиллагааг нь төрөөс дэмжих	10.2	VII	21.7	III	14.8	VII
8	Түүхий эдийн чанарыг дээшлүүлэх	10.2	VII	12	IX	10.9	VIII
9	Экспортыг дэмжих, импортыг хязгаарлах	7.5	X	16	VII	10.9	IX
10	Статистик мэдээ бэлтгэх арга, аргачлалыг сайжруулж, мэдээллийн нэгдсэн санг бий болгох	9.1	IX	10	X	9.4	X
11	Дотоодод эх оронч худалдан авалтыг төлөвшүүлэх	6.4	XI	9.7	XI	7.7	XI

Хавсралт 12. Ноос, ноосон эдлэл, ноосон үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ

№	Бодлогын зорилтууд	Салбар хооронд		МУТХУБ-2030		Нэгдсэн үр дүн	
		Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ
1	Түүхий эдийн нөөцөө бүрэн ашиглаж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэх талаарх төрийн бодлого, хууль эрх зүйн орчныг оновчтой болгож, хэрэгжилтийг хангуулна.	24	I	42	II	31.2	I
2	Гарц, шинж чанарын үзүүлэлтээрээ олон улсын чанар, стандартын шаардлагад нийцсэн түүхий эд бүхий үүлдэр угсааны малыг өсгөж, бэлчээр, тэжээлээр хангах бүс нутаг, засаг захиргааны хуваарийг бий болгоно.	17	II	42	II	27	II

3	Орчин үеийн техник, технологийг удирдах, эзэмших чадвар бүхий мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх бодлогыг оновчтой болгож, үйлдвэрлэлд тогтвортой ажиллах цалин хангамж, нийгмийн асуудлыг цогцоор шийдвэрлэнэ.	11	X	43	I	23.8	III
4	Түүхий эд бэлтгэлийн системийг шинэчлэн тогтоох, эрүүл ахуйн шаардлага хангасан малын ноосыг хяргах, савлах, баглах, хадгалах, тээвэрлэх, үйлчилгээний мэргэшсэн, төрөлжсөн байгууллагуудыг бий болгон, хөдөлмөр хөнгөвчлөх, бүтээмж дээшлүүлэх арга хэмжээ авч, чанар, өртөг зардлын норматив, стандартуудыг тогтооно.	17	II	32	V	23	IV
5	Ногоон үйлдвэрлэлийн стандартад нийцсэн, байгаль орчинд халгүй, хаягдалгүй, үр ашигтай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай химийн бодис, урвалжийг хянах, саармагжуулах, дахин ашиглах системийг бий болгож, төр орон нутгийн санхүүжилтээр дэмжинэ.	11	X	39	IV	22.2	V
6	Ноосон эдлэлийн экспорт, импортыг орлох бүтээгдэхүүний эдийн засагт оруулж байгаа орлогын өсөлтөөс салбарын санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгцээг урамшуулдаг механизмыг тогтооно.	13	VI	32	V	20.6	VI
7	Ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлд техник, технологийн шинэчлэл хийхэд оруулсан хөрөнгө оруулалтыг урт хугацааны зээл, үнэ тариф, татварын ялгавартай бодлогоор дэмжиж, дотоодын зах зээлийг хамгаална.	13	VI	32	V	20.6	VII
8	Дотоодын ноосон эдлэлийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжиж, ард иргэдийн худалдан авалтыг нэмэгдүүлнэ.	14	IV	29	VIII	20	VIII
9	Экспортын баримжаатай инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжихийн тулд туршилт судалгааны төвд тулгуурласан олон улсын итгэмжлэгдсэн лаборатори байгуулна.	13	VI	27	IX	18.6	IX
10	Ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлд оролцогч бүх субъектүүдийн уялдаа холбоо, үүрэг хариуцлагыг хангасан институцийн үр ашигтай тогтолцоо, удирдлага зохион байгуулалтын оновчтой бүтцийг бүрдүүлнэ.	13	VI	26	X	18.2	X

11	Түүхий эд бэлтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспорт, импортын бүтээгдэхүүний худалдан авалтын статистик тоо баримт, бүртгэл тооцооны үнэн зөв, хариуцлагатай мэдээллийн нэгдсэн системтэй болж, улс орны эдийн засгийн үзүүлэлтүүдэд тусгана.	14	IV	23	XI	17.6	XI
----	---	----	----	----	----	------	----

Хавсралт 13. Ноолуур, ноолууран эдлэл, ноолууран нэхмэлийн үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ

№	Бодлогын зорилтууд	Салбар хооронд		МУТХҮБ-2030		Нэгдсэн үр дүн	
		Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ
1	Ноолуурын салбарт тогтвортой урт хугацааны бодлого явуулж, бодлогын залгамж чанарыг хангах	24	I	23	I	23.6	I
2	Ноолуурын салбарт татварын таатай, тогтвортой эрх зүйн орчныг бүрдүүлэх, ялангуяа түүхий эд бэлтгэгчдийг НӨАТ-т хамруулах, үйлдвэрлэлийн зориулалттай хагас боловсруулсан бүтээгдэхүүнд НӨАТ оногдуулахгүй байх, түүхий эдээ тушаасан тохиолдолд урамшууллыг НӨАТ-ын буцаан олголтоор олгох	19	II	5	IX	13.4	II
3	Технологийн паркийн хүрээнд эрдэм шинжилгээ, судалгаа хосолсон цогцолбор үйлдвэрийг байгуулах, ээрэх, гүйцэтгэн боловсруулах техник технологид оруулах хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжих	16	III	7	VII	12.4	III
4	Ногоон хөгжлийн бодлогод нийцүүлэн байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих	11	IV	14	II	12.2	IV
5	Ноолуурын салбарын хүний нөөцийг, ялангуяа инженер, техникийн ажилтнууд, нарийн мэргэжлийн ажилчдыг олноор нь бэлтгэх, тэдгээрийн ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, давтан сургах, тогтвортой ажиллуулах урамшууллын тогтолцоог хөгжүүлэх	6	VI	13	III	8.8	V
6	Экспортод гаргах шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг олшруулж, бүтээгдэхүүний загвар, дизайныг хөгжүүлэх	11	IV	4	X	8.2	VI
7	Ноос, ноолууран эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор үйлдвэрлэлийн дэд бүтцийн таатай орчныг бүрдүүлэх	4	VII	12	IV	7.2	VII
8	Хөнгөн үйлдвэрийн салбарын кластерын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих	6	VI	8	VI	6.8	VIII

9	Борлуулалт, маркетингийн цогц арга хэмжээг хөгжүүлэх	9	V	2	XI	6.2	IX
10	Ноолуурыг чанараар нь ангилах бэлтгэн нийлүүлэлтийн болон түүхий эдийн чанарт нийцсэн үнэлгээний систем бий болгох, урамшууллын тогтолцоог шинэчлэн сайжруулах	6	VI	6	VIII	6	X
11	Олон улсын зах зээлд ноолууран бүтээгдэхүүнийг таниулах, сурталчлах зорилготой үзэсгэлэн, бизнес форумд оролцох, зохион байгуулах	3	VIII	10	V	5.8	XI
12	Дотоодын зах зээлийг хамгаалах зорилгоор Монголд үйлдвэрлэдэг ижил төрлийн бүтээгдэхүүний импортын гаалийн татварыг Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-тай байгуулсан гэрээнд заагдсан хүрээнд нэмэгдүүлж, туслах материалд импортын татварын хөнгөлөлт үзүүлэх	3	VIII	6	VIII	4.2	XII
13	Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг ноолуурын үйлдвэрүүдэд түүхий эдээ цаг хугацаанд нь худалдан авах эргэлтийн хөрөнгийг бүрдүүлэхэд нь төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох механизмыг бий болгох.	4	VII	4	X	4	XIII
14	Угаасан ноолуурын экспортод ногдуулах татварыг ДХБ-тай тохиролцон дээд түвшинд хүргэн нэмэгдүүлэх, тарифын бус хязгаарлалтуудыг тогтоох замаар дотоодын үйлдвэрүүдийн түүхий эдийн нөөцийг нэмэгдүүлэх	2	IX	5	IX	3.2	XIV

Хавсралт 14. Оёдлын үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ

№	Бодлогын зорилтууд	Салбар хооронд		МУТХҮБ-2030		Нэгдсэн үр дүн	
		Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ
1	Оёдлын үйлдвэрүүдийг үйлдвэрлэл, технологийн паркаар хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	22	I	24	I	22.8	I
2	Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, салбарын шинэ технологи, инновацийн хөгжлийг бодлогоор дэмжинэ.	20	III	21	III	20.4	II
3	Салбарын хөгжилд шаардагдах дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх болон нутагшуулахад дэмжлэг үзүүлнэ.	17	VI	23	II	19.4	III

4	Хувцас үйлдвэрлэлийн салбарыг дэмжсэн, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, боловсронгуй болгоно.	21	II	15	IX	18.6	IV
5	Үндэсний үйлдвэрлэлийг төрийн болон дотоодын худалдан авалт, санхүү зээлийн бодлогоор дэмжих тусгай сан байгуулна.	19	IV	17	VI	18.2	V
6	Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлж, төрөөс дэмжинэ.	15	IX	17	VI	15.8	VI
7	Дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний борлуулалт болон түүхий эд материалын бэлтгэн нийлүүлэлтийг үе шаттай дэмжинэ.	12	X	21	III	15.6	VII
8	Салбарын хөгжлийг дэмжсэн эрдэм шинжилгээ, судалгааны лаборатори, хүрээлэн байгуулна.	16	VIII	14	X	15.2	VIII
9	Салбарын хөгжилд чиглэсэн, төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдааг хангасан институцийн тогтолцоог бүрдүүлнэ.	17	VI	12	XI	15	IX
10	Салбарын ажиллах хүчний хэрэгцээ, шаардлагад нийцсэн боловсон хүчин бэлтгэх цогц арга хэмжээ авна.	12	X	19	V	14.8	X
11	Хувцас үйлдвэрлэлийн салбарын стандартуудыг бий болгон, шинэчилж, бараа бүтээгдэхүүний нэр томъёоны нэгдсэн ойлголттой болно.	19	IV	7	XII	14.2	XI
12	Үйлдвэрлэлийн хог хаягдлыг дахин боловсруулж, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.	4	XII	16	VIII	8.8	XII

Хавсралт 15. Ой мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын эрэмбэ

№	Бодлогын зорилтууд	Салбар хооронд		МУТХҮБ-2030		Нэгдсэн үр дүн	
		Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ	Оноо	Эрэмбэ
1	Ой мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаарх төрийн бодлого, зохицуулалт, хууль, эрх зүй, дүрэм, журмын зохицуулалтыг сайжруулах /НӨАТ, нийгмийн даатгалын шимтгэл, татвар, импортын татвар, татаас, хөнгөлөлт г.м/	16.7	II	49.2	I	29.7	I
2	Ой мод, модон бүтээгдэхүүний салбарын удирдлага, тогтолцоо, зохион байгуулалтыг сайжруулах, түүний чиг үүргийн талаарх төр ба төрийн бус байгууллагуудын уялдааг хангах	15.5	VII	41.3	II	25.8	II

3	Ой модны салбарын хүний нөөц, ажиллах хүчний хүрэлцээ, боловсон хүчний хөгжил, мэргэжлийн сургалт, ур чадварыг дээшлүүлэх	18.5	I	34.7	VI	25	III
4	Ой мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн санхүүжилтийн асуудал, хөрөнгө оруулалт, банкны зээлийн үйлчилгээг сайжруулах	16.3	VI	35.2	V	23.9	IV
5	Ой мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн /эрчим хүч, зам тээвэр/ экологи, кластер болон цогцолборыг байгуулах	15.3	X	36.3	III	23.7	V
